



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-64

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	8-37
2. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	37-42
3. “Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	42-60
4. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	60-64

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ц.Баатархүү, Ж.Баярмаа, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, А.Ундраа;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Б.Батцэцэг, П.Батчимэг, Х.Болормаа, Л.Гантөмөр, Н.Наранбаатар;

Тасалсан: С.Одонтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Н.Алтаншагай-18 минут, С.Амарсайхан-1 цаг 49 минут, Б.Батбаатар-50 минут, Ж.Батсуурь-13 минут, Э.Батшугар-05 минут, Ж.Баясгалан-07 минут, Б.Бейсен-07 минут, Х.Булгантуяа-03 минут, Д.Бум-Очир-24 минут, Ш.Бямбасүрэн-18 минут, Ж.Галбадрах-1 цаг 36 минут, А.Ганбаатар-1 цаг 10 минут, Г.Ганбаатар-07 минут, С.Ганбаатар-1 цаг 02 минут, Д.Ганбат-06 минут, Ц.Даваасүрэн-07 минут, Т.Доржханд-2 цаг 06 минут, Б.Дэлгэрсайхан-1 цаг 23 минут, Б.Жавхлан-1 цаг 50 минут, Б.Жаргалан-32 минут, Л.Мөнхбаатар-02 минут, П.Мөнхтулга-14 минут, З.Мэндсайхан-12 минут, П.Наранбаяр-01 минут, О.Номинчимэг-04 минут, Э.Одбаяр-32 минут, Б.Пунсалмаа-34 минут, Р.Сэддорж-1 цаг 07 минут, Б.Түвшин-04 минут, Ч.Ундрам-17 минут, Н.Учрал-15 минут, Г.Уянгахишиг-2 цаг 09 минут, Б.Хэрлэн-05 минут, Б.Чойжилсүрэн-02 минут, Ж.Энхбаяр-1 цаг 43 минут, С.Эрдэнэбат-11 минут.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, М.Энхцэцэг, Ж.Алдаржавхлан, Д.Пүрэвдаваа, М.Мандхай, С.Цэнгүүн, О.Саранчулуун, Б.Заяабал, Х.Булгантуяа, Б.Бейсен, Ж.Баясгалан, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Тогтоолын төслийн хавсралтын 3.1 дэх хэсгийн “тавигдах шаардлага” гэснийг “тавих шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	33
Бүгд:	104

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Баттогтох, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн танилцуулав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.14 дэх “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” төсөл арга хэмжээ нь мөн хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалтад байгаа төсөл, арга хэмжээтэй, агуулга, шалгуур үзүүлэлтийн хувьд давхцаж байгаа тул уг саналыг төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалттай нэгтгэж, Зорилтот түвшин “30” гэснийг “100” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “17,500.00” тэрбум гэснийг “28,500.00” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Г.Лувсанжамц нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	35

Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 34
Бүгд: 106
67.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 12 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Гурав. “Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ж.Батжаргал, М.Энхцэцэг, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Б.Уянга нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Хэлэлцэж байгаа асуудал дээр техникийн илэрхий алдаа гарсан учраас уг алдааг засаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан ёсоор бичиг ирсний дараа үргэлжлүүлэн хэлэлцэхээр уг асуудлыг хойшлуулав. /15.09/

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт Б.Золбоо, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.18 дугаар зүйлийн гарчгийн “тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “тоглоом зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 52
Бүгд: 108
51.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.19 дүгээр зүйлийн “зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд” гэснийг “зохион байгуулахад” гэж, “ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн” гэснийг “ашиглуулсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 50
Бүгд: 108
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 29 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая 2025 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. 67 гишүүн бүртгэгдэж, ирц 53,2 хувьтай байна. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэхээр байна.

1 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн бичиг баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших хуралдаанаар “Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

4 дүгээрт Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 он оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урья. Энэ сайд нарыг орж ирэхийг зарлаарай. Ажлын хэсгийг танилцуулж байя.

Гантөмөр сайд, Жавхлан сайд 2-ыг дуудаарай. Дэлгэрсайхан сайд, Равсалын Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга,

Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Батшугар гишүүн 4 минут хоцорлоо. Жадамбаагийн Баясгалан гишүүн индэрт урьж байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн уншъя.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу дээрх хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үеэр тогтоолын төслийн хавсралтын 3.1 дэх хэсгийн “тавигдах шаардлага” гэснийг “тавих шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулж” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд ДНБ-ий бодит өсөлтийг 2026 онд 6 хувь, 2027-2028 онд 6,5 хувь байх, хэрэглээний өсөлтийн түвшнийг 2026 онд 7 хувь, 2027 онд 6,4 хувь, 2028 онд 6 хувь хүргэхээр тооцсон. Мөн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-2028 онд алдагдалгүй байхаар тооцож, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2026 онд 50 хувь, 2027-2028 онд 45 хувьтай тэнцэхээр байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Уг нь Жадамбаагийн Энхбаяр сайд байсан бол зүгээр байсан юм. Тэгэхээр малын эрүүл мэндийн тухай асуудал их чухал байгаад байгаа юм. Бид нар малаа эрүүл байлгаж байж экспортолно. Гэтэл хувийн мал эмнэлэгт даатгачихаар бас тэр хувийн мал эмнэлгийг тухайн сумын Засаг дарга болон удирдлагууд нь шууд захирч асуудлаа шийдвэрлэж чадахгүй. Тэрнээс нь болоод нөгөө хүмүүс нь жоохон ажил муутай байвал ямар ч тарилга хийдэггүй. Тэгээд сүүлдээ хүмүүс нь өөрсдөө тарилга хийдэг иймэрхүү нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр сум дээр баг болгоныг хувийн хэвшилд даатгасан боловч харамсалтай нь малын эрүүлжүүлэх бодлогод бол сайн нийцэж чадахгүй байна. Тийм учраас тодорхой бас энэ төрийн бас тодорхой чиг үүргээр хариуцлагажуулж ажил хийх тийм баг болгон дээр эмч тавих асуудлыг бас төсөвт суулгах ийм зайлшгүй шаардлага байна.

Дээрээс нь малын эмчийг авна гэхээр төрийн албаны шалгалт авдаг. Тэгээд сум дээр 6 удаа төрийн албаны шалгалтад орчихсон хүн байна шүү дээ. Үгүй ээ, тэр мал тарих тарихад өөрийнхөө мэдсэн тэр мэргэжлээ сайн мэдэж байвал тэр хүнээс заавал бүр Эрүүгийн хуулийн тэд дүгээр заалтад юу байгаа вэ гэж асууж, тэр хүмүүсийг шалгалтад унагааж байхын оронд тэр хүмүүст зориулаад тусгай арга хэмжээ, хөтөлбөр зохион байгуулаад, Төрийн албаны зөвлөлтэй зохион байгуулж байгаад илүү хялбараар өөрийнх нь яг мэддэг тэр сэдвийнх нь хүрээнд төрийн албаныхан шалгалт авхуулаад, тэгээд тэр малын эмчээ томилох тэр арга хэмжээг хийхгүй бол ерөөсөө сум дээр тэр чинь ихэнх нь сайн сургуулиудад бол өндөр оноотой хүүхдүүд нь яваад өгч байна. Тэгээд сүүлийн үеийн малын эмчээр төгсөж байгаа хүмүүс тийм өндөр сайн мэдлэгтэй хүмүүс очихгүй байгаа шүү дээ. Тийм учраас бас тодорхой хэмжээгээр нэг хэсэг нь төрийн албаны шалгалтдаа тэнцэж чадахгүй, тэгээд хөдөө орон нутагт малын эмчийн хэрэгцээ шаардлага маш их байгаад байдаг. Тэгээд томилогдож чаддаггүй ийм нөхцөл байдалтай байгаад байна. Тийм учраас энэ Төрийн албаны зөвлөл, Хүнс, хөдөө аж ахуйн яам Энхбаяр сайд та нар бүгдээрээ нийлж байгаад энэ төрийн албаны шалгалтыг арай хялбаршуулаад, өөрөөр хэлбэл тэд нар чинь хаана малаа яаж тарих вэ, ямар туулга, эм өгөх үү гэдгээ бүгдийг нь сайн мэдэж байгаа шүү дээ. Өөрийнхөө мэргэжилдээ бол сайн л байгаа. Тэгээд тэр хүмүүсийг илүү хурдтай томилох энэ ажилд нь оруулах тэр ажлуудыг хийхгүй бол энэ хөдөөгүүр мал эмнэлгийн үйл ажиллагаа, малын эрүүл мэндийн үйл ажиллагаа бол маш хүнд нөхцөл байдал руу орж байна.

Тун удахгүй бид нар бас энэ хүйтэн орон руу мах экспортлох энэ ажлууд эрчимжинэ. Энэ тохиолдолд бид нарын мал эрүүл байж байх ёстой. Бид нар даруй 1 доллароор илүү өндөр үнэтэйгээр махаа зарах боломж энэ намраар эхлээд бий болно. Энэ тохиолдолд бид нарт бас тодорхой хэмжээний бэлтгэл ажил маш чухал байна. Тэгээд энэ дээрээ бас Хүнс, хөдөө аж ахуйн яам, Төрийн албаны зөвлөл 2

хамтраад жаахан ажил хийгээдхээч. Тэгээд л хүмүүсийг яаж л чангалах, яавал ажилд оруулахгүй байх уу л гэдэг ийм л төрийн албаны хуультай. Тэгээд тэр нэг малын эмчийг томилохын тулд Удирдлагын академид заавал сур гэнэ. Тэр мал удирдахад Удирдлагын академи ямар хамаа байна. Ийм хачин заваан хуулиудыг энэ хугацаанд зөвхөн МАН-ын гишүүддээ зориулаад хийчихсэн. Тэд нар л тэнцдэг. Ийм л хууль зүйн орчныг бий болгочихсон. Тэрнээс нь болоод иргэдийн амьдрал, бодит аж амьдрал дээр явж байгаа тэр хүмүүсийн ажил төрөл ерөөсөө явахгүй байна шүү дээ. Ийм юмнуудаа бүгдийг нь хөнгөлөөд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би түрүүний чуулган дээр хариулт авч чадаагүй 2 асуултаа асууя гэж бодож байна. Яагаад гэхээр өнөөдөр харьцангуй сайд нар маань энд сууж байгаа учраас.

1 дүгээр асуулт болохоор би түрүүний чуулган дээр мөн асуусан байгаа. 2026 оны хөгжлийн хөтөлбөр дээр 2025 оны Монгол Улсыг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр дээр байсан, хийж амжаагүй ажлууд маань автоматаар 2026 оныхоо хөгжлийн төлөвлөгөө дээр ороод явдаггүй юм уу. Яагаад гэхээр эрчим хүчний салбарт 2025 оны төлөвлөгөө дээр 35 ажил байгаа. Тэгэхээр энэ 35 ажлаас нэлээд олон ажлууд бол ерөнхийдөө хийгдэж эхлээгүй байгаа гэж би ойлгож байгаа. Тэгэхээр энэ ажлууд маань бол энэ 2026 оны төлөвлөгөө дээр бол ерөөсөө ор тас орж ирээгүй байсан. Тухайлбал 1 дүгээрт нь ДЦС-ыг 500 тонн/цагаар өргөтгөнө гэсэн энэ ажил бол маш чухал ажил байгаа. Яагаад гэхээр өнөөдөр бид нар маш олон хэрэглэгчийг цахилгаанаар хангаж чадахгүй. ТЭЦ-4-ийн өргөтгөлийг хийснээр нэлээн олон айлуудыг, өвлийг хэрэглэгчээ тасалдаг энэ асуудал байхгүй болно. Тэгээд энэ чухам яагаад хасагдчихсан юм бол.

2 дугаарт нь болохоор Архангай, Өвөрхангай, Баянхонгор гээд 3 аймгийн хувьд бол цахилгаан хангамжийн хувьд маш найдваргүй байдалд байдаг. Яагаад гэвэл хаа байсан Эрдэнэтээс маш насжилт өндөртэй, 110 киловольтын урт шугамаар тэжээгддэг. Тэгээд тэр шугам дээр засвар орох, тэр шугам дээр тулгуур унахад бол энэ 3 аймаг цахилгаангүй болдог. Энэ асуудал өвлийн улиралд тохиолдвол энэ 3 аймаг хэдэн 10 сум хөлдөх хэмжээнд хүрнэ. Дээрээс нь энэ ажил бол улсын төсвөөр биш хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх ажил 2025 оны төлөвлөгөө дээр байсан. Эрчим хүчний яамны хувьд техникийнхээ шаардлагыг гаргаад, тэр тендерээ зарлаад эсвэл тэр дуудлага худалдаагаа зарлаад тэр хувийн хөрөнгө оруулалтыг татаад энэ ажлуудыг хийх ёстой байсан. 2025 онд хийгээгүй байгаа. Тэгэхээр яахаараа 2026 оны төлөвлөгөөнд орж ирдэггүй юм бол гэсэн ийм асуулт байгаа.

2 дугаар асуулт болохоор мөн энэ 2026 оны хөгжлийн хөтөлбөр хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэж байгаа. Тэр хөтөлбөр дээр байгаа ажлуудыг энэ 2026 оны төлөвлөгөөндөө тусгаж орж ирдэггүй юм уу. Яагаад гэхээр энэ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бид олон ажлуудыг хийж өгнө гэж амласан байдаг. Тухайлбал, 1 ажил бол нөгөө айл өрхүүд, аж ахуйн нэгжүүд нарны панел, батарейгаар өөрийнхөө хэрэглээг хангаад, илүүдэл цахилгаанаа сүлжээ рүү борлуулдаг. Орлого олдог ийм боломжийг бүрдүүлье гээд бид нар амлаад, хурал болгон дээрээ ард түмэнд ингээд яриад явж байгаа. Тэгэхээр энэ рүү чиглэсэн ажил жишээ нь 2025 оны төлөвлөгөө дээр байсан бас л мөн 2026 оны төлөвлөгөө дээр энэ рүү чиглэсэн ажил байхгүй байна. Тэгэхээр энэ 2 асуултад хариулж өгөөч ээ. 2025 оны хийгдээгүй ажлууд 2026 оныхоо төлөвлөгөөнд

автоматаар орж ирдэггүй юм уу. Эсвэл энэ ажлуудыг хийхгүй гэсэн үг юм уу. 2025 он дээр жишээ нь Налайхын дулааны станцын өргөтгөл гээд л байсан. Говьсүмбэр болон Дундговь аймаг дулааны станц барина гээд л байсан. Энэ ажлууд бүгд байхгүй. Эсвэл энэ ажлууд зүгээр 2025 онд бэлгэдлийн шинж чанартай байдлаар суусан ийм ажил байсан юм уу.

3 дугаар асуулт би болохоор энийг маш сайн хэлээд байгаа юм. Энэ 2025 оны төлөвлөгөө гэдэг бол Улсын Их Хурлаар батлагдсан хууль. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэх ёстой субъект нь чухам хэн юм бэ. Эсвэл энэ хууль дээр байгаа заалтуудыг /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энхцэцэг гишүүн ээ, Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө дээр урьд нь үргэлжилж байгаа энэ ажлуудыг бол төсөв шиг үргэлжилж байгаа нь энэ, шинээр хэрэгжүүлэх нь энэ гэдэг ийм форматаар Их Хуралд өргөн мэдүүлэх ёстой юм байна л даа. Харамсалтай нь бид нар зөвхөн дандаа 2026 онд шинээр эхлүүлэх төслүүдээ суулгачихсан учраас тэр 2025 онд хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэх гэж байгаа төслүүд маань энд тусахгүй байгаа ийм хийдэл гараад байгаа юм. 2025 он 1 дүгээрт дуусаагүй байгаа. Одоо 5 сар нь дуусаж байна. Цаана нь үлдээд бас 7 орчим сар байгаа учраас Улсын Их Хурлын шийдвэр тогтоолоор баталж өгсөн энэ төлөвлөгөөг Засгийн газар бүр эцсийн мөч хүртэл, он дуустал 12 сарын 31 хүртэл хэрэгжүүлэхийн төлөө, эхлүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргах ийм л бололцоо байгаад байгаа юм.

Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн тухай та мэдэж байгаа. Эрдэнэтээс гараад Хөвсгөл ороод, Хөвсгөлөөс урагшаа яваад бараг төгсгөлдөө 1000 гаруй километр 110-ын шугамаар энэ 3 аймгийн сумууд тэжээгддэг. Эрсдэл өндөр байгаа. Тийм учраас энэ Өвөрхангай аймгийн төв дээр 100мвт-ын 4 цагаар гаргах хүчин чадалтай батарей станцыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барихаар ийм шийдвэр гаргаад явж байна. Батарей станцаа бол нарны станцаараа өөрсдөө цэнэглэх ийм нөхцөлтэй. Хөрөнгө оруулагч олдчихсон. Энэ ажил ойрын хугацаандаа эхлэх байх. Ойрын 1, 2 сарын дотор ажил эхэлчих болов уу гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдэг л /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: ДЦС-4-ийг 500 тонн/цагаар өргөтгөнө гэсэн ажил 2025 оны төлөвлөгөө дээр байсан. Тэгэхээр энэ ажил одоогоор бол эхлээгүй. Ямар нэгэн санхүүжилтийг шийдсэн асуудал байдаггүй гэж ойлгож байгаа. Гэтэл 2026 оны төлөвлөгөө дээр орж ирээгүй байсан. Энэ дээр бас хариулт өгөөч.

Баянхонгорын хувьд Арвайхээрийн хувьд тодорхой хэмжээний шийдэл явж байгаа юм байна гэж харж байна. Тэгэхээр Архангайн хувьд тэр 10мвт-ын нар 20мвт цагийн батарей дээр нь тэр дуудлага худалдаагаа зарлаад, энэ ажлыг эхлүүлчихэд юу нь болохгүй байгаа юм бол гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: ТЭЦ-4-ийн өргөтгөл 5 тонн/цагаар зуухыг нь нэмэгдүүлье, дулааны хангамжийг нэмэгдүүлье гэдэг ийм төлөвлөгөө 2025 онд суучихсан байгаа.

Бид нар хөрөнгө оруулагч нартаа энэ төслийг санал болгоод явж байна. Яг өнөөдөртөө эцэслээгүй байгаа учраас танд илтгэхэд хэцүү байна. 7 сар орчим хугацаа байгаа учраас үргэлжлүүлээд ажиллах ийм төлөвлөгөөтэй байгаа. Ганц энэ төсөл ч биш, хэд хэдэн ийм төслүүд бий. Яг энэ ажлыг хөөцөлдөөд явж байгаа дуусаагүй байхад тэгнэ, ингэнэ гээд хүмүүст худлаа мэдээлэл өгөөд баймааргүй байна. 7 сар үлдсэн учраас бас цааш үргэлжлүүлээд ажиллана.

Архангай аймаг дээр байгаа тэр батарей станцын тухай, нарны станцын тухай ч мөн ялгаагүй. Бид нар хөөцөлдөөд явж байгаа. Ажил дуусаагүй байна.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Өглөөний мэнд. Энэ чинь төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байгаа биз дээ. Хөгжлийн хөтөлбөрийн асуултууд яваад би бас толгой эргээд байна. Төсвийн хүрээний мэдэгдэл Байнгын хорооны даргаас асууж таарах юм байна. Сайд нь байхгүй юм байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдлийн тогтоолыг харахад ирэх оны төсвийн зарлага санхүүжилтийг 33,4 тэрбум 4 их наядад барина гэж тоо явж байна. Тэгэхээр энэ нь энэ жилийнхээ төсвийн зарлагаа нэмэгдүүлэхгүй гэсэн байр суурьтай байгаа юм байна гэж 1 дүгээрт ойлгож байна. Энэ зөв үү гэдгийг 1 дүгээрт Байнгын хорооны даргаасаа асууя.

2-т нь манай Сангийн яамныхан хэдүүлээ энэ төсвийн зарлага, санхүүжилтдээ бүтцийн өөрчлөлт хийвэл яасан юм бэ гэсэн ийм санал байгаа юм. Төсвийн урсгал зардлаа бууруулаад, хөрөнгө оруулалтын зардлаа нэмэх чиглэлээр ер нь та хэд маань намар болтол судалгаа шинжилгээгээ хийж ажиллавал яасан юм бэ. Төсвийн урсгал зардлаа хэдүүлээ бууруулахгүй болохлоор хөрөнгө оруулалт маань нэмэгдэж өгөхгүй байна. Хийх ажил маш их байгаа байхгүй юу. Амласан ажил зөндөө байгаа. Тийм болохоор энэ чиглэлээр 2026 төсвөө боловсруулах чиглэлээр ажиллавал яасан юм бэ гэсэн санал байгаа юм.

Тэгээд дээр нь Засгийн газрын асуудал яригдаад, нөгөө Ардчилсан нам маань Засгийн газраас гарах нь тодорхой болчихсон юм чинь энэ яам энэ тэрийг нь татан буулгаад, төсвийн зардал энэ тэрийг хэмнэж болохгүй юу. Одоо тэр яамгүй сайдаар юу хийх вэ дээ. Хэцүү шүү дээ. Тийм биз дээ. Олон Шадар сайдын ч хэрэг гэж байхгүй байх. Ер нь тэгээд энэ бүтэц энэ тэрийг цомхотгоод, урсгал зардлаа бууруулбал яасан юм гэсэн ийм зүгээр санал байгаа юм. Энийг Төсвийн байнгын хороон дарга хариулахад хэцүү л байх. Зүгээр ямар ч байсан ийм санал байгаа шүү. Тэрийг та бүгд маань хариулж өгөөч. 1 дүгээрт тэр Төсвийн байнгын хорооноос эхний асуултыг хариулж өгөөч. Төсвийн урсгал зардлыг төсвийн зарлага, санхүүжүүлэлтийг 33.4-д гэж тооцоолж байгаа юм байна. Хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Алдаржавхлан гишүүний тэр төсвийн зардал буурах юм байна гэсэн асуулт байна. Тийм. Бууруулж байгаа юм байна лээ. Одоо чинь 35 их наяд илүү байгаа. 34 их наяд болгоё. Ер нь цаашдаа төсвийн зардлын өсөлт хурдацтай байсныг бас ер нь зогсооё, бууруулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй орж ирж байгаа юм байна лээ. Энэ бол зөв. Үндсэндээ 2021 онд байсан 11 их наядын төсөв одоо 35 их наяд болчихсон байгаа шүү дээ. 3 дахин өсчихсөн. Тэгээд энэ бол хэрвээ төсвийн орлого, нүүрс, гол экспортын нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн үнэ унасан үед бол маш өндөр эрсдэлийг дагуулах

байдлыг бий болгочхоод байгаа юм. Тийм учраас цаашдаа бол төсвийн зардлаа өсгөхгүй явъя гэж.

Яг өөрийн чинь хэлээд байгаа тэр төсвийн зардлыг бууруулахад ер нь бол бүтцийн өөрчлөлт шинэчлэл хийж л бууруулах ёстой. Тэрнээс биш механикаар бүх салбарыг тэд гээд шууд таналт хийж болохгүй. Ингэхээр эрүүл мэндийн салбар, боловсрол 2 л хүнд нөхцөл байдал үүсдэг ийм гашуун туршлага бидэнд бас бий. Өмнө ингэж байсан. Тийм учраас ялангуяа энэ 3 дахин өссөн урсгал зардлыг хаанаа өсчөв, юунаас болж өсчөв гэдгийг л нэлээн нарийвчилж гаргаж ирмээр байгаа юм. Тийм ажлын хэсэг Их Хурал дээр Булгантуяа гишүүнээр ахлуулаад ажиллаж байгаа. Эндээс бол тодорхой дүгнэлтүүд орж ирэх байх.

Яамдын тоог бууруулах асуудал бол уг нь их чухал. Би бол ер нь төсөв өссөний бас 1 шалтгаан бол олноор нь яам бий болсон нь салбар салбараар нь төсөв нэмэгдүүлж байгаа гэж ойлгож байгаа. Салбар салбараар нь шүү дээ. Тийм учраас энэ төсвийн зардлыг бууруулах чиглэлд гол хийгдэх ажил бол бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт хийж байж бууруулах ёстой гэдэгтэй бол санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Даваасүрэн даргад баярлалаа. Та бас санхүүч хүний хувьд бас миний саналыг дэмжиж байгаад их баярлаж байна. Манай Сангийн яамныхан ер нь саяын миний хэлсэн саналыг та хэд маань бас надад албан ёсоор албан бичгээр эргэж хариу өгөөч гэж би хүсэж байгаа юм. Төсөвтөө бүтцийн өөрчлөлт хиймээр байна хэдүүлээ. Маш том бүтцийн өөрчлөлт хийж шинжилгээ хийж байж төсвийн зарлага, санхүүжилтийг аль талаас нь хасах вэ, яаж хөрөнгө оруулалтаа нэмэх чиглэлээр ажиллах вэ гэдэг нь албан ёсоор одоо энэ Ганбат Ганбат дарга байж байна. Надад ирэх 7 хоногт та бүгд маань албан ёсоор хариу өгөөч. Би 2026 оны төсөв дээр бас энэ асуудлуудыг тавья гэж бодож байгаа. Тэр Булгантуяа сайдын ажлын хэсэг ахалж байгаа юм бол тэр энэ тэрд нь орж ажиллая гэсэн бодолтой байна. Тэгэхээр төсвийн зарлагад том бүтцийн өөрчлөлт, шинэчлэл хийх цаг болсон гэж би бодож байгаа. Даваасүрэн даргад бас санал дэмжиж байгаад талархлаа илэрхийлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр хэд хэдэн асуудал байна.

Эхлээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2025 онд Засгийн газар эдийн засгийг 8 хувиар өснө гэж өөдрөгөөр төсөөлж оруулж ирсэн. Өнөөдөр яг ямар хувьтай байна вэ. Миний авсан мэдээллээр бол өнөөдөр 5-6 хувьтай байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулмаар байгаа юм. Энэ буруу тооцсон асуудлыг хэн хариуцлага үүрэх юм бэ. Энгийн иргэн “А” этгээд “Б” этгээдээ залилах гэмт хэрэг үйлдэх юм бол гэм хорыг нь тогтоож, дээрээс нь үүссэн тэр хохирлыг барагдуулах ёстой. Засгийн газрын сайд нар залилан мэхлэх үйл ажиллагаа явуулсан байхад хэн хариуцлага үүрэх ёстой вэ. Засгийн газар 8 хувьтай байна Эдийн засаг. Хөндлөнгийн байгууллагууд, дээрээс нь танай байгууллага бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хараат бус байгууллага 6,1 орчим байна гээд санал болгож байхад тэр хуулиар ноогдсон та бүхний судалгааг авах ёстой Засгийн газар тэр тоо судалгааг авалгүйгээр төсвөө тэлсэн, орон тоогоо

нэмсэн, зардлаа нэмсэн энэ үйлдэл дээр хэн хариуцлага үүрэх ёстой вэ гэдгийг маш тодорхой хариулт авмаар байна.

2 дугаарт Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Энэ инфляц 2022 онд бол 13, 12 хувьтай байсан тохиолдол байгаа. Ковидын дараа. Инфляц буурсаар буурсаар одоо инфляц энэ жил та бүхний хэлж байгаагаар 5 хувьтай, 6 хувьтай байна гэж харж байгаа. Ирэх жил 7 хувьтай байна гээд энэ материал дээр оруулж ирсэн байна. Хэрэглээний сагсанд энэ түлш, дулаан, цахилгааны үнэ ордог уу. Дээрээс нь 7 хувийн өсөлт байна гээд та бүхний төсөөлөөд байгаа ирэх жилийн тэр өсөлтөд жишээгээр яг ямар бүтээгдэхүүнийг жишээ болгоод хэдэн бүтээгдэхүүн хэлээч ээ. Үнийн өсөлт нь ердөөсөө 7 хувь гэж. Миний тооцоогоор бол инфляц өнөөдөр бол 12 орчим хувьтай байгаа байх гэдэг ийм баримжаа тооцоотой байна. Ирэх жил бол энэ асуудал бүр өснө гэсэн төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр та бүхний энэ зөрүүтэй мэдээлэл дээр та бүхэн тайлбар хийгээч. Яаж тооцоод та нар 7 хувь гаргаад байгаа юм бэ. Энийгээ яг бүрэн гүйцэд ойлгуулах тийм боломж байдаг уу гэдгийг хэлмээр байна.

3 дахь асуулт болохоор зардлын асуудал байгаа юм. Урсгал зардал ялангуяа төсвийн зардлыг ирэх жил хэдээр хэмнэх юм. Яг тоо баримтууд. Төрийн албан хаагчдын тоо хэдээр хасагдах юм. Ялангуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас орж ирж байгаа энэ 400 орчим орон нутгийн болон улсын үйлдвэрийн газрууд хэд болж багасах юм. Үр өгөөжийн асуудал нь тооцогдсон юм уу. Яг аль байгууллага хариуцаад байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хариулт авъя. Баярлалаа. Тэгээд тодруулна.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга. Төсвийн байнгын хорооны дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Байнгын хороо бол яг Байнгын хороон дээр хөндөгдсөн асуудлуудын хүрээнд хариулт өгдөг. Энэ асуудал бол хөндөгдсөн. Байнгын хорооны ихэнх гишүүд ялангуяа инфляцын энэ орж ирсэн байгаа хувь хэмжээ бол үндэслэл муутай байна гэдэг ийм зүйлийг ярьсан. Дэлхийн банк, ялангуяа ОУВС бол харьцангуй бас нэлээн бодит байдал дээр тооцохыг оролддог. 6,2 хувьтай л гэж үзсэн юм байна лээ л дээ. Тэгэхээр манайхан бол 2025 оныг бол 6 хувь, 2027, 2028 оныг 6,5 хувь байхаар тооцсон байна лээ. Инфляцын түвшнийг бол ДНБ-ий өсөлтийг шүү. Инфляцын түвшнийг энэ жил 7 хувьтай гэсэн. Гишүүд бол үүнтэй харин санал нэгдэхгүй байгаа юм. Энэ бол өсөлт нь өндөр байна. Тэгээд ямар аргачлалаар тооцож байгаа талаар нэлээн мэдээллүүдийг бол авсан. Тэгэхдээ бүгд Статистикийн газар, Сангийн яам, Монголбанк энэ тэр бол бас ойролцоо аргачлалаар тооцдог гэсэн ийм хариултуудыг бол өгсөн. Тэгээд 2027, 2028 онд инфляц үе шаттай буураад байхаар тооцсон байгааг бол гишүүд эргэлзээд байгаа юм. 2027 онд 6,4, 2028 онд 6 хувь хүргэнэ гэсэн ийм тооцоо хийсэн. Энийг бол бас үндэслэл муутай гэж ингэж ярьсан. Зүгээр тэр нарийвчилсан зүйлүүдийг бол Эдийн засаг, хөгжлийн сайд л хариулах нь зүйтэй байх. Урсгал зардал ер нь төсвийн зардлыг бууруулж тооцсон байгаа. 1 их наяд гаруйгаар энэ оныхтой харьцуулахад бол бууруулна гэж ингэж тооцсон байна лээ.

Д.Амарбаясгалан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 дугаар индрээс хариулт өгье. Нэмэлт хариулт.

Ж.Дэлгэрсайхан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Дэлгэрсайхан. Бидний хувьд яг 2025 оны эдийн засгийн өсөлтийг 7,5 хувь байх боломжгүй гээд манай таамаглал дээр бол 5 хувиар орж ирсэн байгаа. Цаашдаа 2026 онд 5,4, ингээд 2027 онд, 2028 онд ер нь 5 орчим хувьтай байх юм байна гэсэн ийм таамаглал байгаа. Засгийн газрын оруулж ирсэн зүйлээс бол бидний таамаглал 2 гаруй хувиар доогуур байгаа гэдгийг хэлье. Энэ дээр бид нарын гол баримталж байгаа зүйл бол өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал болон эдийн засагт нөлөөлж болохуйц томоохон улс төр, уул уурхайн салбарын эрсдэлийн асуудлыг хөндсөн. Тийм учраас 2026 он хүртэл энэ уул уурхайн салбартай холбоотой асуудал нэлээд хүнд байдалтай байх юм байна гэж харсан. Түүн дээр нэмээд хэлэхэд ер нь өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал бол эхний сарын улирлын гүйцэтгэл ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Хууль зүйн хувьд Тогтвортой байдлын зөвлөл бас туршлагатай байлгүй гэж бодож байна. Энэ та бүхний хэлээд байсан эрсдэлийг, тоо мэдээллийг тооцоогүй өөрсдийнхөөрөө зардлыг нэмсэн, төсвөө баталсан, өөдрөгөөр төсөөлсөн асуудал дээр хуулийн хүрээнд хэн хариуцлага үүрэх ёстой юм бэ. Энэ чинь маш их хэмжээний хохирлын асуудал яригдана шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгө буюу төсвийг үрэлгэн зарах тэр үндсэн нөхцөл энэ төсвийн хүрээний буруу тооцооллоос л үүсэж байгаа шүү дээ. Энийг тодорхой хариулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх үү. Даваасүрэн дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм, Тогтвортой байдлын зөвлөл бол оруулж ирсэн хуулийн төсөл дээр дүгнэлт л гаргасан байгаа юм. Хариуцлагыг хэн хүлээх вэ гэхээр оруулж ирсэн Засгийн газар л гэсэн үг шүү дээ. Тийм учраас энэ оруулж ирж байгаа бодлогын баримт бичиг батлагдаад, энэ нь хэрэгжихгүй, биелэхгүй байхад яах вэ, уг нь жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байх үед энэ Засгийн газартай биелээгүй асуудлаар л хариуцлага хийх ёстой. Хариуцлагыг оруулж ирсэн Засгийн газар л хүлээх ёстой л доо.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандухай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө дээр орлогыг бүрдүүлдэг гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний улирлын байдлаар бол өмнөх оны үеэс 40 хувиар бол буурсан байгаа. Нийт экспортын орлого 17 хувиар буурсан. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого бол 16 хувиар буурсан байгаа. Түүхий эдийн үнэ буурсны улмаас бий болсон энэ нөхцөл байдал 2025, 2026 онуудад дамжин үргэлжлэх төлөвтэй гээд хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд нь тусгаад оруулчихсан байгаа. Тэгэхээр угаасаа орлого буурч байгаа нөхцөл байдлыг статистикаараа тавьчихсан мөртөө орж ирж байгаа төлөвлөгөө болон төсөв нь энэ статистикаа үгүйсгэсэн байдлаар ороод ирчихсэн ийм зөрүүтэй асуудал байгааг бас хэлмээр байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Шинжлэх ухаан, инновацыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ. Одоо байгаа ДНБ-д эзлэх хувийг 0,5 хувьд байлгана гэж байгаа юм. Угаасаа статистикийг нь харах юм бол бараг дундаж нь өөрөө 0,5 хувьд л зарцуулалт хийж байгаа. Гэсэн мөртөө энд 1 асуудал байгаад

байгааг би ойлгохгүй байгаа юм. Боловсролын яаманд их, дээд сургууль нь харьяалагдаад байдаг. Тэгсэн мөртөө эрдэм шинжилгээний байгууллага нь Эдийн засаг, хөгжлийн яамнаасаа эрдэм шинжилгээний байгууллага мөн гэсэн чиглэлээ баталгаажуулаад байдаг. Мэдлэг бүтээж байгаа газар нь өөрөө хөрөнгө оруулалт хийж RND буюу энэ судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хийдэггүй юм уу. Энэ одоогийн байдлаар бол Эдийн засаг, хөгжлийн яам энэ эрдэм шинжилгээний байгууллагаас ямар ч гарсан судалгаа, мэдлэг хөгжүүлсэн мэдээлэл, датанууд ерөөсөө гараагүй. Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг харах юм бол үндсэндээ бараг 2024 онд нийт 76 орчим тэрбум төгрөгийн мөнгө зарцуулснаасаа 82,3 хувь нь зүгээр л урсгал зардал. Тэгэхээр энэ чинь гол инновац, технологи хөгжүүлдэг байх ёстой мөнгөө зарцуулахгүй зүгээр л тэнд нэг хэдэн эрдэм шинжилгээний ажилчид цалин аваад л суугаад байгаа юм биш үү. Тэгэхээр энэ өөрөө бүтэц тогтолцооны хувьд өөрөө алдаатай учраас эрдэм шинжилгээний байгууллага хөгжихгүй яваад байна шүү дээ. Тэгэхээр энэ салбарууд чинь яаж өсөж хөгжих юм бэ гэдэг дээр бас хэлмээр байна.

Энэнээс болсоор байгаад бид нар Брэйн дрэйн буюу чадвартай залуучуудыгаа гадагшаа алдаад дууслаа. Сая бол жишээлбэл Их Британи улсын Монголд оюутнуудтай, судлаач нартай уулзаад ирсэн. Ерөөсөө гол хэлж байгаа юм нь Монгол Улсдаа хөгжлийг бүтээхэд оролцмоор байна. Үнэхээр цалин урамшуулал өөрөө хангалтгүй, ажлын байр тогтворгүй учраас бид нар очиж чадахгүй, эмээгээд байдаг юм гэж хэлж байгаа юм. Үндсэндээ эрдэм шинжилгээний байгууллага бид нар дорвитойхон санхүүжилт олгож, энэ дээр ач холбогдол өгч хөгжүүлж ирэхгүй бол ямар ч нөгөө чадвартай судлаачид орж ирэхгүй гэдгийг бас хэлмээр байгаа юм.

Хөдөө аж ахуйн сайдаас уг нь асуумаар байлаа. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд энэ 3.2.4 дээр малын эзэн, үйлдвэрийн эзэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Малын гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортолно гээд шинэ арга хэмжээ орж ирж байгаа юм. Энэ 1 жилийн дотор хийх боломжгүй 1 дүгээрт. Одоо хийж байгаа энэ Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо хөдөлгөөнөөс яг ямар ялгаатай юм бэ. Яагаад энэ байгаа мөнгөө зарцуулаад явж байгаа хугацаа тавьчихсан хөдөлгөөнүүд дээрээ сайжруулалт хийж, энэ хэрэгжилт дээрээ анхаарахын оронд ийм шинэ нэр томьёо өгч, шинэ арга хэмжээг дахиж төсөв оруулж ирээд байгаа юм бэ гэдэг дээр би хариулт авмаар байгаа юм.

Мөн энэ дээр дахиад малын генетик нөөцийн сайжруулах дээр дахиад төсөв, арга хэмжээг оруулж ирсэн байгаа /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Мандхай: Ер нь манайх ингээд аливаа төлөвлөгөөг суурь судалгаатай, үндэслэлтэй, өнгөрсөн хугацаанд хийсэн алдаа дутагдлыг үр дүн дээр үндэслэж төлөвлөдөг, тэгээд төсвөө зөв хуваарилдаг баймаар байна. Малын генетик нөөцийн үнэлгээ хуулиараа бол 3 жил тутамд хийх ёстой. Гэтэл сүүлийн 6 жил хийгдээгүй ирсэн байгаа юм. Бид нар энэ үнэлгээг хийж байж ямар ажлыг төлөвлөж, малын генетик фондын асуудлыг яаж сайжруулах хамгаалахтай холбоотой ажлын төлөвлөгөөнүүд улсын энэ хөгжлийн төлөвлөгөө болж сууж, төсөвт бас яг суугдаж орж ирэх ёстой байгаа юм. Тэгтэл энэ 6 жил хийгдээгүй юм чинь бид нар одоо энэ төсөв дээр оруулж ирсэн төлөвлөгөө төсвийг дэмжээд явахад би бол учир дутагдалтай гэж харж байгаа юм. Тэгээд энэ дээр би бас хариулт авмаар байна.

3.2.2.1 дээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд бас ингээд төлөвлөгөө оруулж ирсэн байгаа юм. Монгол орны усны нөөц өөрөө багасаж байгаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулт өгье. 4 дүгээр индэр.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Одоо энэ бол төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл бол төсвийн зарлагын нийт дээд хэмжээг баталж өгдөг байгаа. Тэрнээс биш дотор нь салбараар нь ангилж, задалж баталдаггүй. Мөн урсгал зардал энэ тэр гэж бас задалж баталдаггүй байгаа. Тэгэхээр таны асууж байгаа асуулт бол үүний дараа хэлэлцэгдэх жилийн төлөвлөгөө дээр яг хариулагдах боломжтой. Тэгэхээр энд орж ирсэн ажлын хэсгийн хувьд бол таны асуултад шууд хариулах боломжгүй байна.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга нэмж хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, нөгөө жилийн төлөвлөгөө хамт хэлэлцэж байгаа болохоор та бүгд нөгөө жилийн төлөвлөгөөний асуултууд яриад байх шиг байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь нөгөө төсвийн тогтвортой байдлыг хангах үзүүлэлтүүд дээр ярьж байгаа байхгүй юу. Жишээлбэл зардал гэхэд, хөрөнгө оруулалт гэхэд шинэ боломж хэд байгаа юм гэдэг дүнгээ тавиад, тэгээд төсвийн зардал нь ДНБ-ий тэдэн хувь байна гээд тавьчихсан байгаа. Тэр 9, 10 үзүүлэлтүүдийн хүрээнд төсвийн хүрээг бол баталдаг. Тэрийгээ бид нар яриад байгаа юм. Тэрнээс биш яг нарийвчлаад бүр хөрөнгө оруулалт 1 бүрээр ярьсан зүйл бол байхгүй.

Ер нь зүгээр яах вэ, авахдаа тэр Мандхай гишүүний хэлээд байгаа шиг нүүрсний үнийг харин 75, 80 ам.доллар гэж ингэж авсан юм байна лээ. Одоогийн байдлаар нүүрсний үнэ яг ийм хэмжээнд байгаа. Эхний 4, 5 сарын гүйцэтгэлийг харахад бол экспортын орлого 1,3 тэрбум ам.доллараар буурсан байгаа. Засгийн газар бол үүнийг алт, зэсээрээ нөхчихсөн гээд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Үгүй ээ үгүй, яах вэ ер нь яамны хариултыг сонсохоор төсвийн хүрээний мэдэгдэл ч бай, төлөвлөгөө бай ер нь зарчмын хувьд энэ чинь 1 л юм руу чиглэж байгаа шүү дээ. Би ер нь бүтцийн хувьд тогтолцооны асуудлыг яриад байгаа байхгүй юу. Энэ чинь нийт тавьж байгаа төсөв чинь өөрөө дотроо нийт зардлын чинь 82 хувь нь урсгал зардал руу яваад байна. Эрдэм шинжилгээний салбарт. Тэгээд үндсэн гол инновац, технологи, туршилт хийх төсөв чинь өөрөө 20 хувь хүрэхгүй байна шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө тогтолцооны хувьд алдаатай яваад байна. Зүгээр хүмүүсийг цалинжуулаад тэнд зардал үрээд байна. Хэрэв тийм байгаа бол тэнд зүгээр хүмүүсийг цалинжуулж орон тоо үүсгээд байх шаардлага байгаа юм уу. Эдийн засаг, хөгжлийн яам дээр угаасаа байгаад үр дүн гарахгүй байгаа учраас энэ тогтолцооны хувьд нь өөрчлөх ёстой юм биш үү. Энэ дээр би ер нь яаж сайжруулах гэж байгаа юм. Дахиж нэмж орж ирж байгаа 0,5 хувьд хүргэнэ гэдэг ажлаа яаж хийх гэж байгаа юм бэ гэдгийг л тодруулж асууж байгаа байхгүй юу. Тэгээд Хөдөө аж ахуйн яамнаас миний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам.

Л.Энх-Амгалан: Миний хариулт адилхан л байна даа гишүүн ээ. Үүний дараа яг ажлын хэсэг дээр салбар салбар хариуцсан, асуудал асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга нар, яамдын төлөөлөл, газрын дарга нар орж ирнэ. Яг тэр үед энэ тогтолцооны асуудал дээр яг холбогдох хариуцсан хүн нь тодорхой хариулах байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн дарга нэмэлт хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Яах вэ зүгээр яг энэ бүтцийн асуудал Байнгын хороон дээр хөндөгдөөгүй л дээ. Зүгээр би гишүүн асуусан учраас хариулчихъя.

Дараагийн яг энэ хөрөнгө оруулалтын асуудал яригдахаар бас хөрөнгө оруулалт чинь шинжлэх ухааны урсгал санхүүжилттэй бол хамааралгүй болчихоод байна. Тогтолцооны хувьд буруу байна гээд байгаа нь би бас үнэн байх гэж бодоод байгаа юм. ШУТС-гаар дамжаад урсгал зардал санхүүжүүлээд, тэнд хэдэн эрдэмтэн, тэнд хэдэн академичид сууж байгаа байхгүй юу. Хөдөлж байгаа юм байхгүй, өөрчлөгдөж байгаа юм байхгүй. Академийнх нь 3, 4 жил болоод л цалингаа нэмнэ гээд Их Хуралд оруулж ирээд, тэгээд л цалингаа нэмдэг, төсвөө нэмдэг. Тэгээд ийм зүйл бол байгаа байх. Тэгэхдээ энэ бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр хөндөгдөх асуудал бас яг эхний хэлэлцүүлэг дээр болох байсан юм. Тухайн үед сайд нар нь яг байж байх үед нь та нар энэ асуудлуудаа бүтцийн хувьд яаж шийдэх гэж байна вэ гэж. Одоо болохоор оруулж ирсэн Эдийн засаг, хөгжлийн сайд нь ч алга. Тэгэхээр ер нь цаашдаа 2025 он, 2027 оны төсвийн төсөөллүүд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хөдөө аж ахуйн яамнаас төлөөлөл байна уу. Төрийн нарийн бичгийн дарга, сайд. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Эрчим хүчний реформыг 2024-2028 оны хооронд хэрэгжүүлнэ гээд Улсын Их Хурлаас бол асар өндөр дэмжлэгтэй байгаа. Тэрний нэг том илрэл нь 2026 онд гэхэд шинээр 9 төслийг 175 тэрбумаар дэмжихээр Улсын Их Хурлын гишүүд бол саналаа гаргасан байгаа юм. Гэтэл 2025 онд тавигдсан байсан 35 төсөл нь өөрөө хөдөлсөн юмгүй байж байгаа. Энэ юуг харуулж байна гэхээр Эрчим хүчний яам ажлаа хийж чадахгүй байгааг харуулж байгаа юм л даа. Өмнөх төслүүдээ хэрэгжүүлж чадаагүй Эрчим хүчний яам одоо яаж дараа жил хэрэгжүүлэхээр төсөвт оруулах гэж байгаа энэ шинэ төслүүдээ хэрэгжүүлж явах юм бэ. Энэний үндсэн шалтгаан нь бол Эрчим хүчний яам өөрөө эрчим хүчний реформ хийхтэй холбоотойгоор энэ эрчим хүчний тусгай зөвшөөрлүүдийн асуудлуудыг бид нар хөнгөвчилж өгөх шаардлагатай байсан. Жишээ нь Барилга, хот байгуулалтын яам дээр Батсуурь сайд бол маш том реформыг хийж байгаа. Тэр бол license.mn дээр дамжаад хүн ерөөсөө гэрээсээ тусгай зөвшөөрлийн материалуудаа бүрдүүлээд өгчих боломжтой болж байгаа юм. Ерөөсөө тэгж шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дамжих ч байдаг юм уу, яамаар олон хоног явах шаардлагагүй болоод, 1 инженер гэдэг хүн өөрөө 4-5 компанид бас бүртгүүлэх боломжийг нь нээж өгч байгаа юм. Манай Монгол Улс бол хүний нөөцийн асар дутагдалтай орон. Тусгай зөвшөөрөл авахад тулгамддаг асуудал бол инженерүүдийн тоо өөрөө хүрэлцэж чаддаггүй. Үүнээс болоод авлига бий болдог. Тэгэхээр энэ сайдаар дамжуулж заавал гарын үсэг зурдаг эсвэл аль нэг газрын даргыг хүлээж 200 хоног 1 тусгай

зөвшөөрөл авах гэж дунджаар гардаг цаг хугацааг ердөөсөө цахимаар хийх боломжийг нь гаргаад өгчхөж байгаа юм. Энэ өөрөө маш том реформ. Ард иргэд эрчим хүчний реформоос юу хүлээж байгаа вэ гэвэл ганцхан заавал станц барих тухай асуудал биш. Бид нар энэ төрийн хүнд суртлаа зайлшгүй өөрчлөх ёстой тэр зүйлийг хүсээд байсан, шаардаад байсан. Гэтэл энэ маань бол өөрөө яваагүй байна. Энэ Барилга, хот байгуулалтын яам дээр Батсуурь сайдын хийчихсэн байгаа жишээг бэлхэн аваад Эрчим хүчний яам хэрэгжүүлээд явчих л даа. Тэгэх юм бол энэ олон төслүүд чинь өөрөө цаг хугацаандаа хэрэгжээд явах боломж нь гараад ирнэ.

2 дугаар асуудал бол Байгаль орчны яаман дээр Одонтуяа сайдын хөдөлгөж чадсан олон жил гацсан байсан Эгийн голын УЦС-ын төслийн хэлэлцээрүүд бол явагдаж байгаа юм байна. Энэ дээр болохоороо энэ дэлхийн өвийн Байгаль нуурт үзүүлэх Дэлхийн өвийн сангийн Юнеско-ийн гаргасан байгаа тэр 2015 онд гарсан тэр зөвлөмжийг өөрчлөх, энэ дээр дахиад судалгаануудыг нэмж хийхээр 3,4 тэрбум гэж гарсан юм байна. 2026 онд 1,3 тэрбум. Энийг бол Байгаль орчны яамнаас бол хөдөлгөөд, одоо Эрчим хүчний яам дээр ирж байгаа юм байна. Миний санаа зовж байгаа зүйл бол Эрчим хүчний яам дээр очоод энэ ажил гацах вий дээ. Эрчим хүчний яам энэ ажлаа шахаж явж явуулж чадах юм уу. Эгийн голын УЦС 300мвт буюу тогтворжуулах асар чухал ач холбогдолтой. Манай улс дотоодоосоо эрчим хүчээ хангадаг болох боломжийг нээх хамгийн том төсөл байгаа юм. Энэ дээрээ яаж ажиллах гэж байгаа юм бэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Хөгжлийн төлөвлөгөө. Яах вэ одоо нэгэнт асуучихсан юм чинь та хариулт өгчихье дөө. Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Цэнгүүн гишүүн ээ, тусгай зөвшөөрлийн тухайд би сүүлийн 2022 оны 8 дугаар сараас хойш Эрчим хүчний сайдаар ажиллаж байгаа. Ямар нэг тийм хүндрэл бэрхшээл байхгүй. Хүнд суртал гаргахгүй ажилла гэдэг шаардлагыг тавьж байгаа. Ажлын 10 хоногтоо багтаагаад бид нар өгч байгаа. Гарцаагүй шаардлага биелүүлэхгүй байгаа компаниуд янз бүрийн байдлаар улс төржүүлээд байгаа юмнууд бий. Та саяын ярьсан 200 хоногтой холбоотой яг тан дээр тийм тодорхой мэдээлэл байгаа бол бичгээр ирүүлээд, би танд бичгээр тодорхой хариулт өгье. Ийм саналтай байна.

Эгийн голын УЦС-ын тухайд та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Монгол Улс Эгийн голын УЦС-ыг хэрэгжүүлэе гэдэг ийм санал тавьсан. Түрүүчийн түрүүчийн Засгийн газрын үед бол Хятадын тэрбум долларын зээлээр энийг санхүүжүүлэх талаар яригдаж байсан. Гэтэл ОХУ Юнескод гомдол гаргаад, Юнескогоос манай Засгийн газрыг бид нар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийх компанийг сонгоод, Францын компани дүгнэлтээ гаргасан. Байгаль орчинд тодорхой хэмжээний Байгаль нуурт нөлөөлөл багатай гэдэг дүгнэлт ирсэн. Энийг одоо байгаа Цивилев сайдын өмнөх Шульгинов сайдад би бичгээр дипломат шуудангаар хүргүүлсэн. Ийм байна. Гэтэл 2 улсын Төрийн тэргүүний уулзалтын үеэр энэ найрамдал бус харилцаатай улсын компанийн гаргасан дүгнэлт хангалтгүй байна. 2 улсын шинжлэх ухааны байгууллагууд хамтарч энэ дүгнэлт гаргая гэдэг ийм шийдвэр гарсны хүрээнд Монголын талаасаа Байгаль орчны сайд ахлаад, ОХУ талаасаа Байгаль экологийн сайд нь ахлаад ийм ажлын хэсэг явж байгаа. Ирэх 2026 оны эхний хагастаа багтаагаад дүгнэлтийг гаргая гэдэг ийм ойлголттойгоор явж байгаа. Ийм л байна.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Төсвийн хүрээний мэдэгдлийн орлого, зарлага хэсэгт аль алинд нь нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгал яригдаж байгаа учраас тодруулж, мөн дараагийн төсөв дээр ялангуяа энийг анхаарч ажил болгох талаар бас хэдэн юм ярихгүй бол болохгүй нь ээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн даатгалын асуудал байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийхээр ажил олгогч нь 10 хувь, энгийн хүмүүс бол ажил олгогч 12,5 хувь, хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө 9,3 хувь, энгийн хүн бол 11,5 хувь төлж байгаа өнөөдөр. Тэгээд НДШ-ийг арай бага төлж байгаа нь ашиг тустай мэт боловч яг үнэндээ бодит байдал дээр НДШ төлдөг бусад хүмүүстэй адилхан нийгмийн даатгалын сангаас олгох аливаа боломжууд ерөөсөө байхгүй байна гэсэн үг. 1 дүгээрт юу вэ гэхээр нийгмийн даатгалын санг шимтгэлийн хуулиар нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авах биш, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсдэг. Сүүлийн 5 жил нийтдээ 36 сар ба түүнээс дээш төлсөн бол хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн халамжийн тэтгэврээс нийгмийн даатгал руу шилждэг. Ажил хийх боломж нь жигд биш байхад энэ нөхцөл хангагдахгүй байгаа гэсэн үг байхгүй юу. Ажил хийх гээд. Тасралтгүй 5 жил ажил хийдэг хөгжлийн бэрхшээлтэй хүн бас их ховор шүү ер нь бол. Яг амьдрал дээр бол ийм л болчихоод байгаа юм.

Дараагийнх нь болохоор хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоох нь бас бид нарт үйлчлэхгүй, ажиллахгүй байгаад байна. Ер нь бол тэтгэврийн дээд хэмжээ 800 мянга орчим төгрөг байхад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувь тэнцүүлснээрээ 540000-ыг л авдаг. Та нар өөрсдөө тоо баримтаа мэдэж л байгаа байх. Бүрэн тэтгэвэр тогтоох хэсгийг аваад үзэхээр бүрэн тэтгэвэр авах эрх үүсэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн ер нь байхгүй. 20 жил төлөөгүй шүү дээ. 20 жил ажил хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн гэвэл ер нь их ховор шүү. Эрүүл мэндийн байдлаараа ч, тэр нөхцөл байдлаараа ч тэр. Тэгэхээр энэ зэрэг асуудлууд нь өөрөө ажил хийж байгаад ажлаасаа халагдахад ажилгүйдлийн тэтгэмжийг авч чадахгүй. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүн хөнгөлөлттэй НДШ төлсөн учраас. 12 сар сар бүтэн цалин авсан хэр нь цалингийн зээл авч чадахгүй. 12 сар НДШ төлөгдсөн мөртөө цалингийн зээл ч үүсэхгүй. Банкны зээл ч үүсэхгүй. Халамжийн сангийн тэтгэвэр 328 мянга байхад нийгмийн даатгалын сангийнх 540 мянга хавьцаа байгаа. Тэгэхээр ер нь бол ирэх жилүүдэд, одоо ингээд 2025, 2026, 2027 онд энэ асуудлаа шийдэхгүй бол том зургаар дүгнэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм, эдийн засгийн эрх гэдэг зүйл бол огт хэрэгжихгүй байна уу даа л гэж дүгнэлт хийх гээд байна л даа энэ нөхцөл байдлыг аваад үзэхээр. Одоо би энэ асуудал дээр ямар төлөвлөгөөтэй байгааг асуумаар байгаа юм.

Сүүлд нь тодруулмаар байгаа юм. Энд байгаа эдийн засагчдаас. Ер нь засгийн шийдвэр гаргалтын удаашрал нь ДНБ-д, ялангуяа улсын төсөв, төсвийн хүрээний тооцоог гаргахад яаж нөлөөлдөг ийм тооцоолол байдаг уу. Энийгээ тэр дундаа өвдсөн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд яаж тусдаг вэ гэдэг тооцооллыг та нар хийж энэ төсвийн хүрээллийн тооцоог хийдэг үү. Энэ дээр ер нь яаж тооцооллуудаа гаргадаг юм бэ. Энэ дээрээс хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Саранчулуун гишүүн ээ, би тантай бас санал нэг байгаа. Та бид 2 бас Баясгалан гишүүн бид 3 бас сүүлийн үед энэ хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн асуудал, гол нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг гол тогтолцооных нь хувьд шинэчлэл хийе гэдэг дээр зарчмаа тохироод, тэгээд бид нар чинь энэ тогтолцооны зураглал гаргах гээд хамтдаа суугаад байгаа шүү дээ тийм ээ Саранчулуун гишүүн ээ. Тэгээд энэ зураглал гарч ирснээр юуг давуу талыг бий болгох гэж байна вэ гэхээр ерөөсөө яг эхийн хэвлийгээс төрөөд, ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь оношлогдоод ингэх юм бол яг аль насандаа эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээг ямар хэлбэрээр яаж авах вэ, аль наснаас дараагийн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсролын тогтолцоо руу яаж шилжих вэ гэдэг энэ тогтолцооны зураглалуудыг бид нар гаргаж ирээд, энийгээ дагуулж яг таны хэлж байгаа энэ тэтгэвэр, тэтгэмжийн асуудал байгаа.

Насан туршдаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болж оношлогдож байгаа ийм хүмүүс ч бас байгаа. Тэгээд энэ дээр тохирсон одоогийн явж байгаа энэ халамжийн тэтгэвэр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр, хувь тэнцүүлсэн тэтгэврээс цаашаа бүрэн тэтгэвэр лүү яаж шилжилтүүд хийх вэ гэдгийг бол бид нар их нарийн тогтолцооных нь хувьд маш сайн шинжилгээ анализ хийж байж энэ дээр гаргалгаанууд гарах ёстой. Тэгэхээр би тантай 1 зүйлийг л яриад байгаа шүү дээ. Одоо бүгдээрээ асуудлыг шийдэхдээ ийм гал унтраасан байдлаар авч хэлэлцэхээ больё. Тогтолцоогоор нь харъя. Системээр нь харъя. Тэгж байж зөв онош тавьж байж, зөв эмчилгээ, зөв арга шийдлүүд гаргахгүй бол 1 удаагийн хуулиар, 1 удаагийн хуулийн өөрчлөлтөөр бид нар энэ асуудлуудыг шийдэж чадахгүй юм байна. Тийм учраас өнөөдөр энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ цаашдаа хөдөлмөрийн чадвар алдагдлын асуудлуудыг нөгөө ICF гээд олон улсын тогтолцоонд шилжүүлж, эндээсээ үндэслэж хөдөлмөрийн тэр чадвар алдагдлуудыг яаж үнэлэх вэ, тэрийг яаж нөхөн сэргээх вэ, амьдралд яаж бие дааж оролцуулах вэ, энийг нь дэмжсэн нийгмийн даатгалын тогтолцоо, энийг дэмжсэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тогтолцоо, энийг дэмжсэн ажилгүйдлийн тогтолцоо, энийг дэмжсэн тэтгэмжийн тэтгэврийн тогтолцоонууд нь яг яах вэ гэдгийг бид нар ингээд ярилцаж байна. Удаахгүй бид нар Улсын Их Хурал дээр тэтгэврийн шинэчлэл болон нийгмийн даатгалын тогтолцооны асуудлаар шинэчлэлийн эрх зүйн юуг өргөн барихаар бэлдэж байгаа. Энэ хүрээндээ яг таны сая хөндөж тавьсан асуудал дээр нэлээн томоохон бодлогын шийдлүүд оруулж ирнэ гэдгийг бас би энд хэлье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр бид бол энэ төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байна. Энэ удаагийн энэ жилийн төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулалтын хувьд ч, тооцоо судалгааны хувьд ч Улсын Их Хурал дээр хэлэлцүүлж байгаа хэлэлцүүлгийн хувьд ч гэсэн бас тийм шаардлага хангахуйц хэмжээнд бас явагдаж чадсангүй гэсэн ийм хувийн дүгнэлттэй сууж байна. Яах вэ, төсвийн хүрээний мэдэгдэл цаашдаа ер нь өмнө нь байнга л өөрчлөлт орж явдаг. Төсвийн тодотголоо дагаад, жил жилийн төсвөө дагаад байнга л өөрчлөлт ороод яваад байдаг учраас төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас онцгой анхаарал хандуулахгүй яваад байна гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд би үүнтэй холбоотой зүгээр саналуудаа л хэлье дээ. Асуулт асуугаад яах вэ гэж. Ингээд хэд хэдэн саналуудыг бас хэлье гэж ингэж бодож байгаа.

Тэгээд нэн даруй бол Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулиуд дээр бол бид нар өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн байна гэж ингэж харж байгаа юм. Тэрийгээ би бас хэд хэдэн саналуудаар би бас та бүхэнд хэлье гэж бодож байна.

1 дүгээрт нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ажиллаж байгаа. Бид энэ төсвийг тогтвортой байлгах гол бодлогын зөвлөмж өгдөг ийм л том байгууллагыг үүсгэлээ гэж бид нар харж байгаа. Хуулиараа бол бид нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр эдийн засгийн хүсэлтийг тооцох, инфляцыг тооцох, орлого, зарлагыг тооцох гэх мэтчилэн маш их томоохон үүрэг даалгавруудыг өгчихсөн. Энд 7, 8 гишүүн байгаад байдаг. Ажлын алба байдаггүй. Хүн, хүчний нөөц ч байхгүй. Тэгээд ийм их хэмжээний ажлыг даалгаад өгчихсөн. Энэ эдгээр хийдэг ажлууд нь Засгийн газрын ажлуудтайгаа давхацдаг. Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газар 2 байнгын зөрчилдөөн үүсдэг. Энэ зөрчилдөөн нь парламент руу орж ирдэг ийм нөхцөл байдал үүсээд байгаа гэж ингэж харж байгаа юм. Зүй нь бол манай Тогтвортой байдлын зөвлөл бол яг энэ төсвийг тогтвортой байлгах чиглэлээр бодлогын зөвлөмж өгдөг ийм зөвлөл хэлбэрээр нь ажиллуулах нь зөв гэж үзэж байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд хамгийн гол нь манай төсвийг аваад үзэхэд нүүрс, зэсийн тэнцвэржүүлсэн үнэ хамгийн чухал. Гэтэл өнөөдрийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр орж ирсэн тэнцвэржүүлсэн үнэ нь 133 доллар гээд ороод ирчихсэн байгаад байгаа. Гэтэл өнөөдөр бодит амьдрал дээр нүүрсний үнэ чинь яг ийм үнэтэй байгаа юу гэвэл 70 доллар хүрэхтэй, үгүйтэй байгаад байгаа юм. Эндээс юу харагдаж байна вэ гэхээр зэрэг тэнцвэржүүлсэн үнийг төсвийг тогтворжуулахад ямар ч үүрэггүй болгоод байгаа нь эндээс харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ төсвийг тогтвортой байлгахын тулд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Улсын Их Хурлын гишүүдэд яг энэ чиглэлээрээ тодорхой тийм бодлогын танилцуулга бас хийх шаардлагатай байна гэж ингэж үзэж байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбоотой Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ төсвийг тогтвортой байлгах үүднээс ямар бодлогын зөвлөмжүүдийг гаргах шаардлагатай байна вэ гэдэг чиглэлээр нэн даруй бас танилцуулга хийхийг хүсэж бас санал илэрхийлж байна.

2 дугаарт нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг гаргадаг ийм л бодлогын баримт бичиг. Үүнийг давхардуулаад бид нар бас улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө гээд улсын төсөвтэйгөө давхардуулсан бас нэг ийм үр дүнгүй ажлыг л ингээд хийгээд л яваад байдаг. Засгийн газар дээр боловсруулалтын шатад ч тэр Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад ч тэр бид нар маш их үр ашиггүй ийм давхардсан ажлыг хийгээд яваад байгаа. Өнөөдөр бодит амьдрал дээр бид нар энэ урсгал зардлаа өмнө нь хийгдэж байсан хөрөнгө оруулалтынхаа зардлуудыг үргэлжлүүлж явуулахад өнөөдрийн энэ төсөв хүрэлцэхгүй байгаад байгаа шүү дээ. Гэтэл төсвийн жилийн төлөвлөгөө гээд өмнө нь бас үндсэн чиглэл гээд ямар ч хэрэгждэггүй ийм бодлогын баримт бичиг явдаг байсан. Энийгээ өөрчлөөд жилийн хөгжлийн төлөвлөгөө гэж өөрчилсөн. Одоо энэ жилийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг харахад дахиад хэрэгжихгүй баахан ийм төлөвлөгөөнүүд явж байгаа юм. Тэгэхээр энийг бол юу гэж харж байна гэхээр зэрэг төсвийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Заяабал: Энэ дээр ямар санал хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөг энэ төсвийн хүрээний мэдэгдлийгээ дагаад Засгийн газрын өрийн баримт бодлогын баримт бичигтэйгээ адилхан ийм товчхон хэлбэрээр дагалдуулсан бодлогын баримт бичиг болгож болдоггүй юм уу гэсэн ийм 2 дахь саналыг илэрхийлэх гээд байгаа юм.

3 дугаарт нь энэ өрийн асуудал байгаа. Яах вэ ингээд Өрийн тухай хуулиар орон нутаг бонд гаргах эрхтэй. Өр тавих эрхтэй болчихсон. Гэтэл Төсвийн тухай хууль дээр чинь орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж хэрэгжүүлнэ гэсэн ийм хуулийн заалт чинь хэрэгжихгүй өнөөдрийг хүртэл ингээд яваад байна. Цаашдаа орон нутаг, одоо орон нутгийн бүсийн уулзалтуудыг хараад байхад бүсүүд дээр болж байгаа байдлыг харахад нийслэлээс гадна аймгууд чинь бонд гаргах ийм боломжийг нь нээгээд, энэ талаар ярилцаад явж байна л даа. Энэ чинь эргээд дахиад төсвийг орон нутгийн төсвийг алдагдалгүй батлах, цаашаа явах ямар ч боломжгүй болгож байна л даа. Энэ дээрээ бас бид нар өөрчлөлт хийж /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Минут сунгахгүй. Минутдаа багтаагаад ярина.

Ер нь нэмэлт минутын агуулгыг та бүхэн маань их сайн ойлгох ёстой шүү дээ. Хариултаа гүйцэд авч чадахгүй бол тодруулж асуух эрх нээж байгаа юм. Хэн хариулт өгөх вэ. Хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээ загвар дээр бас Заяабал гишүүн бодитой санал хэлж байна. Даваасүрэн дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүний хэлээд байгаа ялангуяа татварын орлого биелэх эсэх энэ тэр дээр гишүүд нэлээн эргэлзээтэй зүйл яриад байгаа юм. Би зүгээр 1 жишээ хэлье. Одоогоор яг эхний 4, 5 сарын экспортын орлогын гүйцэтгэлийг харахаар нүүрсний орлого 1,3 тэрбум ам.доллараар буурчихсан байгаа Засгийн газар бол үүнийг алт, зэсээр нөхөж байгаа гэж ингэж тайлбарлаад байх шиг байгаа юм. Үнэндээ бол яг бодит байдал дээр тийм биш. Яагаад гэвэл алт, зэсийн орлогын чинь дийлэнх хувь Оюутолгойн орлого байгаа. Оюутолгойн орлогын чинь 5 хувь нь л татвараар орж байгаа. Тэгэхээр бодит нөхцөл байдал дээр экспортын орлогын хувьд бид нар алдагдал хүлээгээд эхэлчихсэн байгаа. Тэрбум доллараар бол. Өнгөрсөн онтой харьцуулж байгаа шүү дээ. Ийм байгаа. Загварчлалуудын хувьд бол бид нар бас тодорхой асуусан. Ерөнхийдөө 1 загварчлалаар тооцоогоо хийдэг гэдэг зүйлийг Эдийн засаг, хөгжлийн яам бол хариулсан. Тийм учраас зүгээр түүвэр авахдаа, сонгохдоо янз бүрээр бас авдаг байж магадгүй.

Нөгөө гол яриад байгаа юм бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газрын оруулж ирж байгаа санал 2-ын хоорондын зөрүүг яриад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол төсвийн хүрээний мэдэгдэл орж ирэхээс өмнө тэр таамаглал төсөөллөө Сангийн яаманд бас хүргүүлж байгаа. Хүргүүлж байгаа юм. Тэрийг нь бол би бас харж тооцож үздэг байх гэж бодож байна. Одоо Улсын Их Хурал дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Төсвийн алба 2-ыг зохицуулсан эрх зүйн орчин бий болгох хуулийн төсөл бэлтгэх ажлын хэсэг ажиллаж байна. Өчигдөр бид хуралдсан. Тэгээд энийг нэг мөр шийднэ. Яагаад гэвэл энэ дээр бас давхардал бий. Төсвийн албыг Тамгын газарт байлгаж болохгүй ээ дарга аа, Их Хурлын дарга аа. Яагаад гэвэл төсвийн нэг эрх захирагч хуулиар олгогдоогүй эрх эдэлж, нөгөө төсвийн эрх захирагч нартаа дүгнэлт өгч болохгүй. Энэ буруу юмыг өнгөрсөн жил хийчихсэн юм байна лээ. Уг нь төсвийн алба нь хаана байсан юм гэвэл Байнгын хорооныхоо дэргэд байсан юм. 2011 оны ху хуулиараа.

Тийм учраас бусад байгууллагуудын ерөнхийлөн захирагч нарын төсөвт дүгнэлт өгч байгаа учраас энэ Төсвийн алба нь Их Хурлынхаа дэргэд, Байнгын хороодынхоо дэргэд байх ёстой. Тэгж байж энэ төсөв дээр дүн шинжилгээ өгдөг, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг гаргадаг ийм байх ёстой. Зүгээр макро эдийн засгийн үзүүлэлтүүд боловсруулах асуудал дээр болохоор 1 хэсэг нь Тогтвортой байдлын зөвлөл алба байх ёстой, 1 хэсэг нь төсвийн алба нь хийх ёстой гээд 2 юм байгаад байгааг бид нар 1 болгох гээд байгаа юм. Ер нь бусад орнуудад төсвийн албан дээрээ байдаг. Тэнд бол маш том бүтэц байдаг. Зөвхөн төсвийн үзүүлэлтүүд биш макро эдийн засгийн бүх үзүүлэлтүүдийг бэлтгэж Их Хуралд өгч байдаг. Их Хурал нь түүнийгээ үндэслээд Засгийн газраас оруулж ирж байгаа макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг бодитой юу, үгүй юу гэдэг ийм хэлэлцүүлэг явагддаг байхгүй юу. Одоогоор бол манайд тийм бүтэц нь Их Хуралд байхгүй гэсэн үг. Бид нар Засгийн газраас л зүгээр асуугаад суугаад байгаа байхгүй юу өөрсдөөс нь.

Д.Амарбаясгалан: Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдлийг дагаж энэ тооцоо судалгаануудыг оруулж ирэхдээ манай Засгийн газрын зүгээс онцгой анхаарч оруулж ирмээр байна. Өнөөдрийн энэ төсвийн хүрээний мэдэгдлийг дагаж орж ирж байгаа тооцоо судалгаа чинь өнгөрсөн үеийн авч хэрэгжүүлсэн Засгийн газрын үйл ажиллагаануудыг статистик тоо мэдээг нь хараад тэрийг дандаа зөвтгөсөн өнцгөөс нь асуудлыг дандаа харж авч үзсэн байх жишээтэй. Гэтэл энэ дээр өмнө нь тавьсан байсан зорилт, бодлогын арга хэмжээнүүд хэрэгжээгүйтэй холбоотой ямархуу хэмжээний алдагдсан боломжуудыг бид нар алдаад байгаа юм бэ гэдэгтэй холбоотой ямар ч тооцоо судалгаа байхгүй. Дандаа өнгөрсөн түүхийг зөвтгөсөн ийм хэлбэрээр тооцоо судалгаа хийж оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ та бүхэн бас онцгой анхаараарай.

Өрийн асуудал дээр нэмж хэлэхэд бид нар зөвхөн өрийн өрийн баримт бичиг дээр зөвхөн Засгийн газрын өрийг төлөхтэй холбоотой бодлогын асуудлуудыг оруулж ирсэн байгаа. Гэтэл хувийн хэвшлийн өрүүд байгаад байгаа. Эдгээр чинь бүгдээрээ Монгол Улсын валютын ханш дээр нөлөөлөх учраас хамтад нь тооцож явах ёстой шүү гэдэг /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Төсвийн хүрээний мэдэгдэл дээр манай Улсын Их Хурлын гишүүд бол 9 тоо л баталж байгаа юм. ДНБ-ий өсөлт, инфляц, тэгээд орлого, төсвийн зарлага, тэгээд тэнцвэржүүлсэн тэнцэл гээд. Тэгээд асуухаар манай Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам үгүй ээ энэ 9 тоогоо л ярина шүү дээ. Үүнээс илүү хальж бол бараг ярихгүй шүү дээ гээд. Тэгсэн мөртөө бас яах вэ, та бүгдийн нэг бодлын заль л даа. Тэгээд энэ хэдийгээ батлуулчихаад, дараа нь намар тэрүүнийхээ хүрээнд төсвөө оруулж ирэнгүүтээ үгүй ээ та нар өөрсдөө батлаад өгчихсөн шүү дээ гээд. Бид нар нөгөө дотрыг нь мэдэхгүй учраас асуухаас өөр аргагүй болчихоод байдаг. Яагаад гэвэл энэ хүрээнд төсвөө хийгээрэй гэдэг үүрэг чиглэлийг бид Улсын Их Хурал та бүгдэд өгч байгаа юм. Гэхдээ мэдээж энэ 9 тоог гаргахын тулд Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам бүгдээрээ хамтраад та бүхэн маань өдөржин шөнөжин л ажилласан байж таараа. Тэгэхээр үүний ар талын үндэслэлийг угаасаа асуух нь Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг. Тэгээд би ийм юм асуух гэсэн юм.

Сая Улсын Их Хурал 2025 оны төсвийг батлахдаа 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 52 дугаар тогтоолоор Засгийн газарт баахан чиглэл өгсөн. Энэ чиглэлүүдийн хэрэгжилт өнөөдөр 50 хувьтай байх ёстой. Тэр маань юу болж байна вэ. Яагаад гэвэл бид нар үүний хэрэгжилтэд бараг тулгуурлаж, 2026 оныхоо төсвийг ингэж хийгээрэй, энэ хүрээнд хийгээрэй гэдэг чиглэлийг, тоог өнөөдөр баталж, Улсын Их Хуралд өгөх гээд байдаг. Үүний маань хэрэгжилт ер нь ямар байгаа талаар уг нь бол энэ төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг өргөн барихад ядаж 50 хувийнх нь тайланг өргөн барьчихсан бол их зүгээр байсан юм. Тэгээд би энэ хэдийг асууя гэж бодож байгаа юм.

Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгоно гэсэн. Энэ өнөөдөр Улсын Их Хуралд өргөн баригдаагүй. Хэрвээ Улсын Их Хурлаар энэ хаврын чуулганаар ганцхан сарын л хугацаа байх шиг байна. Өргөн баригдаад батлагдаад татварын орчныг жишээлбэл сайжруулахад төсвийн орлого буурах, нийгмийн даатгалын реформ энэ тэр хийгдэх юм бол бас сангийнх нь орлого буурах ийм болоход та хэд төсвийн хүрээгээ өөрчлөх юм уу. Гэтэл 3 сарын хугацаанд бол өөрчлөхгүй гээд бид нар бас хуулиа баталчихсан. Тэгээд үүнийгээ яая гэж бодож байгаа юм бэ.

2 дахь нь энэ бас тогтоолоор өгсөн бүртгэлийг сайжруулах ерөнхийдөө бол аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх орчныг сайжруулах гэдэг энэ ажлууд маань хэдэн хувьтай явж байгаа вэ. Ашигт малтмалын нэгдсэн бүртгэлийг сайжруулна гэсэн. Дээрээс нь нэмээд ахиад төрийн өмчит компанитай холбоотой нэлээдгүй үүрэг чиглэлүүд өгсөн. Олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдийг хамтран тэдгээрийн засаглалыг сайжруулна гэсэн. Бүтэц, орон тоог нь сайн буулгана, зардлыг бууруулна гэсэн. Тэр ер нь хэдэн хувьтай хийгдсэн байгаа юм бэ. Түүний үр дүн өнөөдөр манай төсвийн хүрээн дээр яаж та бүхэн үр дүнг нь 2025 ондоо юу хийгээд, 2026 онд төсвийн хүрээн дээр хэрхэн яаж сайжирч орж ирж байгаа, зардлаа бууруулж байгаа, орлогоо нэмэгдүүлж байгаа гэж хэдэн хувиар нь яаж тооцсон байгаа юм бэ гээд асуух юм бол яг үнэнийг хэлэхэд нэлээн олон тоонуудыг та бүгдээс асуумаар байна.

Дээрээс нь энэ тогтоол дээр бас нэг өгсөн юм нь улсын төсвөөс өгч байгаа олон татааснуудыг олгож байгаа бүх төрлийн татаас урамшууллын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөлөл судалгаа хийх ёстой гэсэн. Энэ бол 50 хувь хийгдчихсэн байгаа байх гэж би бодож байна. Яагаад гэвэл энэ тогтоол батлагдсанаас хойш яг хагас жил өнгөрсөн байна. 50 хувь хийгдсэн байгаа байх. Үүний үр дүн та бүхэн 2026 ондоо татаасаа ер нь яаж бууруулна гэж төсөвлөж энэ төсвийн хүрээн дээрээ оруулж ирсэн байгаа юм бэ. Ингээд 2010 онтой харьцуулах юм бол би сая ингээд хэдэн жилийн тоог аваад үзэхэд 2020 онд төсвийн нийт зарлага 13,9 их наяд байжээ. 2026 онд та бүхэн 33,5 их наяд буюу 6 жилийн хугацаанд 20 орчим их наядар нэмэгдүүлж орж ирж байгаа юм байна. Тэгээд би энэ татаас, эдийн засгийн үр өгөөж гэдгийг сая 2025 оныхоо төсвийг батлуулж байхдаа та бүхэн энийг ер нь зайлшгүй харж авч үзэхгүй бол татвар гэдгээ арай өөр, төсөв гэдгээ арай өөр нүдээр харахгүй бол болохгүй нь гэж байсан. Энэ бүгд маань .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яам, Энх-Амгалан дарга 4 дүгээр индрээс хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Энэ тооцооллууд яаж хийж байгаа вэ, засаг дээр хийгдэж байгаа

ажлуудынхаа нөлөөг яаж оруулж байгаа вэ гээд нэлээн өргөн хүрээтэй асуулт асуусан. Тэгэхээр би төсвийн хүрээний мэдэгдлийг хийхдээ яг тооцоолууд хийгддэг дарааллыг нэлээд дэлгэрэнгүй танилцуулъя.

Хамгийн эхлээд төсвийн орлогоо тооцохоос эхэлдэг. Зарлагаа биш. Орлогоо тооцохдоо бол эдийн засгийн өсөлт болон инфляц, бусад гадаад, дотоод орчин нөхцөлийг харгалздаг. Тэгэхдээ хамгийн эхлээд уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуй, түүнийг дагасан боловсруулах салбарууд, тэгээд эрчим хүч, барилга болон бусад аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбаруудыг салбар тус бүрээр нь хариуцсан яамтай нь тухайн салбаруудад хувийн болон улсын хөрөнгөөр ямар гол ажлууд хийгдэж байгаа вэ, тэрний нөлөөллүүд хэдэн онд яаж орж ирэх вэ гэдгийг илүү нарийвчлан яг бодит эдийн засаг талаас нь судалдаг. Ингэхэд мэдээж бидний тооцсон төлөвлөгөөнөөс ажлууд хоцорч хэрэгжих, түрүүлж хэрэгжих олон юмнууд болдог. Тэгэхээр тэр хэрээр бидний тооцоо хугацааны хувьд наана цаана, нөлөө нь наана цаанаа орох, заримдаа жил дамнаж орох гэсэн ийм олон үйл явдлууд болдог гэдгийг хэлье.

Тэгээд төсвийн зарлагын тухайд бол урсгал зардал бол ДНБ-ий 26, 27 хувьтай тэнцүү байгаа. Энэ бол ковидын өмнө бол 22 хувьтай байсан ийм тоо. Тэгэхээр энийг үе шаттай бууруулаад, дараа жил 24 хувь, тэгээд 2027 онд 23 хувь, цаашаа Жи Ти Пи-ийн 22 хувь буюу ковидын өмнөх тэр тэнцвэр лүү аваачъя гэж байгаа юм.

Манайхны танилцуулж байгаа ихэнх танилцуулгууд ихэвчлэн ДНБ-тэй жишсэн харьцаагаар илүү танилцуулаад байдаг. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг нь болохоор доторх задаргааг нь нарийн хийхгүй. Гэхдээ яг макро эдийн засгийн тэнцвэрээр ямар харьцаатай байвал илүү зохистой юм бэ гэдгийгээ илүү онолын түвшинд тодорхойлдог гэсэн үг. Тэгээд тэр зохистой түвшин рүүгээ одоо хазайчихсан байвал яаж үе шаттай шилжих вэ гэдэг энэ хандлагыг л төсвийн хүрээний мэдэгдлээр илүү түлхүү оруулдаг юм. Тэгэхээр яг дотогшоо орсон тэр төрийн бүтээмжийг сайжруулах энэ тэр гээд олон асуултын нөлөөг бол энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд хариулахад төвөгтэй. Энэ бол яг төсөв дээр цаашаагаа яам ямаараа задраад явахдаа илүү хариулагдах боломжтой. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол илүү тэнцвэртэй байдал, тогтвортой байдал, цаашдын хандлага, бодлогын чиглэл гэдэг иймэрхүү агуулгуудаар тоонуудаа бид нар тайлбарладаг байгаа.

Нийгмийн хамгаалал тэтгэвэр, тэтгэмжтэй асуулт асуусан. Ковидын өмнө яг нийгмийн хамгааллын тэтгэвэр тэтгэмж бол ДНБ-ий 2,2 хувьтай тэнцэж байсан байгаа юм. Тэгэхээр энэ бол ковидын үе .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу. Энх-Амгалан даргад 1 минут нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмжийн зардал бол ковидын жилүүдэд нэлээд өсчихсөн. ДНБ-ийхээ 3 хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд өсчихсөн. Энийг бол Нийгмийн хамгааллын яамтай нэлээд ярьсан. Тэгээд 2026 онд бол энийг 2,5 хувь руу дөхүүлж буулгах, тэгээд улмаар 2028 ондоо ковидын өмнөх түвшиндээ очиж, яг тэр тэнцвэр лүүгээ буцаж очих нь зүйтэй юм гэдэг ийм бодлогын чиглэл өгөөд, тооцоололд оруулсан байгаа.

Тэр олон татаастай холбоотой асуудал байдаг. Ялангуяа хөдөө аж ахуйн салбарт хэрэгждэг маш олон 10 гаруй төрлийн татааснууд байдаг. Тэр олон татааснууд дээр бол олон улсын байгууллагууд судалгааны байгууллагууд тодорхой судалгаа хийгээд дүгнэсэн судалгаанууд зөндөө байдаг. Ихэнх татааснууд нь анх Улсын Их Хурлаас өгөгдсөн зорилгодоо хүрээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээнд нийцэхгүй байна гэсэн тийм дүгнэлтүүд байдаг. Тэгэхээр Булгантуяа гишүүн дээр байгаа ажлын хэсгийн хувьд тэр судалгаануудыг аваад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга нэмж хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Булгантуяа гишүүний хөндөөд байгаа асуудал бол чухал асуудал. Төсөв дагаж гарсан тогтоолын хэрэгжилтээ та нар яаж байна. Хагас жил болчихлоо. Төсвөө хэрэгжүүлээд, гүйцэтгэл хийгдээд гээд. Тэгээд энэ чиглэл дээрээ бас анхаарах зайлшгүй шаардлага байгаа юм. Сая өмнөх Байнгын хорооны хурал дээр Их Хурлаас өгөгдсөн чиглэл, Засгийн газрын хэрэгжилтийг хангаж байгаа байдлыг танилцуулахад байна шүү дээ. Хууль, тогтоолын хэрэгжилт, Их Хурлаас өгсөн чиглэлийн биелэлт 66 хувьтай байгаа байхгүй юу. Тийм учраас Их Хурал энийг ер нь анхаарч шаардаж байхаас өөр арга байхгүй. Их Хурлын тогтоол, шийдвэрийг үл тоож байна гэсэн үг шүү дээ энэ Засгийн газар. Тэгээд асуугаад байгаа зүйл бол яах вэ, төсвийн шинэчлэл, ялангуяа бид нарын тэр 52 дугаар тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу төсвийн зарлагыг цаашдаа бууруул гэснийг бол бууруулж байгаа юм байна лээ. Одоогийн 2026 оны төсөөлөл бол 2025 онд төсөөлж байснаас бол буурсан /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн даргад минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Ц.Даваасүрэн: 2025 оны батлагдсан түвшинд царцаасан байгаа. Орлого, зарлага 2-ыг бол. Яг 2025 оны түвшинд нь өсгөөгүй. Булгантуяа гишүүний тэр нарийвчилж асуугаад байгаад бас та нар хариулах хэрэгтэй. Одоо ингээд татварын реформын ажлын хэсэг гээд байж байна. Тэтгэврийн реформын ажлын хэсэг гээд байж байна. Энэ бүгд чинь татварын орлогыг, НДШ-ийн орлогыг бууруулахаар байгаа шүү дээ. Энийгээ яаж тооцож байгаа юм бэ гэж асуугаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нь бас та бүгд бас жоохон тодорхой хариулах ёстой. Яагаад гэвэл орлогоо бууруулаад явахад ямар эрсдэл төсөвт байгаа юм бэ. Төсөөлөхөд ямар байгаа юм бэ гэдэг зүйлийг чинь та нар төсөөлөл хийж байгаа юм чинь бас тооцсон л байх ёстой л доо. Тэгэхээр энийг бол нарийвчилсан хариултыг энэ төсвийн хүрээний мэдэгдлээ боловсруулсан байгууллага нь Эдийн засаг, хөгжлийн яаманд өгөх хэрэгтэй. Ийм 2 реформ хийнэ. Яах юм бэ гээд байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан 4 дүгээр индэр. Тодорхой хариулаарай.

Л.Энх-Амгалан: Татварын реформуудыг бол хийхээр төсвийн хүрээний мэдэгдэл орон зайг нь гаргаж тооцсон байгаа. 2025 онд бол ДНБ-ий 34, 35 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн орлого төвлөрүүлнэ гэж төлөвлөсөн байгаа. Тэгэхээр цаашдаа яг хуулийн төслүүд эцэслэгдээгүй байгаа болохоор нарийн тоог хэлж мэдэхгүй байна. Гэхдээ төсвийн хүрээний мэдэгдэлд бол 2026 онд ДНБ-ий 32 хувьтай тэнцэх хэмжээний орлого төвлөрүүлнэ гэж, Жи Ти Пи-ийн 2 хувьтай тэнцэх хэмжээний орон зайг үүсгэж өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ дүнтэй тэнцүүлсэн хэмжээний татварыг бууруулах орон зай тооцогдсон гэсэн үг. Тэгэхээр 2027 оны хувьд бол ДНБ-ээ 30,4 хувь болгож мөн орон зайг нэмэгдүүлж өгсөн байгаа.

Цаашаагаа татварын реформ нь 1 жил хэрэгжихгүй. Үе шаттай цаашаа орон зай хэрэг болно гэж тооцсон учраас. Тэгээд 2028 оны хувьд бол 29,6 болгож бууруулсан байгаа. Энэ нь мөн 2028 он. /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Миний асуултыг бүр ойлгохгүй сүүлдээ Даваасүрэн дарга ашгүй тодруулж өглөө. Би тэгээд байгаа шүү дээ. Өргөн бариагүй байгаа татварын реформ, нийгмийн даатгалын чинь реформ аль аль нь төсвийн орлого дээрээ үр дагавартай байх байх. Тэр чинь хэрэгжвэл хаврын чуулганаар эсвэл намрын чуулганаар батлагдвал 2026 оныхоо төсөв дээр энэ төсвийн хүрээнийхээ хүрээнд авч хэрэгжүүлж чадах юм уу, үгүй юм уу гэдэг асуултыг асуугаад байгаа юм. Тэгээд сүүлдээ бүр тэтгэвэр хэд вэ гэдэг асуултад хариулаад байх юм. Сангийн яамнаас Санжаадорж дарга та нэг хариулаад өгөөч.

Д.Амарбаясгалан: Санжаадорж хариулах уу, Тэлмүүн хариулах юм уу.

Х.Булгантуяа: Эсвэл Ганбат дарга хариулах уу. Нийгэм энийг чинь маш их хүлээгээд байгаа байхгүй юу. Яагаад гэвэл энийг одоо та нар чадахгүй гэвэл 2025 онд энэ угаасаа хэрэгжихгүй юм байна. 2026 онд ард түмэн татварын болон нийгмийн даатгалын реформ хүсэн хүлээгээд хэрэггүй юм байна. Энэ чинь тэртээ тэргүй дандаа мөнгөтэй уялдаж байгаа юм чинь гэдгээ эсвэл эртхэн шиг хэл гэж л хэлэх гээд байгаа байхгүй юу. Чадах юм уу, үгүй юм уу.

Д.Амарбаясгалан: Санжаадорж дарга энэ дээр их тодорхой хариулахгүй бол одоо татварын реформ хийнэ гээд иргэд бол татварын хөнгөлөлтүүд орж ирнэ гэсэн хүлээлттэй байгаа. Мэргэжлийн хүмүүс хувийн хэвшлийнхний энэ олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж шүүмжилж байгаа өнцгүүдийг харахаар татварын реформ нэрийн доор татварын төрлийг нэмэх гээд байна буюу Булгаа даргын болгоомжилж байгаа төсвийн орлогын тасалдал үүсэх үү, үгүй юу гэдэг асуудал асуугаад байна шүү дээ. Тэгэхээр яг явж байгаа реформ дээр чинь орлого тасалдах биш бүр нэмэх тийм бодлого яваад байгаа юм биш үү. Энийгээ бас тодорхой хариулахгүй бол сүүлийн үед бизнес эрхлэгчид энэ чиглэлээр их шүүмжилж яриад байгаа шүү дээ. Энэ дээр сайн, тодорхой хариулт өгчих.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Булгантуяа даргын асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдэл бол одоогийн батлагдсан хууль, тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл бол номинал дүнгээс гадна ДНБ-д эзлэх хуваарь байгаа. Номинал дүн гэдэг бол яах аргагүй түрүүний хэлсэн тэр нүүрсний үнэ, зэсийн үнэ гэх мэт манай гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн тооцооллоор гарч ирж байгаа орлого гэсэн үг. Энэ дээрээс орлого бууруулах асуудал бол тооцогдоогүй гэсэн үг. Татварын реформ. Ер нь бол зүгээр намрын төсөв хамгийн хүнд зүйл нь юун дээр очиж тулах вэ гэдэг дээр бол яг мэргэжлийн хүний хувьд бид юу гэж харж байгаа вэ гэхээр энэ жилийн төсөв, ирэх жилийн төсөв 2 яг ижилхэн болчихоод байгаа. Дүн нь ижилхэн. Тэгэхээр бид нар хэрвээ цалин хөлс нэмье гэх юм бол тодорхой хэмжээнд зардал бууруулах хэрэгтэй болно. 1-1,5 их наяд төгрөгийн зардал бууруулна. Тэгж байж бид нар цалин хөлс нэмэх ийм орон зай гаргана. Энэ дээр нэмээд хэрвээ бид нар орлого бууруулах үр дагавартай нийгмийн даатгалын реформ, татварын реформыг хэрэгжүүлбэл дахиад тэр хэмжээгээрээ зарлага бууруулах ийм зүйл хийнэ гэсэн үг болчихож байгаа.

Зарлага бууруулах асуудал дээр бол Сангийн яам хамгийн эрүүлээр энэ зүйлийг хийхийг 100 хувь дэмжиж ажиллаж байгаа. Гэхдээ зарлагыг бид нар механик байдлаар шууд 20 хувиар бууруулна гэдэг юм уу, 10 хувиар бууруулна гэдэг юм уу, төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулна гэсэн зүйлийг бол бид хийж чадахгүй. Энийг хийхээ тулах юм бид нар ямар нэгэн төлөвлөгөөтэй орж ирэх ёстой. Энэ дээр тодорхой хэлэх юм бол 1 дүгээрт бид нар чиг үүргийн шинжилгээг бол хийх шаардлагатай байна. Одоогийн хуулиудаар болох юм бол 208 хуулийн 1028 заалтаар бид нарт төсвийн ямар нэгэн орлогыг оноочихсон байгаад байна. Өөрөөр хэлбэл төр өөрийнх нь нуруун дээр маш их ачаа үүрч байна гэдэг нь харагдаад байна.

Чиг үүргийн шинжилгээний дараа бид нар реинженеринг гэдэг зүйлийг эрхлэх хэрэгтэй байна. Энэ чиг үүрэг үнэхээр төрийн чиг үүрэг юм бол үүнийг бид нар хэрхэн хамгийн иргэнд ээлтэй байдлаар үр ашиг өндөртэйгөөр буюу зарлага багатайгаар бид нар хийж чадах вэ гэдэг энэ зүйлийг хийх хэрэгтэй байна. Үүний дараа бид нар харин орон тоо бууруулах гэдэг юм уу энэ асуудлыг энэ үндэслэлүүдтэйгээр судалгаан дээр гаргаж ирж зардлыг бууруулах боломжтой гэж харж байгаа. Энэ дагуугаа бол ажиллаад явж байгаа. Үндсэн жил бол энэ жилийн мөрдөгдөж байгаа хуулийг батлахдаа бол Улсын Их Хурлаас 2 тогтоолоор үүрэг чиглэлүүд өгсөн. Энэ үүрэг тогтоолын чиглэлүүдийн хүрээнд бид Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэгтэй хамтарч маш нягт ажиллаж байгаа. Бид бол үүсэж байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор бүх зүйлүүдийг нэлээд дэлгэрэнгүй гаргаж тавьж байгаа. Намрын төсөв дээр бас энэ гаргаж тавьсан асуудлуудтай холбоотойгоор бас нэлээд асуудлууд нь давхар шийдэгдэж орж ирэх болов уу гэсэн ийм байдлаар бол ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Булгантуяа дарга тодруулж асууя.

Х.Булгантуяа: Яг нөхцөл байдал бол ийм байгаад байгаа юм гишүүд ээ. Одоо нөгөө батлагдсан хуулийн хүрээнд төсвийн хүрээгээ хийсэн учраас шинэ реформ, татварын реформ, нийгмийн даатгалын гэдэг юмнууд нь батлагдаагүй учраас энэ бол манай өнөөдрийн батлах гэж байгаа төсвийн хүрээнд бол тусаагүй. Тусгах бас нөгөө талдаа хэрвээ тусгана гэх юм бол Сангийн яамны хэлж байгаагаар орлого бууруулаад, дахиад дээрээс нь нэмээд өнгөрсөн онтой зарлагаа нэмэхгүй гэх юм бол энэ бол маш хүнд байдалд хүрнэ гэсэн юм болчхоод байна шүү дээ. Хаврын чуулган тун удахгүй дуусах гэж байна. Энэ хаваржингаа энэ бүгдийгээ өргөн бариад, хэлэлцүүлчихгүй дээ. Тэгсэн бол төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд та бүхэн маань тусгаад 2026 оноос хэрэгжээд явах уг нь боломжтой байсан юм.

Дээрээс нь бас манай Төсвийн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга 2-т Засгийн газрын зүгээс энэ олон ажлуудыг уг нь та хэд 2025 оны 2 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэдэг үүрэг чиглэлийг Засгийн газар авсан байсан. Тэгээд энэ бүгдийгээ уг нь ингээд хийчхээд, энэ реформуудаа хийчхээд, төсвийн хүрээнийхээ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль орж ирж байна л даа. Эрүүл мэндийн салбарын талаар би 5 дахь жилдээ ярьж байгаа юм. Төсвийн хүрээний мэдэгдэл байна. Төсөв ярихдаа

ярь гэдэг. Гэтэл энэ салбарын тусламж, үйлчилгээний чанар, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, ажилчдын нийгмийн асуудал ер нь дордож байна.

Цалин хөлсийг нэмэх тал дээр үндсэн цалингийн сүлжээг 1 дахин нэмэх юун дээр тусгадаггүй юм уу ерөөсөө. Одоо эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүд дутагдалтай байна. Бүгд цалин бага, ажлаа голж байна. Одоогийн инфляц, юмны үнийн өсөлттэй холбоотой ажиллах боломжгүй болсон. Ерөөсөө хамгийн хүнд нөхцөлд ажилладаг эмнэлгийн асрагч нар 8 цаг ажиллаж байна шүү. Шөнө цэвэрлэдэг асрагч нар байхгүй байна. Хотын эмнэлгүүдээ хараарай. Үүгээр эмнэлгийн дотоод халдвар ихсэх аюул үүсэж байна. Тийм учраас энэ эмнэлгийн ажилчдын цалинг нэмэх тал дээр тусгадаггүй юм уу Эрүүл мэндийн сайд энэ талаар юм тавиагүй юм уу. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд нийлж байж энэ асуудлыг шийддэггүй юм уу. Энэ талаар нэмэх тал дээр баримталж байгаа бодлого байна уу. 1 дүгээрт.

2 дугаарт эрүүл мэндийн үндэсний салбар, эм зүйн алба үүсээд 100 жил болоход Үндэсний эмийн үйлдвэр байхгүй. Стратеги, төлөвлөгөөнд энийг тусгадаггүй юм уу. Энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Энэ талаар баримталж байгаа бодлого байна уу.

Малын түүхий эдийн асуудал байж байна. Бас л хаягдах юм байна л даа. Баруун бүс Ховдод гэсэн тэр баригдтал наад зах нь эсгийний үйлдвэр, малын дотор эрхтэн боловсруулах жижиг оврын үйлдвэрүүд барихгүй бол ерөөсөө энэ талаар стратеги төлөвлөгөөндөө тусгаад, малын түүхий эд боловсруулах тал дээр баримталж байгаа бодлого байна юм болов уу.

Сэргээгдэх эрчим хүчний талаар Чойжоо сайд би урьд нь бас ярьж байсан. Бид эрчим хүчний зохицуулах газар, Их сургуулийн сэргээгдэх эрчим хүчний тэнхимтэй хамтраад Бээжингийн Банжин технологи компани 100 хувь хөрөнгө оруулалт хийгээд, 100-10 мянган Мвт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүч барьж өгье гэсэн. Зөвхөн дотооддоо эрчим хүчний борлуулалт дээр нь танай Засгийн газартай тохиръё гэсэн. Тантай уулзсан уу энэ хүмүүс. Би танд бас санал болгож хэлсэн, Их Хурлын даргад хэлж байсан, Ерөнхий сайдад хэлж байсан. Зээл биш энэ чинь. Хөрөнгө оруулалт хийгээд, борлуулалт дээр нь тохироод 15, 20 жил юм уу дараа нь Монгол Улс засвар хийж бүрэн хүлээлгэж өгөх асуудал дээр хөрөнгө оруулалт хийсэн компанийн улсын энэ сэргээгдэх эрчим хүчний газар, Их сургуулийнхан энэ тэр бүр очоод сургалтад суугаад, тэгээд энэ Засгийн газартай гэрээ хийхээр ирсэн. Энэ талаар таны энэ сэргээгдэх эрчим хүчний талаар зээл авна гээд ярьж байна л даа. Энэ чинь хэчнээн сая долларын зээл болох юм. Нөгөө саяын компаниуд тантай уулзсан уу энэ талаар асууя. Дараа тодруулъя.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Бейсен гишүүний асуултад хариулъя. Надтай таны энэ яриад байгаа компани уулзаагүй байна 1 дүгээрт.

2 дугаарт бид нар дотооддоо 10 мянган Мвт буюу 10 гегаваттын ийм цахилгаан эрчим хүчний хэрэглээг шингээх хэрэглээ байхгүй. БНХАУ-ын талаас би эрчим хүчний сайдтай нь саяхан уулзсан. Хятадын талаас ийм Хятадын компаниуд нэн ялангуяа энэ дотор төрийн өмчтэй компаниуд дотроос ч ийм санаачилга гараад байна. Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бариад, Хятад улс руу

экспортольё гэсэн ийм санал тавиад байгаа. Танай Хятадын сүлжээнүүд энд ийм хэрэглээг хүлээж авахад бэлэн үү гэдэг ийм асуулт тавьсан. Бид судалъя гэсэн 1 дүгээрт. Ер нь шаардлагатай бол бид нар бизнесийнхээ загвар, бид нар ямар эрх зүйн орчин бий болгох юм та нар ямар нөхцөлтэйгөөр худалдаж авах вэ гэдгээ тодорхой болгоё гээд манай талаас хэрвээ та бүхэн энэ саналыг дэмжиж байгаа Монгол Хятадын хамтарсан ЭХЯ-уудаас нь эрчим хүчний салбарынхныг оруулаад хамтарсан ажлын хэсэг байгуулаад, дүгнэлт гаргая гэдэг ийм яриатай л байгаа.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Сая эрүүл мэндийн салбарын нийгмийн асуудал, цалингийн нэмэгдлийн асуудал байна л даа. Монгол Улсын иргэд маань эрүүл байж байж Монгол Улсаа хөгжүүлэх ёстой. Гэтэл эрүүл мэндийн салбарынхны цалин хар. Аргацаасан, өдөр өнгөрөөсөн бага цалинтай. Хамгийн их цус, шээс, баастай холилдсон асрагч нарын цалин нь бага. Ажилчид нь олдохгүй. Энийг нэмэх тал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, Эрүүл мэндийн яам баримталж байгаа бодлого байна уу гээд асуусан. Дахиад асууя даа.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ. Эдийн засаг, хөгжлийн яам. За Сангийн яамны Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Бейсен гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэх талаар ямар бодлого барьж байгаа гэж асууж байна. Одоо бол 1 талдаа бид нар зарлага гаргахын тулд орлогоо бас бодох хэрэгтэй. Одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр батлагдаж байгаа орлого, зарлага маань бол үндсэндээ энэ жилийн түвшинд байна гэсэн үг. Тэгэхээр зарлага нэмэх боломж байхгүй байна гэдэг нь харагдчихаад байна.

Тэгэхээр ийм нөхцөлд бид нар юу хийх ёстой вэ гэхээр бүтээмж гэдэг 1 л зүйлийг ярих хэрэгтэй болчихоод байна гэсэн үг. Эрүүл мэндийн салбарын төсөв бол сүүлийн 4 жилийн хугацаанд 1 их наяд гаруй төгрөгөөр нэмэгдсэн. Хөрөнгө оруулалттайгаа нэмэгдээд. Одоо энэ нэмэгдсэн төсвөө харин яаж зөв хуваарилах вэ гэдэг асуудал туйлын чухал болж байна. Анхан шатын буюу өрхийн эмнэлэг болон сумын эмнэлгүүдэд бид нар ямар өвчин эмчилгээгүй явуулах вэ, урьдчилан сэргийлэх ямар тусламж, үйлчилгээгээ үүгээр дамжуулах вэ гэдгийгээ зөв хуваарилах ёстой. Энд хуваарилж байгаа зардал бол хэдий хэмжээний бага байна нөгөө талдаа 3 дугаар шатлал дээр бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Тэгэхээр бүтээмжийн хүрээнд бол одоогийн байгаа төсвөө зөв хуваарилах замаар цалин хөлсөө нэмэгдүүлэх боломж байна гэж бид харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ цалин хөлс нэмэгдүүлэх юм тусгахгүй бол энэ эмч, мэргэжилтнүүд, сувилагч нар байхгүй болж байна шүү. Яг хэчнээн хувиар нэмэх юм. 50 хувь юм уу, 1 дахин нэмэх юм уу. 1 дүгээрт.

2 дугаарт Үндэсний аюулгүй байдалтай холбоотой Үндэсний эмийн үйлдвэртэй байх ёстой бид нар. Энэ дээр тодорхой төлөвлөгөө байна уу. Ер нь Эрүүл мэнд яамнаас, Засгийн газраас оруулж ирсэн эмийн үйлдвэрийн тал дээр баримталж байгаа бодлого, төсөв 2027-2028 онд тусгасан уу.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны стратегийн баримт бичгийг батлах тухай асуудал орж ирсэн байгаа. Тэгээд ер нь яг ард иргэдийн амьдралын чанар өдрөөс өдөрт муудаж, эдийн засгийн нөхцөл байдал суларч байгаа энэ үед хийж байгаа төсөөллүүд маань хэтэрхий тийм өөдрөг байдлаар оруулж ирээд байгаа юм биш үү. Энэ 2026 онд гэхэд бол хэрэглээний үнийн түвшинг 7 хувь байна гээд ороод ирсэн байгаа шүү дээ. Тэгээд 2027 онд 6,4, 2028 онд 6 хувь. Энэ жилийн 2025 оны хувьд 2024 онд төсөвлөж орж ирсэн чинь ямар зөрүүтэй байгаа юм. Төсөөллөөс чинь ер нь зөрсөн юм уу. Эсвэл яг мөргөлдөж байгаа юм уу. Энэ дээр хариулт авмаар байна.

Тэгээд 2 дугаарт гэх юм бол дахиад л ярихад нөгөө нүүрсний үнэ чинь унаад, одоо 75 долларт очно. 2026 онд гэсэн байгаа. Тэгвэл та хэдийн маань тооцоогоор яг хэдэн доллароор тооцсон байгаа юм бэ энэ үнийн дүнг. Түүрүүн Байнгын хорооны дарга бас хэлж байна шүү дээ. 4 сарын байдлаар эхний 4 сарын байдлаар 1,3 тэрбум долларын ноднингийнхоос зөрүү гарчихсан байна. Энэ чинь жилийн эцэс гэхэд бараг 5 тэрбум долларын зөрүү гарах гээд байна. Тэгвэл энэ зөрүү яаж тусах юм.

3 дугаарт 2026 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлээд аж ахуйн нэгж, байгууллагын дулааны тарифыг нэмж байгаа. Аж ахуйн нэгж, байгууллага 73 хувь, айл өрхийн дулаан 100 хувиар нэмэгдэж байгаа. Тэгээд бас халуун, хүйтэн ус, бохир усны үнийг 2 дахин нэмж байгаа. Үгүй ээ, ингээд энэ бүхнийгээ зарлачихсан. Тэгэхээр энэ зарласан зүйлүүдээс гадна бид нар харж байна шүү дээ. Хоёрхон хоногийн өмнө шатахууны үнэ нэмчихлээ. Тэгэхээр энэ бензин шатахууны үнэ нь инфляцад нөлөөлөх юм уу. Энэ дээр бас тодорхой хариулт авъя.

Тэгээд 2025 оны төсөвт инфляцын түвшнийг 6 хувь байхаар тооцсон байгаа. Тэгээд цалин, тэтгэврийг бол 6 хувь нэмэгдүүлсэн юм. Тэр хэмжээгээрээ. Үндэсний статистикийн хорооноос мэдээ авлаа л даа. Тэр мэдээнд болохоор 2025 оны 4 дүгээр сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 8,6 хувиар өссөн гэж байгаа. Бүсээр нь авч үзэх юм бол бүр энэ нь бол бүр тодорхой байгаа. Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ бол 18,4 хувиар, хүнсний бус бүлгийн үнэ 10,9 хувиар өссөн. Хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Тэгэхээр бид нарын нөгөө тооцоод байгаа 6 хувиас чинь бол ийм асар их зөрүүтэй байгаад байна шүү дээ. Тэгэхээр хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ингэж өсөж байгаа нь ард иргэдийн амьдралд бол хүндээр нөлөөлж байгаа юм. Тэгэхээр ард иргэдийн амьдралд энийг яаж тэнцвэржүүлэх вэ гэхлээр гар дээр ирж байгаа цалин нэмэгдэж байж энэ өндөр инфляц, энэ өндөр хэрэглээгээ давах боломжтой болно. Тэгэхээр цалин хөлсний талаар ирэх онд хэдэн хувиар нэмэх бодлого байгаа юм бэ. Энэ хэдэн асуултад яг тодорхой хариулаад өгөөрэй. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан 4 дүгээр индрээс хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Инфляц 2025 оны хувьд төсөөлж байсан дүн болон одоогийн гүйцэтгэл ямар байна вэ гэж асуулаа. 2025 онд бол бид яг төсвийн хүрээний мэдэгдлийн энэ хууль дээр жилийн дундаж нь 7,2 хувь байхаар батлуулсан байдаг. Одоо бол инфляц 8,6 хувьтай байгаа. Бидний тооцсоноос бага зэрэг өндөр. Өндөр байгаа шалтгаан нь бол манайх руу орж ирдэг валютын урсгал багассантай холбоотой. Ханш хөдөлсөнтэй холбоотой бага зэрэг хөдөлгөөн орсон. Дээр нь нэмээд эрчим хүчний тарифын шинэчлэлтэй холбоотой нөлөөнүүд орж ирсэн байгаа.

Дараа жилийн хувьд бол 7 хувиар тооцож байгаа инфляцыг. Тэрний дараа жил 6,4, 6 гээд ингээд үе шаттай буурна. Инфляц нь өөрөө өрхийн бодит орлого, ялангуяа ядууралд маш нөлөөтэй үзүүлэлт байдаг учраас Засгийн газрын зүгээс инфляцыг бууруулах бодлогыг байнга баримталдаг. Тэр хэрээрээ холбогдох арга хэмжээнүүдийг бас төлөвлөж оруулж ирсэн байгаа.

Нүүрсний үнэ асуулаа. Нүүрсний үнийг 2026 онд бид 80 доллароор тооцсон байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хувьд бол 85 доллароор тооцсон. 85-ыг арай өндөр байж магадгүй өнөөгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулаад гэж үзээд, бид бууруулж авсан байгаа. Энэ хэрээрээ бидний оруулж ирсэн төсвийн орлого болон зарлагын хэмжээ ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал болгосноос 1, 2, 3 бүхэл их наяд төгрөгүүдээр дараалсан 3 жилүүдэд бага байгаа гэдгийг хэлье. Энэ төсвийн зарлагыг бууруулсантай холбоотой мэдээж төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Засгийн газар хоорондын инфляцын тооцоо зөрүүтэй байгаа. Тогтвортой байдлын зөвлөлөөс бол инфляцыг нэлээд өндөр тоог хэлсэн. Төсвийн зарлагыг бууруулж байгаа гэдэг нь эдийн засгийн нийт эрэлтийг хумих тийм нөлөөтэй байдаг. Тэр агуулгаараа инфляцыг бууруулах нөлөөтэй байдаг гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн тодруулж асууя.

Ж.Баясгалан: Тэгээд гүйцэд хариулсангүй. Түрүүн би хэлсэн. Нөгөө инфляцын түвшнийг 6 хувь гэсэн байгаа. Бүсээр нь аваад үзвэл энэ жил бол маш өндөр байгаа. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэвэл дараа жил дулааны үнэ дахиад нэмнэ. Дулааны үнэ дахиад нэмнэ. Дахиад иргэдийн нуруун дээр ачаа очно. Дахиад иргэдийн орлого багасаж байгаа. Дахиад дарамт болж байгаа. Аж ахуйн нэгжүүдийн хувьд үнийн өсөлт дахиад үүснэ. Тэгвэл энэ үнийн өсөлтийг чинь бид нар яаж багасгах юм бэ. Энэ бол эргээд л цалин нэмэх асуудал байгаа. Тэгвэл цалин дээр ямар нэгэн нэмэх тооцоолол орж ирсэн юм уу. Ирэх онуудад. 1 дүгээрт.

2 дугаарт гэх юм бол одоо яг байгаагаар 8,3 хувь гэж байна шүү дээ. 8,6 хувь гэж байна. Инфляц 7 хувь байх ёстой гэж тооцсоноо. Тэгвэл энэ чинь оны сүүлээр 9,3 хувь гээд танай яам тооцоо гаргачихсан байгаа. Монголбанкны ерөнхийлөгч чинь оны сүүлээр 2 оронтой тоо .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Инфляцын тооцоо Улаанбаатар болон улс гэж ялгаатай тооцоо гардаг. Энэ бол Үндэсний статистикийн хорооноос албан ёсоор зарладаг ийм статистик. Тэр нь 430 бүтээгдэхүүнийг хамруулдаг. Яг тэр 430 бүтээгдэхүүнийхээ үнийн түвшнээр индексжүүлээд зарладаг ийм албан ёсны

статистик байгаа. Цалинг бас хэт их нэмэх нь бас л эргээд инфляцаа нэмэгдүүлдэг ийм л сөрөг талтай. Цалинг яг зохистой түвшинд нь нэмэх ёстой байдаг.

Тэгээд инфляцыг яаж бууруулах юм бэ дунд хугацаанд гэж. Монголбанкны зорилт бол 6 хувь, 5 хувь гэж ингэж буурч байгаа. Засгийн газраас оруулж ирсэн Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол энэ хувиудыг 7 хувь, 6,4 хувь гэж бага зэрэг өндөр байгаа. Үүний цаана бол ялангуяа тэр үнэ чөлөөлөх бодлогууд бол хэрэгжинэ гэсэн энэ тооцооллуудыг шингээж өгсөн учраас Монголбанкны зорилт .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Уг асуудлыг хэлэлцэх хугацаа дуусгавар болсон байна. Гэхдээ 1 гишүүн үлдсэн учраас гишүүний асуулт, хариултаар асуудлыг хэлэлцэх хугацааг сунгаж байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Ирэх 3 жилийн үндсэндээ төсвийн хүрээний мэдэгдэл орж ирж байгаатай холбоотойгоор ер нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын орлого яаж өсөх вэ гэдэг энэ тоог ер нь яаж төсөөлж байгаа юм бэ. Инфляцыг бол 7 хувьд тавьсан байж байна. Бодит байдал дээр эндээ хүрэх байх магадлал муу гэж би бол харж байгаа. Цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын бусад зүйлүүд бол индекслэн нэмэгдэж байх ёстой. Зарим нь бол хуульчлагдсан. Тийм учраас энэ тал дээр бол зөвхөн инфляцаа хаах төдий л төсөөлж байна гэх юм бол энийг дэмжмээргүй байна. 1 жилдээ 6 хувь, 7 хувь цалин хөлс нэмсэн болоод л тэгэх юм бол энэ чинь огт бодитоор нэмэхгүй л гэсэн үг шүү дээ. Тийм учраас манай төсөв, санхүүгийн энэ бодлогынхон маань хөрөнгө оруулалт зээл гэхээсээ илүүтэйгээр яг бодит иргэдийн, аж ахуйн нэгж, байгууллагуудын зүйл дээр хүлээж байгаа гол иргэдийн хүлээж байгаа, сонгогчдын хүлээж байгаа энэ зүйл дээр ямар өөрчлөлт гарах юм бэ гэдгийг л хэлдэг баймаар байна. Ирэх жилүүдэд бол гадаадын зээлийн хүүгийн хөвөгч хүү рүү шилжиж байгаа гадаадын эх үүсвэрүүд бол нэмэгдэж орж ирнэ. Зардал нь өсөж орж ирнэ л гэсэн үг. Манай улсад банкны зээлийн хүү бараг дэлхийн дунджаас хамгийн өндөр байгаа шүү дээ. Жилийн 18, 20, бизнес нь бараг 30 хувьтай. Яг иргэд зах зээл дээр гарахаар банк, санхүүгийн байгууллагаас 50 хувийн хүүтэй, бүр цаашаа ломбард, өдрийн зээлээр явах юм бол бараг 80, 90 хувийн хүүтэй ийм улс гэж ер нь байдаг юм уу. Тийм учраас ирэх жилд зээлийн хүүг яаж төсөөлж байгаа вэ. Гаднын эх үүсвэрүүдийг тодорхой хэмжээгээр оруулж ирж, иргэдийн хэрэглээний, мөн ЖДҮ-лэлийн төслийн зээлүүдийг санхүүжүүлэх ийм боломж бололцоо хэр зэрэг байгаа вэ. Засгийн газрын өрийн хэмжээ гэдэг дээр л харагдсан байж байна. Нийт манай хувийн хэвшил, зарим орон нутгууд бонд гаргаад эхэлж байгаа. Энийг ер нь яг хэдэн хувьтай байж байгаа юм. ДНБ-ий нийтдээ хэдэн хувь гэж тооцож байгаа вэ. Энэ чинь эргээд л манай улсын валютын нөөц ханшид нөлөөлдөг учраас энэ тал дээр бол би тоо энэ дотроос олж харсангүй.

Дараа нь нэмэлт санхүүгийн эх үүсвэр бас харагдахгүй байна гээд бас түрүүн хэлж байх шиг байна. Өөдрөг төсөөлөл харагдахгүй байна гэж. Бидний яриад байгаа энэ стратегийн ордуудыг 10, 20 жилийн өмнө ингээд авчихсан компани, аж ахуйн нэгж, байгууллагуудаас роялти юм уу, эсвэл тодорхой төрд ноогдох хувиудыг авна гээд байгаа. Энэ дээр энэ орлогын төсөөлөл орж ирж байгаа юм уу, үгүй юм уу. Энийг юу гэж үзэж байгаа юм. Би бол энэ дээр нэмэлт ийм орлого орж ирнэ гэдгийг бол бараг туссан юм уу, үгүй юм уу гээд сайн харагдахгүй байгаад байна. Тэгээд энэ тал дээр бас хариулт хэлж өгөөч. Тэгээд ирэх жилүүдэд энэ валютын ханшийг хэд дээр байна гэж тооцож байгаа юм бэ. Яах вэ олон нийтэд хамаагүй, тэд болно, эд болно гэдэг байдлаар ингээд зарлахаар болдоггүй. Дунджаар валютын ханшийн

өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг юу гэж авч үзэж байгаа юм бэ. Цалин нэмэгдэхээр инфляц өсчихнө л гээд байдаг. Энэ бас нэг талаараа бол тийм биш шүү. 3 жил цалин нэмээгүй үед бол инфляц өсөж л байсан одоогийн хэмжээнд. Тийм учраас энэ тал дээр манайхан өөрсдөө ийм бодолтой байж болохгүй. Дээрээс нь энэ том төслүүд, том хөрөнгө оруулалтууд, зээлүүд, ЖДҮ-лэл эрхлэгч нар чанартай ажлын байр, иргэдийн бодит орлогод яг ямар нөлөөлөл үзүүлж байгаа юм бэ. Цөөхөн хүрээлэлдээ л үр өгөөжөө өгөөд, нийт иргэдэд өгөхгүй байна уу, үгүй байна уу гэдэг дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан дарга хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Өрхийн орлого, аж ахуйн нэгжийн орлого яаж өсөх юм бэ гэдэг асуулт асуусан. Яг бидний тооцоогоор бол өрхүүдийн бодит орлого бол 6-7 хувиар өснө гэж тооцоо хийсэн байгаа. Үүний цаана бол олон төслүүд хэрэгжиж байгаатай холбоотойгоор ерөнхийдөө зах зээл дээр ажлын байрны нийлүүлэлт өндөр байгаа. Ажиллах хүчний оролцооны түвшин гэж 1 үзүүлэлт байдаг. Тэр бол 2, 3 жилийн өмнө 55, 56 хувь болоод буучихсан байсан. Энэ эргэж өсөөд 61, 62 хувь руу оччихсон байгаа. Энэ хурдаараа төслүүд хэрэгжээд явбал ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувь руу буюу өмнө байгаагүй түвшин рүү 2026, 2027 он, 2028 ондоо оччих болов уу гэсэн бидний тооцоолол байгаа. Тэгэхээр энэ үзүүлэлтийн цаана бол нийт өрхүүдийн цалингийн орлого явж байдаг. Тэгэхээр өрхүүдийн цалингийн орлого бол нийт орлогынхоо 85-90 хувь дээр очих ийм төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр өрхүүдийн орлого илүү цалингийн орлоготойгоо уялдаатай болоод илүү баталгаатай орлогын эх үүсвэр нэмэгдэнэ гэж ингэж үзэж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан дарга нэмэлт хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Зээлийн хүү асуусан. Зээлийн хүү бол 17 гаруй хувьтай байна. Тэгэхээр зээлийн хүү буурах үндсэн нөхцөл бол яалт ч үгүй л макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдсан байх ёстой. Тэгэхээр үүний цаана бол зээлийн хүүгийн 60-70 хувь нь бол эх үүсвэрийн зардал байдаг. Эх үүсвэрийн зардал гэдэг нь хадгаламжийн хүү бууж ирдэг гэсэн үг. Хадгаламжийн хүүгийн суурь бол инфляц байдаг. Тэгэхээр инфляц 8, 9, 10 хувьтай байгаа тохиолдолд бол зээлийн хүү 17, 18 хувь дээрээ байсаар байна. Тэгэхээр дунд хугацаандаа инфляцыг 5 хувь, 6 хувь руу бууруулах зорилт тавиад байгаа нь өөрөө цаанаа зээлийн хүү буурах үндсэн нөхцөл бүрдэнэ л гэж харж байгаа юм. Тэгэхээр зээлийн хүү бол 1, 2 жилийн дотор бол тэгж буураад, огцом огцом буураад байхгүй. Инфляц буурч, макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдсан тохиолдолд зээлийн хүү буурах үндсэн нөхцөл бүрдэнэ.

Дээр нь нэмээд мэдээж гадаадын банкны хямд эх үүсвэр орж ирсэн тохиолдолд зээлийн эх үүсвэрийн нийлүүлэлт нэмэгдэж байж зээлийн хүү буурна. Тэгэхээр энэ 2 арга зам, ажил хэрэгжиж /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль 1 намын

бүлэгт харьяалагддаггүй гишүүд тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлэх боломжтой байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Тогтоолын төслийн хавсралтын 3.1 дэх хэсгийн “тавигдах шаардлага” гэснийг “тавих шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулж” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хурууны хээгээ уншуулна.

Ингээд Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 71 гишүүн дэмжиж, 68,3 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

11.49 цаг.

Дараагийн асуудалд орно.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж

дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн 1 саналын томъёоллыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авчихсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллын жигдлэх, хууль зүйн техникийн засваруудыг хийж тогтоолын төслийн эцсийн хувилбар болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Асуулт асууж, үг хэлэх гишүүд байхгүй. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Шууд санал хураалт руу орно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн чуулганы танхимд хүрэлцэн ирсэн байгаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Нийт 1 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэл хангая.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.14 дэх “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” төсөл арга хэмжээ нь мөн хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалтад байгаа төсөл, арга хэмжээтэй, агуулга, шалгуур үзүүлэлтийн хувьд давхцаж байгаа тул уг саналыг төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2.2 дахь дэд заалттай нэгтгэж, Зорилтот түвшин “30” гэснийг “100” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “17,500.00” тэрбум гэснийг “28,500.00” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Парламент бол хууль баталдаг. Хууль тодорхой хугацаатай байдаг. Жишээ нь Төсвийн хууль бол бүтэн жилийн хугацаанд хэрэгжих ёстой. Гэтэл төрийн хэмнэлтийн хууль бас байгаа. Тэр дээрээ бол бас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг тодорхой хугацаа заасан юм шиг байгаа юм. Үүнийх нь

дагуу Засгийн газрын тогтоол гараад, өөрөөр хэлбэл парламентын баталсан хуулиас давсан арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Энэ бол буруу. Парламентын эрхэд бүрэн халдаж байна гэсэн үг. Тэгээд энэ нь юу вэ гэхээр 6 сарын 1-ний дотор тендер болон худалдан авалтыг бүгдийг нь хийнэ. Тэрнээс цаашаа бол хурааж авна гэдэг энэ бол парламентын эрхэд халдаж байна гэсэн үг. Бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж байгаа тэр хуулийг Засгийн газар бид нар хэрэглэхгүй гэсэн үг. Тэгэхээр өнөө жилийн хувьд бүх худалдан авалтууд бүгдээрээ яамд дээр байгаа. Яагаад гэвэл энэ жил орон нутагтаа хөрөнгө оруулалтууд тавиагүй. Энэ ажлаа хийгээгүй бол яамнууд өөрсдөө буруутай гэсэн үг. Тэгэхээр энэ 6 сарын 1-ээс бүх хөрөнгийг буцаагаад татах юм байна. Энэ бол бид нарын эрхэнд халдаж байна гэсэн үг. Гэвч жишээ нь нэлээн олон хөтөлбөрүүд байгаа л даа.

Жишээ нь манай Бат-Эрдэнэ гэж сайд тухайн үед сайд байж байхдаа даахгүй нохой булуу хураана гэгчээр копыг Монгол Улсад хийнэ гэж ам гарснаасаа болоод, өнөөдрийн байдлаар татвар төлөгчдийн мөнгөнөөс 400 орчим тэрбум төгрөг гаргана гэсэн ийм тооцоололтой байгаа. Тэр нь дахиж нэмэгдэнэ. Тэгээд энэ жил 60 тэрбум зарцуулагдаж байгаа. Тэр мөнгөө өнөөдрийг хүртэл худалдан авалтыг нь хийгээгүй байгаа. Тэгээд энийгээ татаад явчих юм бол нөгөө олон улсад бид нарын авсан тэр үүрэг бол байхгүй болно. Тэгэхээр энэ копын 60 тэрбум бол явна гэсэн үг. Яагаад гэвэл ажлаа хийхийн тулд. Тэгэхээр ингээд 1 сайдын дураараа мэдэгдсэн тэр мэдэгдлээс болоод, ард түмний баахан мөнгийг зарцуулж, баахан дарга нар, цэрэг нар тэндээс ирж, хуралдаж, идэж уусан тэр төлбөрийг татвар төлөгчдийн мөнгөнөөс гаргачхаад жишээ нь Ховд аймагт 2 тэрбум төгрөг тавьсан байхад тэрийг нь хурааж авна гэдэг бол ерөөсөө байж болохгүй. Энэ бол Их Хурлын бүрэн эрхэд халдаж байгаа зүйл. Тийм учраас энэ асуудлаа цэгцлэхгүй бол Үндсэн хуулийн цэцэд өгнө. Дээрээс нь Их Хурлаас тодорхой тогтоол бид нар бас санаачилж гаргах, үүний дагуу Засгийн газарт бас тодорхой хариуцлага тооцох ийм зүйлийг хийнэ шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Тэгээд зарчмын санал хэлж байна л даа. Одоо бас энэ 6 дугаар сарын 1-ний дотор тендерээ зарлаж чадаагүй хөрөнгө оруулалтын ажил яах вэ гэдэг асуудал гарч ирж байгаа. Тэгээд энэ чинь бас л давхар давхар тушаал гэсэн үг шүү дээ. Ер нь бол ажлаа хийж чадахгүй, олон янзын учир шалтгаанаас болоод хугацаандаа тендер зарлаж чадаагүйгээс болоод гэрээ хийж чадаагүйгээс болоод хөрөнгө оруулалтын ажил татагдана гэдэг бас дэндүү хайран л зүйл болчихож байгаа юм. Тэгээд энэ дээр гарц гаргалгааг яах юм Сангийн яам бас ярилцах ёстой. Яг нэг агуулгаар хэд хэдэн асуудал байна шүү дээ. Жавхлан сайд

1 дүгээрт энэ тендер зарлагдаагүй, хөрөнгө оруулалтын ажлуудыг цаашид яах юм.

2 дугаарт нь энэ нэг зээл тусламжтай холбоотой асуудлуудыг хэрхэн яаж ашиглалтыг нь сайжруулах юм.

3 дугаарт олон төрлийн концесс болон бусад төрлөөр энэ хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хэрхэн яаж анхаардаг байх юм бэ гэдгийг Засгийн газар талаас их сайн бодож оруулж ирэх хэрэгтэй. Мэдээж алдаа дутагдал санал шүүмжлэлтэй холбоотой асуудлаар зарим зүйлийг хөдөлгөхөд хүндрэлтэй байдаг. Гэхдээ бүгдийг нь хүнд байдаг, алддаг гэдэг ойлголтоор хаачаад суугаад байна гэдэг бол улс орны хөгжил удаашрах нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа л зүйл болчихож байгаа юм. Энэ дээр хариулт тайлбар хийх боломжгүй. Дэг байхгүй.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжихгүй байдлаар Лувсанжамц гишүүн үг хэлнэ. Үг өгье.

Г.Лувсанжамц: Эрхэм гишүүдийн, сайд нарын өдрийн мэндийг хүргэе. Засгийн газраас өргөн барьсан 2026 оны хөгжлийн төлөвлөгөөгөөр нийтдээ 17,5 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн. Бадамсүрэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг өнгөрсөн 7 хоногийн хугацаанд маш шуурхай ажилласан. Энэ хөгжлийн төлөвлөгөөнд өндөр ач холбогдол өгөөд, нухацтай ажилласан ажлын хэсгийн дарга, ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа гэж эхлээд хэлмээр байна.

Энэ хугацаанд Байнгын хороо болон нэгдсэн чуулганы хуралдаанаар зарчмын зөрүүтэй 142 санал гарч, үүний 17 нь 3 дугаар хавсралт буюу шалгуур үзүүлэлтийн санал байсан. Үлдсэн 125 саналаар нийт 1,6 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ шинээр тусгагдаж ирэх жил 19 их наяд төгрөг зарцуулахаар болж байгаа. Тэгээд хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байгаа учраас хот төлөвлөгч хүний хувьд Улсын Их Хурлын гишүүд, сайд нарт хандаж 1 зарчим хэлмээр байна.

Та бүхэнд энэ өргөн барьсан төлөвлөгөө болон чуулганаар нэмсэн саналуудаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг салбараар хуваасан графикийг тараасан. Эндээс харахад төлөвлөсөн арга хэмжээний 33 хувь нь гишүүдийн оруулсан саналын 41 хувь нь зам барих буюу автомашинд зориулагдсан байгаа. Өнгөрсөн хугацаанд бид улсаараа нэг зүйлийг буруу ойлгоод, буруу яриад, буруу хэрэгжүүлж ирсэн. Энэ юу вэ гэхээр зам дагаж хөгжил гэдэг зүйл. Зам дагаж хөгждөг, зам барьж хөгждөг улсууд бол автомашин үйлдвэрлэдэг улсууд. Тэр улсуудын зөвлөхүүд нь хүрч ирээд бид нарыг зам барь гээд байдаг. Манай төсвийн ихэнх нь, төлөвлөгөөний ихэнх нь ийм зам барих ажил руу татвар төлөгчдийн мөнгийг зарцуулаад байдаг. Манайх шиг ийм хөдөө аж ахуй, уул уурхай голлосон, цаашдаа үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр зорьж байгаа улс бол боловсрол 1 дүгээрт, 2 дугаарт эрүүл мэнд, 3 дугаарт эрчим хүчний гэсэн энэ 3 салбарт хөрөнгө оруулах ёстой. Төсөв төлөвлөгөөний дийлэнх нь энэ 3 салбарт чиглэж, иргэдийн төлсөн татварыг хүүхдийн боловсрол, иргэдийн эрүүл мэнд, аж ахуйн нэгжүүдийг эрчим хүчээр хангахад зориулагдах ёстой. Харамсалтай нь бид нар энэ боловсролынхоо салбартаа 20 хуваасныхаа 1-ийг буюу 5 хувь, эрүүл мэндийн салбарт 3 хувийг зарцуулахаар болоод байна л даа. 0 хуваасны 1-ийг л эрүүл мэнддээ зарцуулъя гээд байна. Өнөөдөр эмнэлэг очертой, ор нь хүрэлцэхгүй, сургуулиуд 1 ангидаа 1 танхим нь 55-аас дээш хүүхдүүд чихцэлдээд сууж байхад бид нар төлөвлөгөөнийхөө 33 хувийг нь замд, гишүүдийн өгсөн саналын 40 гаруй хувь нь зам барья гээд ороод ирж байж болохгүй. Бид нар цаашдаа эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд гэсэн ийм салбарууд руугаа хөрөнгө оруулалтаа чиглүүлэх ёстой. Төсөл, арга хэмжээг төлөвлөх ёстой.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд ганц зүйлийг захиж хэлэх гэсэн юм. 8 сарын 15-аас өмнө 2026 оны төсвийн төлөвлөгөөг гаргаж өгөх байх. Тэр үедээ энэ хөгжлийн төлөвлөгөө дээр туссан төсөл, арга хэмжээний эрэмбийг нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, ач холбогдлоор нь эрэмбэлээд Эдийн засгийн байнгын хороон дээр хүргэж өгөхийг хүсэж байна. Тэгж байж бид нар аль зам нь хэрэгтэй, хэрэггүйгээ төлөвлөөд, аль сургууль, цэцэрлэгийг хаана барих вэ, ямар эмнэлэг хэдий хэмжээний ортой, хэрэгтэй вэ гэдэг зүйлүүдийг Их Хурал дээрээ хэлэлцэж шийдвэр гаргах ёстой.

Манай төсвийн болон төлөвлөгөөний бодлого ийшийгээ чиглэх ёстой гэсэн зарчмын байр суурийг хот төлөвлөгч хүний хувьд та бүхэндээ хэлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулсан байгаа. Уг санал мэдээж шинээр орж байгаа төсөл, хөтөлбөр биш байна. Хөгжлийн төлөвлөгөөний зарим заалттай давхацсан агуулга ижил байгаа учраас 2 заалтыг нэгтгэе гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байгаа. Тэгэхээр энийг дэмжиж өгч байж 1 төсөл болох юм гэдгийг бас гишүүддээ ойлгуулж хэлэхийг хүсэж байна.

Мэдээж Лувсанжамц гишүүний хэлж байгаагчлан Монгол Улсын төсвийн бүтэц ер нь ямар байх юм бэ гэдэг үндсэн агуулга, зарчим яригдаж байна. Мэдээж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай бүх л салбар тулгамдсан асуудлуудтай байгаа. Ялангуяа баруун бүс нутагт бол энэ боомттой холбох олон жил яригдсан зам бол баруун бүсийн эдийн засгийн хөгжлийг бодитой бий болгох, ард иргэдэд зах зээлийг нь ойртуулж өгөх чухал ач холбогдолтой авто замын төсөл учраас энэ баруун бүс нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд энэ дээр саналаа гаргаж явж байгаа. Харамсалтай нь Түвшин гишүүний хэлсэнчлэн жил болгон амсуулах байдлаар төсөв тавиад явна. Бараг 10, 20 жил барьж байж дуусах зам болчих гээд байгаа учраас энэ дээр анхаарах ёстой гэсэн ийм байр суурийг гишүүд бас хэлж байгаа.

Ер нь цаашдаа энэ авто замын болон эрчим хүчний томоохон төсөл хөтөлбөрүүд хөрөнгө оруулалтыг улсын төсвөөр гэж харахаас илүүтэйгээр хөнгөлөлттэй зээл хэрэгжүүлэх хэлбэрээр гэдэг юм уу, хэрэгжүүлж явах юм бол энэ төсөвтөө дарамт их бага болох байх. Төсвийнхөө зардлыг буулгах тал дээр гишүүдийн ярьж байгаа саналыг энэ Сангийн яам бас бодитой авах хэрэгцээтэй гэж бас харж байгаа. Ард иргэдийн хүсээд байгаа энэ нийгмийн даатгалын хөнгөлөлт дэмжлэг татварын дарамтаас ангижруулах нөхцөл боломж гэдгийг бид төсвийнхөө урсгал зардлыг бууруулж байж бодитой бий болгоно гэдэг л ганц зарчимтай явж байна. Тэгэхээр энэ зардал бууруулах дээр их сайн анхаарч ажиллах нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг бас хэлье.

Ингээд гишүүдийг санал хураалтад бэлтгэл хангахыг хүсэж байна. Хурууны хээгээ уншуулаад, бэлтгэлээ хангая. 20-иод гишүүд бүртгүүлээгүй байгаад байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулсан байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 71 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэсэн байгаа. Дахиж бэлдэх үү. Гишүүд санал хураалтад бэлтгэл хангая. Хурууны хээгээ дахин уншуулна. Санал хураалт. Гишүүд бүртгүүлж байгаа юм байна. Байнгын хорооны саналаар төслийг батлах санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72 гишүүн буюу 67,9 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье. Өдөр 14 цагаас үдээс хойших чуулганы хуралдаан үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 29-ний өдрийн үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудалдаа орёе.

“Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 3” төслийн зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодоор 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн дэмжсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар захирамжийг үндэслэн зээлийн хэлэлцээрт 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр гарын үсэг зураад байна.

Тус төсөл нь шинэ сэргэлтийн бодлогын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн төслийн жагсаалтад туссан бөгөөд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэж байгаа болно.

Төслийн хүрээний одоогийн Багануур Чойр чиглэлийн ЦДАШ-ыг 220квт-ын 2 хэлхээт болгон, хүчин чадлыг нэмэгдүүлж, Багануур, Чойр дэд станцуудыг өргөтгөснөөр бүс нутгийн өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрчим хүчний найдвартай ажиллагаа, тогтвортой байдлыг хангах өндөр ач холбогдолтой юм.

Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас олгох 47 сая ам.долларын зээлийн хугацаа 30 жил, үүнээс үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил бөгөөд баталгаат овернайт санхүүжилтийн хүү софр дээр нэмэх нь 101, 44 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу “Эрчим хүч 3” төслийн зээлийн хэлэлцээр нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын гэрээ тул зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эрчим хүч 3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийг хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг судалсан эсэх, Өмнөговь аймгийн 3 сум БНХАУ-аас цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангадаг асуудлыг шийдвэрлэж, аймгийн төвтэй холбох боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Жангабыл төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төслийн танилцуулгад Багануур, Чойр, 110квт-ын ЦДАШ-ын дамжуулах чадварыг нэмэгдүүлнэ гэснийг анхаарч засварлах, Чойр-Сайншанд, Сайншанд-Замын-Үүд чиглэлийн шугам баригдах болон ашиглалтад орох хугацаа, Багануур, Чойрын шугамын алдагдлын хувь тооцоо, төсөл хэрэгжсэнээр алдагдлын хэмжээ буурах эсэх, трансформатор, цахилгаан станцын тоноглолуудад чанарын шаардлага хангаж байгаа эсэх, цаашид нарны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх шаардлагатай талаар, Эрдэнэбүрэн, Мянгад, Улиастай чиглэлийн шугам барьж эхлэх хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан өмнө авч байсан бусад зээл, зээлийн нөхцөл шаардлагын хувьд ялгаатай эсэх талаар, Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангасан эсэх, Зээлийг эргэн төлөх хугацаанд зээлийн хүү нэмэгдэх, өөрчлөлт орох эрсдэлийн шинжилгээ хийсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд дотоодын аж ахуйн нэгж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийг хэрэгжүүлэх боломжтой талаар, эрчим хүчний бие даасан байдал, үндэсний аюулгүй байдлын хүрээнд хэрэгжүүлэх цуврал төслийн талаар, эрчим хүчний бие даасан хараат бус байдал бүрэн хангагдах талаар зураглал байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбат 10 аймагт ДЦС барих төслийн явц, хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаар тодруулан асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал хэлээгүй болно.

“Эрчим хүч 3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Эрчим хүч 3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн

төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гантогтох мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхтүвшин мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лхагвадэмбэрэл Судалгаа хөгжлийн хөгжүүлэлтийн хэлтсийн дарга. Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 12 гишүүн, 14 гишүүн нэр ирсэн байна. 14 хүнээр Алтаншагай гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. “Эрчим хүч 3” төсөлтэй холбоотойгоор Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ одоо үүсээд байгаа 1 нөхцөл байдал байгаа. Бид хэд бас хөгжлийн гэдэг юм уу ийм зээлүүд авчхаад ашиглаж чаддаггүй. Төсвийн зарлагын дээд хязгаартаа тулчихсан гээд. Төсөв алдагдалгүй баталдаг болсон гэдэг зарчмын хүрээнд авсан энэ зээлүүдээ ашиглалтыг ерөөсөө хийж чадахгүй буюу энэ төслүүдийн хэрэгжилт буюу бүтээн байгуулалтын ажлууд маш их удааширч байна. Төлөвлөгөө графикийн дагуу явахгүй байна. Энэ хүрээнд тухайн төслийг хэрэгжүүлэх явцад бараа материалын үнэ өсөх, ажиллах хүчний зардал өсөх, тээвэр логистикийн хүндрэлүүд үүсэх, эндээсээ болоод маш олон бүтээн байгуулалтууд зогсонги болох, авсан зээлүүд нь хүрэлцэхгүй болох ийм нөхцөл байдал руу ингээд яваад байх юм. Энэ дээр яг энэ авч байгаа зээл чинь ер нь ашиглагдах юм болов уу. Энийг Сангийн яамнаас асуух уу. Эсвэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос асуух уу. Байнгын хороо зөвшөөрөөд байдаг.

Тэгээд энэ зээл чинь ашиглая гэхээр цаашдаа энэ төсвийн зарлагын дээд хязгаарт хүрсэн гэдэг юм уу ийм нөхцөл байдлаасаа болоод ерөөсөө ашиглахгүй гээд ингээд гацчихсан. Түрүүчээсээ зарим Улсын Их Хурлын гишүүд энийг шийдье гээд хууль санаачилж байгаа. Тэгээд эсрэг тэсрэг байрууд мэдээж байгаа. Тэгэхээр энэ дээр бас нэг тодорхой байр суурь хэлээч.

Ер нь зүгээр эрчим хүчний эх үүсвэргүйгээр өнөөдөр нийгэмд тулгамдаад байгаа сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, магадгүй энэ хүнс, хөдөө аж ахуйн сэргэлт ч гэсэн байхгүй шүү дээ. Бид хэд тарьснаа хурааж аваад, хураасныгаа гүн хөлдөөж чадахгүй, боловсруулж чадахгүй, аж үйлдвэр хөгжүүлье гэхээр эрчим хүчний дутагдалтай. Орон сууц барья гэхээр эрчим хүч, дулааны дутагдалтай ийм үед ерөөсөө уг нь бол яг тодорхой эрэмбийн дагуу бас сектороор нь гэдэг юм уу, тодорхой салбарыг бас онцгой бодлого явуулах ийм зайлшгүй шаардлага байгаа юм. Энэ дээрээ Засгийн газар яаралтай, бодлогоо тодорхой болгоод оруулж ирмээр байгаа юм гэдэг зүйлийг бас хэлмээр байгаа юм.

Тэгээд энэ авсан зээлийн ашиглалтыг ер нь хийж чадах юм уу. Ийм зээлүүд аваад байдаг. 12 их наядын авчихсан зээлээ ашиглаж чадахгүй ингээд түгжигдэж байгаа. Түрүүчээсээ томоохон бүтээн байгуулалтын төслүүд чинь яг тухайн жилд бүтээн байгуулалтын графикийн дагуу хөрөнгө оруулалтууд нь орж ирэхгүй, бараа материалаа татаж чадахгүй, ажиллах хүчний зардал хий төлөөд явж байгаа зэрэг ийм нөхцөл байдлууд үүсчхээд байгаа. Энэтэйгээ яаж нийцэж байгаа юм бэ гэдэг зүйл дээр бас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Сангийн яам, Засгийн газраас аль алианаас нь асууя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. 2025 оны батлагдсан төсөв дотор нийт ашиглавал зохих хүлээгдэж байгаа 12 их наяд төгрөгийн төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дүнгээс 1,5 их наяд л төсөв дээр суусан байгаа. Энэ хэлэлцээр ингээд соёрхон батлагдмагц энэ жилийн хувьд бол төслийн бэлтгэл ажил хангагдах ийм л шатын санхүүжилт гарна. Тэр нь 1 орчим сая доллар гэж төслөөс тооцоолсон байгаа. Тэгэхээр энэ жилийн 1,5 их наядын зээлийн ашиглалт дотор энэ төслийн яг саяын миний хэлсэн энэ хэмжээнд бол багтаагаад төслийг эхлүүлнэ гэсэн үг. Тэгээд цаана нь дахиад энэ чинь 46 сая доллар үлдэнэ гэсэн үг. Энийг тэгээд ирэх жилүүдэд төсвийн багтаамж ямар байх нь вэ. Ер нь бол их л шахцалдаж явна гэсэн үг.

Ирэх жилүүдэд нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС гээд томоохон төслүүдийн том дүнтэй санхүүжилтүүд хүлээгдэж байгаа. Тухайлбал нефть боловсруулах үйлдвэр дангаараа 34 жилийн хугацаанд Монгол Улсын зээлээр хэрэгжүүлж байгаа хамгийн том төсөл болж байна. 1,7 тэрбум доллар буюу 5,6 их наяд төгрөг. Энэ жилийн 1,5 их наядын зээлийн ашиглалт дотор 350-400 орчим л багтаж гарахаар байгаа. Тийм учраас бид нэмж авч байгаа зээлүүд дээрээ бол маш өндөр шалгууртай, нэлээн орон зайн дээр нэлээн харам байгаа гэх үү дээ. Хамгийн шаардлагатай нэн тэргүүний ЦДАШ-ууд, дэд бүтэц, эрчим хүчтэй холбоотой ийм төслүүд дээр л урт хугацааны ийм хөнгөлөлттэй зээлүүдийг стратегийнхаа хүрээнд Их Хуралд танилцуулаад, зөвшөөрөл аваад явж байгаа.

Д.Амарбаясгалан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Тэмүүлэн дарга хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Сайнзориг гишүүний асуусан асуултад хариулъя. Энэ орж ирж байгаа асуудлыг бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцээд, эрчим хүчний эх үүсвэр болоод, дутагдалтай холбоотой асуудал нэн тэргүүний бас шийдвэрлэх асуудлын хүрээнд хэлэлцээд оруулж ирсэн хэлэлцээрийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол олонхоороо дэмжсэн байгаа.

Таны асуусан асуулттай холбогдуулаад ер нь зүгээр бид нар энэ өрийн удирдлагынхаа менежментийг яах юм бэ. Цаашид ер нь зээлийнхээ ашиглалтуудыг хэрхэн сайжруулах юм бэ гэдэг асуудал байгаад байгаа. Тэрнээс үндсэндээ бид нар 10, 20, 30 жилийн хугацаанд авсан 100, 200 төслүүд байгаа байх. Хэрэгжиж байгаа төслүүд ч байна, хэрэгжихгүй нь ч байгаад байна. Нөгөө талдаа тэр зээлийн ашиглалт буюу том дүнгээрээ 10 хэдэн их наяд гэдэг асуудал бол үнэн. Өнөөдөр үндсэндээ бид нар хүсээд байгаа зүйл нь бол Сангийн яам энэ бодлого барьж байгаа яам нь орж ирж энийгээ эрэмбэлээд, хэрэгцээгүй төслүүдээ болиод, нэн

тэргүүнд хэрэгжүүлэх асуудлаа бол эрэмбэлээд явах ёстой гэдэг асуудлыг хөндөж яриад байгаа юм. Би нөгөө .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Би тэгээд Байнгын хорооны дарга болон Жавхлан сайдын үгнээс бол 1 зүйлийг ойлголоо. Нэн тэргүүний эрчим хүч, дэд бүтцийн чиглэлийн энэ төсөл хөтөлбөрүүдээ бол яаралтай хэрэгжүүлэх ёстой юм байна. Энэ дээрээ бас зайлшгүй хууль, эрх зүйн орчныг шаардлагатай өөрчлөлтүүдээ хийгээд явах ёстой юм байна гэж харж байна.

2 дугаарт зүгээр Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг л харахад жилд 2 тэрбум долларын нефть бүтээгдэхүүн хэрэглэхээд явж байгаа. Энийг өнөөдрийн байдлаар төсвөөс санхүүжүүлж байгаа графикаар буюу энэ төсвийн хязгаарыг аваад үзэх юм бол 10-15 жилийн дараа бүтээн байгуулалт ашиглалтад орно. Гэтэл Улсын Их Хурлаас 2028 онд дуусга гэдэг зээлийн хэлэлцээрийг байгуулсан ийм төлөвлөгөө гаргаад өгчихсөн байгаа. Энэ хэмжээгээрээ бид нар энийг оруулж чадахгүй бол жилд 1 тэрбум долларыг жишээ нь авч үлдэх боломжоо алдана л гэсэн үг. Тэгэхээр зайлшгүй энэ дээр хаана хаанаа ойлголцож, тэр мөнгө нь үндсэндээ гадаад улсын Эксим банк дээр зээлийн шугам нээгдчихээд байгаа шүү дээ. Бид хэд авч ашиглах, Монгол Улсад эсрэгээрээ валют орж ирээд, бүтээн байгуулалт ажлын байр бий болгох, урт хугацаандаа манай дэд бүтцэд стратегийн зарим салбарын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя. Б

Ж.Батжаргал: Баярлалаа. “Эрчим хүч 3” төслийг хэрэгжүүлэх олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас авах зээлийн гэрээг соёрхон батлах асуудлыг дэмжиж байгаа. Дам дамаа бид нар энэ эрчим хүчнийхээ салбар, үйлдвэрлэсэн эрчим хүчээ түгээх, дамжуулах чиглэлийнхээ асуудал руу шуурхай хөрөнгө оруулалт хийж байж энэ үндэсний аюулгүй байдлаа ч хангах тэр, бусад салбаруудынхаа хөгжлийг тэтгэгч энэ асуудал руугаа бол нэлээн онцгой анхаарч ажиллах ёстой. Магад ч үгүй энэ цаг үе эрчим хүчний салбарт ахиу бүтээн байгуулалт хийх тийм цонх үе байж мэдэхээр харагдаад байгаа юм. Миний бодлоор бол. Эрчим хүчний нүүрсний гадаад зах зээлийн үнэ тийм өндөргүй байна. Эрчим хүчний нүүрс бидэнд арвин нөөц байгаад байна. Энийгээ түшсэн станцууд байгуулах, дотоодынхоо хэрэглээг бүрэн хангах, улмаар эрчим хүч экспортлогч орон болох энэ зорилт руугаа ер нь жоохон нөөцөө ахиу хуваарилж зүтгэж ажиллах нь зүйтэй гэсэн ийм бодол санаатай байгаа. Тийм учраас энэ рүү авч ашиглах гэж байгаа зээлийг дэмжиж байна.

2, 3 тодруулах зүйл байна. 1 дүгээрт бид нар 5 жилийн хугацаанд 47 сая долларыг авч ашиглахаар байгаа юм байна гэж харагдаад байгаа юм. Хуваарийнх нь асуудал ямархуу байгаад байгаа юм. Бид нар чинь гаднаас авч байгаа зээлийн хөрөнгийн баталгаажсан, ашиглаж чадаагүй байгаа үлдэгдэлдээ тодорхой хураамж төлөөд байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр үүнийг аль болохоор богино хугацаанд бүрэн ашиглаж гэмээ нь энэ дарамт ирэх асуудал нь багасах ёстой. Тэгэхээр энэ талаас нэг тодорхой мэдээллийг авчихмаар байна.

2 дугаарт энэ төслийг гүйцэтгэгч нь ер нь ямархуу байдлаар шалгарах юм бэ. Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк нь бас тодорхой бодлого, байр суурь

илэрхийлээд гүйцэтгэгч дээр оролцох оролцоо энэ тэр гэж бий юу. Би яагаад энийг асууж байна вэ гэхээр 10 аймгийн дулааны асуудлыг шийднэ гээд Солонгосын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг Эксим банк нь шийдсэн. Гэтэл тэндээс гүйцэтгэгч шалгаруулах ажил зохион байгуулагдсан. 10 аймгийн дулааны станц дөнгөж эхлээд зогсчихсон. Зарим аймаг дээрээ 40-өөд хувьтай гэж ярьдаг. Зарим дээрээ 20 гаруй, 30-аад хувьтай. Тэгээд бид авч ашигласандаа хүү төлж байгаа. Авч ашиглаж чадаагүй байгаадаа хураамж төлж байгаа. Тэгээд энэ нь биднээс болоогүй Солонгосын талаас болоод байгаа. Тийм учраас энэ авч ашиглаагүй зээл гэдэг юм уу, эсвэл дуусаагүй үйлдвэрлэлд аваад ашиглачихсан зээлд хүү, хураамж төлдөг асуудлыг зогсоомоор байгаа юм. Яг нарийндаа. Энэ асуудлыг ер нь хаана хаанаа нэлээн нухацтай ярьж, хариуцлагын асуудлыг зөв талд нь гаргаж шийдэхгүй бол энэ хий төлөлтүүд үүсээд яваад байх магадлал үүсээд байна. Тийм учраас энэ олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авч ашиглаж байгаа зээлийн хөрөнгийг зээлжүүлэгч тал бас өөрөө хариуцлагаа үүрч, өөрсдийнхөө буруутай үйл ажиллагаанаас болж байгаа бол тэр хүү, хураамжийн асуудал нь зогсдог энэ тэр ийм хэлэлцээр юмнуудыг цаашид бодож хийхгүй бол болохгүй нь. Энэ тал дээр ямар байр суурь байна вэ. Солонгосын тэр асуудал ер нь ямархуу түвшиндээ яригдаж, ямар шийдэл дээр хүрч байна вэ. Энэ 10 аймаг чинь яг тэр дулааны станцын ашиглалтад орох цаг хугацаатай тохируулаад орон сууцжуулах үйл ажиллагаагаа, үйлдвэрлэх үйл ажиллагаагаа төлөвлөөд, хувийн хэвшлийнхээ хөрөнгө оруулалтуудыг татаад ажилд нь оруулчихсан байгаад байдаг. Зарим барилга байгууламжууд нь ашиглалтад ороод, дулаангүй зогсох байдалд хүрэх гээд байна. Тийм учраас үүнийг ашиглалтад орох хүртэл хугацаанд тэр аймгууд дээр бий болсон бүтээн байгуулалтуудыг ашиглах бололцоог нь бий болгож, нэмэлт эх үүсвэр гаргаж, одоогийн байж байгаа станцуудыг нь түр хугацаанд нэмж тоноглож ажиллуулах бололцоог ер нь юу гэж харж байгаа вэ. Эрчим хүч .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Эрчим хүчний сайд Чойжилсүрэн хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ зээлийн тухайд бол манай Сангийн яам илүү тодорхой хариулах байх. Эхний 4 жилдээ бол зээл ашиглалт, таны яриад байгаа зээлээ аваагүй байсан ч гэсэн нөгөө ашиглаагүй зээлд ашиглалт энийг төлөхгүй, 4 жилийн хугацаанд хөнгөлөлттэй гэсэн ийм заалтууд суулгаж оруулсан байгаа.

2 дугаарт энэ 10 аймгийн төслийн тухайд энэ бол олон улсын сэргээн босголт хөгжлийн банк учраас олон талт байгууллагууд байдаг. Тендерийг нээлттэй зарлана. Заавал 1 орны улс орнуудад зориулахгүйгээр хүссэн улсын компаниуд Их Хурал соёрхон баталсан тохиолдолд тендер зарлаж таарна. Ажлын хэсэг байгуулаад. Тэр үед бол бүх компаниуд оролцох нь нээлттэй. Ийм 2 ялгаатай. Солонгосын 10 аймгийн дулааны станцын тухайд бол Солонгосын Эксим банкны экспортын зээл учраас зөвхөн тэр зээлийн ерөнхий нөхцөлөөрөө Солонгос компаниудын дунд тендер зарлах ийм нөхцөлтэйгээр олгогдсон зээл байгаа. Энэ дагуу 2021 онд тендер зарлагдаад, Бюксан инженеринг гэж компани шалгараад, түүнээс хойш ингээд ковид гээд янз бүрийн байдлаар хүндэрч явсаар байгаад, сая 2025 оны 4 дүгээр сард энэ компани Солонгостоо дампуурлын тухай хамгаалалтад хамрагдах ийм хүсэлтийг гаргажээ. Солонгосын аж ахуйн нэгжүүдийн дампуурлын тухай хуулиараа шүүхийн шийдвэр гарна. Эрх хүлээн авагч томилогдоно. Дараа нь томилогдсон эрх хүлээн авагч энэ компаниудын хэрэгжүүлж байсан төслүүдийг эрэмбэлээд, алиныг нь явуулах вэ, алиныг нь явуулахгүй байх вэ гэдэг мөнгөн урсгал тэр дампуурал дээр нь арай гайгүй хувилбарыг нь сонгодог ийм зарчимтай

юм байна. Энэ 6 дугаар сард Солонгосын тэр захиргааны хэргийн шүүхийн хурал шийдвэр 1 талдаа гараад, үүний дараа шинээр томилогдсон эрх хүлээн авагчдаа бид нар энэ төслийн хувь заяаг шийднэ. Энэ процессыг хүлээхгүйгээр бид нар солонгосын Кореа Эксим банкны төлөөллүүдтэй 2 удаа уулзалт хийсэн. Монгол Улсад сууж байгаа Солонгос улсын Элчин сайд ч энд идэвхтэй оролцоод явж байгаа. Яг таны яриад байгаа энэ Солонгосын талын буруугаас шалтгаалаад зээлийн хүү гүйж байгаа энэ нөхцөлд бол энийг зогсоож ийм хэлэлцээр явуулъя гэж байгаа. Гэхдээ энэ захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гараад энэ компани гүйцээх үү, эсвэл энэ компанийн хэрэгжүүлж байсан төслийг одоо байгаагаар нь үнэлээд, үлдэх ажлынх нь объём хэсэг дээр нь шинээр тендер зарлах уу гэдэг энэ 2 сонголтыг нь өмнө байгаа. Энэ шүүхийн шийдвэрийг харж байгаад бид нар нэг талд нь гаргах ийм л зүйл болж байна. Харамсалтай зүйл байна. Ийм чадвар муутай компани шалгараад ийм байдалд орсон.

Монголын талаас авч хэрэгжүүлэх захиалагчийн бүх үүргийг Эрчим хүчний яам, Сангийн яам бол ямар нэгэн доголдол, гажуудал байхгүйгээр гэрээнд заасан үүргийн дагуу хэрэгжүүлээд явж байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Сая манай Чойжилсүрэн сайд бараг хариулчихлаа даа. Энэ зээлийн нөхцөл бол одоо бидэнд олдож байгаа хамгийн таатай ийм зээл байгаа юм. Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас авч байгаа энэ зээл маань 30 жилийн хугацаатай, эхний 5 жил үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Тэгэхээр 2026, 2027, 2028, 2029 энэ 5 жилийн дотор зээлээ бүрэн ашиглаад, барилгын ажил дууссан байх ёстой. Хэрэв 2029 он дуусахгүй бол тэрнээс цааш яг таны хэлж байгаа торгууль ашиглаагүй үлдэгдэл дээр 0,25 хувийн ийм торгууль гэх үү дээ төлж эхлэх юм байгаа юм. Тийм учраас 2029 он гэхэд ажил нь ч дууссан. Зээлээ ашиглаад ч дууссан байх ёстой. Ингээд цаашаага бол үндсэн төлбөрийнхөө төлөвлөлт нь эхлээд явах учиртай ийм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Гадаад зээлийн ашиглалт дээр 1 асуудал байгаад байгаа юм. Энэ эрчим хүчний салбар гэдэг юм уу ийм тодорхой өөрийнхөө үйл ажиллагаагаар авсан хөрөнгөө буцаагаад нөхчих салбарууд дээр Засгийн газар баталгаага гаргаж, Хөгжлийн банкаараа дамжуулж, шууд эрчим хүчний түгээх систем рүүгээ төрийн өмчтэй компани руугаа зээлдүүлдэг хэлбэрээр явж байж энэ төсвийн хязгаарлалтуудад орохгүй гарах бололцоо байгаа. Үүнийг ер нь судалж үзсэн, барьсан юм байна уу гэж 1 ийм зүйл.

2 дахь зүйл Чойжилсүрэн сайдаас тодруулах юм. Энэ Солонгосын талын хийж байгаа хөрөнгө оруулалт удах тусам энэ аймгуудын хөгжилд чөдөр болоод байна. Тийм учраас энэ аймгуудын одоо байж байгаа станцыг нэгэнт эхлүүлчихсэн бүтээн байгуулалтуудад нь шаардлагатай эрчим хүчний эх үүсвэрийг нь дулааны эх үүсвэрийг нь өгч чадах өргөтгөлийг хийж өгөх бололцоо байна уу. 2100 айлын орон сууцын хороолол явчихсан байна. Хэд хэдэн үйлдвэрийн ажлууд явчихсан /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Батжаргал гишүүний асуултад нэмээд хариулъя. Удах тусам улам хүндэрнэ. Одоо байгаа угсраад орхичихсон каркас төмөр эдлэлүүд муудах ийм эрсдэлүүд бий. Төслийн нэгж болон Эрчим хүчний яамнаас бид нар энийг ямар ч байсан консервацад хадгалахад тодорхой хэмжээний хамгаалалтын арга хэмжээнүүд аваад явж байгаа. Одоо энэ 6 дугаар сар гэдэг чинь удахгүй гарах гэж байгаа учраас ойрын ирээдүйд бид нар нэг талд нь гаргах ийм шаардлага байна. Энэ төсөл хэрэгжихгүй болсон тохиолдолд бид нар төсвийн мөнгөөр энийг гүйцээх бололцоо байхгүй. Нэгэнт Кореа Эксим банктай зээл хэлэлцээр хийсэн учраас энэ төслийг бол тэр Корей Эксим банктай нь дуусгахаас өөр аргагүй. Таны хэлээд байгаа хувилбарын тухайд төсвийн орон зай ямар гарах нь вэ бид нар мэдээж энийг судлаад, Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам маань өнөөдөр дөнгөж сая үүний өмнө төсвийн хүрээгээ батлуулчихлаа шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яам батлуулаад. Энэ хязгаар дотор .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Ийм байгаа. Эрчим хүчний яамнаас өгч байгаа мэдээллээр бол одоо нэгэнт суурилагдчихсан эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийг хэрэглэгчидтэй нь холбох ЦДАШ-ын хэрэгцээ бол 1842км. Энэ бол 188км буюу 10 хувь нь юм байгаа юм. Энэ 1800км бол яг нийтийн хэрэглээний нийтийн хэрэгцээний ийм шугамуудыг холбож байгаа дэд бүтэц байгаа юм. Өөрөөр хэлбэл шууд бас арилжааны зориулалттай биш. Эндээс бол шууд орлого олоод, өөрийгөө санхүүжүүлэх ийм боломжгүй. Гаднын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлээр бас явах ийм боломжгүй. Тэгээд эзэмшигч нь заавал улс өөрөө байх ёстой гэсэн ийм чиглэлийн яамны өөрсдийнх нь гол тодорхойлолт нь байгаа юм.

Тийм учраас бид нар энэ нөхцөлүүдийг хангаж байгаа 3 жилийн стратегитай үзэл баримтлалд багтаж байгаа ийм төслүүдийг гадаад хэлэлцээрүүдийг үргэлжлүүлж, зээл олж ирдэг байгаа юм. Хэрвээ үнэхээр яг арилжааны боломжтой .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Арилжааны боломжит өөрөө өөрийгөө санхүүжүүлэх төслүүдийг бол аль болох төсвөөс санхүүжүүлэхгүй, гаднын хөрөнгө оруулагч нарт санал болгох Хөгжлийн банк ч юм уу өөр эх үүсвэрүүд рүү бид явуулж байгаа. Харин баталгааны хувьд бол бас л төсөв дотроо ордог. Тийм учраас баталгаа бол юу гэдэг юм төсвөөс гадуур Хөгжлийн банк руу шууд шилжүүлэх ийм боломжтой эх үүсвэр бас шууд бол биш юм байгаа юм. Тэгэхээр баталгаа гаргахгүйгээр төсөл өөр өөрийгөө санхүүжүүлээд, арилжааны шугамаар явах л ийм төслүүдийг төсвөөс холдуулах боломжтой.

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Багануур Чойрын 220 киловольтын ЦДАШ-ыг барих энэ зээлийн гэрээг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд 3 асуулт байна л даа.

1 дүгээрт энэ зээлийн бичиг баримтыг харахаар ТЭЗҮ-ийн хүрээнд гарсан дүн дээр үндэслэгдэж зээл авч байгаа гээд бичсэн байна л даа. Тэгээд энэ дээр маш их гайхаж байна л даа. Яагаад гэхээр ТЭЗҮ дээр бол ерөнхийдөө маш тойм буюу маш өндөр дүн гардаг. Тэгэхээр ийм үндэслэлгүй өндөр дүн дээр үндэслэж, зээл авч

байгаа чинь жоохон асуудалтай юм биш үү. Яагаад гэхээр бодит зураг төсөл хийгдэж байж л тухайн төслийн бодит өртөг тодорхой болдог. Тэгэхээр яагаад ингэж бодит өртөг буюу зураг төсөл дээр гарсан дүнгээр зээлээ авч болохгүй байгаа юм бэ. Бид нар төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хувьд болохоор заавал зураг төсөлтэй бай гэж шаарддаг. Тэгсэн мөртөө зээлийн хувьд болохоор зүгээр нэг ийм ТЭЗҮ-ийн дүнгээр зээл авч байгаа. Яагаад гэвэл энэ бол дахиад л бид нар өөрсдөө төлнө шүү дээ. Тэгэхээр энэ дээр жоохон асуудалтай юм биш үү гэж ингэж харж байна.

2 дугаар асуулт болохоор ерөнхийдөө ингээд харахаар 47.0 хэдэн сая доллар гэдэг 1км 220 киловольтын дэлхийн жишиг өртгөөс бол нэлээн өндөр харагдаж байна л даа. Яагаад гэхээр дэлхий дээр дунджаар бол 1км 220 киловольтын шугам 200 мянган доллар юм байна. Энэ дүн дээр ингээд харахаар бол 254 мянган доллар гэсэн ийм өртөг харагдаж байна л даа. Тэгэхээр энэ нэлээн өндөр харагдаж байна. Энэ дээр та бүхэн ямар хариулт өгөх вэ.

3 дугаар асуулт болохоор дөнгөж саяхан Батжаргал гишүүн ярьж байна. 10 аймгийн ДЦС-ын асуудал. Тэгэхээр бид нар бас л дахиад л энэ ондоо өндөр дүнтэй төслийг болохоор дахиад л гаднын компанид өгнө. Би бас өмнө ч гэсэн асууж байсан. Дотоодын компаниуд ийм өндөр дүнтэй юм хийж чаддаггүй юм гээд л гаднын компанид өгдөг. Дотоодын компаниа тендерт орохоор бараг л үг үсгийн алдаа гаргаж байна гээд л хасдаг. Гаднын компаниудыг болохоор бүр 1 ч шалгаж чаддаггүй. Тийм ч учраас тэр 10 аймгийн хувьд болохоор бүхэл бүтэн дампуурчихсан компанид тэр өндөр өртөгтэй юмыг тавиад туучихсан. Одоо ингээд 10 аймгийн дулааны станц ч байхгүй, бөөн өр ширэнд орчихсон сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ алдаа дутагдал энэ төсөл дээр гарахгүй гэх магадлал хаана байгаа юм бэ. Тэгэхээр энэ дээр бас хариулт өгөөсэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүн ээ, ТЭЗҮ-ийн дүнгээр зээл авч байгаа нь үнэн. Гэхдээ яг зээлийн гүйцэтгэл ТЭЗҮ-ийн дүнгээр гарна гэсэн үг биш. Одоо Улсын Их Хурлын соёрхон баталсны дараа зээлийн удирдах хороо, төслийн нэгж байгуулагдана. Зураг хийнэ. Түүний дараа олон нийтийн дунд нээлттэй тендер зарлагдана. Зургийг нь бол эцэслэнэ. Гэхдээ яг гэрээний өмнө зургийг нь бол эцэслээгүй, ТЭЗҮ-ээрээ явчихсан байгаа. Тэгэхээр энэ яг зах зээлийн өрсөлдөөнд сонгон шалгаруулалтаар орж гүйцэтгэгч шалгарна. Тийм учраас зах зээлийн үнэд үнээс өндөр гарах болов уу гэсэн ийм болгоомжлол бол цаашид байхгүй байх гэж би бодож байна. Яагаад гэвэл дахин хэлье. Дэлхийн банкны худалдан авалтын дүрмээр ТЭЗҮ-г нь боловсруулаад, Дэлхийн банк бол тэр төслийн бэлтгэл хангахад олон оронд, дэлхийн улс орнууд бүгдэд нь үйл ажиллагаа явуулдаг учраас арвин туршлагатай. Алдаа гарах магадлал бага. Тэгээд үүний дараа зураг, төсвийг хийгээд, тэгээд зарлана.

Тэгэхээр энэ 47,8 сая долларыг бодит гүйцэтгэлээрээ 47,8 саяас бага биш тендерт өрсөлдөөд хамгийн бага үнэтэй, хамгийн сайн тендерээр ирүүлсэн оролцогчийг шалгаруулна. Тийм учраас энэ бол дээд хязгаар гэж ойлгоно. Энэ бол зээлийн дээд хязгаар гэж ойлгоно. Түүнээс биш яг энэ дүнгээр бүгдийг нь аваад хэрэглэхчхэнэ гэсэн үг биш гэдгийг бас товчхон хэлье.

Мэдээж энэ төслийн юун дээр Дэлхийн банк бол нэлээд улс орнуудын нөгөө магадалшгүй зардлыг тооцдог, янз бүрийн нөхцөл, улс төрийн болон эдийн засгийн янз бүрийн хямралуудыг тооцдог учраас магадалшгүй ажлын зардал оруулаад, тооцохоор 254 мянган доллар болно. Дундаж үнэ таны ярьж байгаа 200 мянган доллароос ч хямдхан ороод ирэх байх гэсэн ийм хүлээлттэй байгаа. 1км шугамын урт.

3 дугаарт нь нэг ийм асуудал бий. Энийг илэн далангүй хэлсэн нь дээр байх. Манайх жижиг улс. Яг ийм хэмжээний тендер бол мэдээж тендер шалгаруулахад Дэлхийн банкны худалдан авах журмаар бид нар манай тендерийн хуулиас гадуур явна. Тэгэхээр эд нар ийм туршлагатай компани шалгаруул гэдэг ийм шаардлага тавьдаг. Яг урьд нь манайд ийм төрлийн шугамын ажил цөөхөн хийгдсэн учраас энэ борлуулалтын орлого болон хийсэн ажлын туршлагыг шалгаруулах дотоодын компаниуд дээр хүндрэл үүсэж байгаа нь үнэн. Одоо бид нар жишээлбэл ЕСБХБ-ны санхүүжилтээр явж байгаа Чойр-Сайншандын шугам дээр дотоодын компани оруулах гэж би тендерийнх нь 3, 4 багцад хуваагаад, дотоодын компаниудыг шалгаруулах бололцоо гаргах гэж сүүлийн 2 жил ЕСБХБ-тай янз бүрийн байдлаар лобби хийж, нааш цааш бичиг хөөцөлдөж явж байна. Харамсалтай нь үр дүнд хүрэхгүй байгаа ийм нөхцөл байна. Одоо энэ зээлийг ашиглах нөхцөл байдал хугацаа чинь дуусах гээд байна шүү гэдэг ийм нөхцөл байдалд тулгагдаад одоо Европын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: Миний санахын Багануур-Чойрын 220 киловольтын шугамын зургийг Баясал төгс гээд компани хийсэн гэж бодож байгаа. 2022 онд тэгэхээр зургийг чухам яагаад ашиглахгүй байгаа вэ гэж асуулт байна. Хоёрдугаарх нь нөгөө аль болох л дотоодын компаниар буюу та ярьж байна. Сая Чойр-Сайншандынхыг болохоор багцлаад хэдэн багц болгоод зарлах гэж байгаа гэж ярьж байна. Тэгэхээр энэ төслийг бас яг адилхан аль болох л яагаад гэвэл шугамын хувьд болохоор яг километрээр нь хуваагаад олон компани оруулах бүрэн боломжтой байдаг. Тэгэхээр яг энэ аргыг ашиглаад аль болох л дотоодынхоо компаниудыг оруулах нь зүйтэй байх гэж бодож байна л даа. Яагаад гэхээр дотоодын компани буух эзэнтэй, буцах хаягтай. Тэр шугам дээр асуудал гарлаа, тэр нөгөө дуудаж ирээд энийгээ зас гэх боломж үнэхээр байхгүй. Тэгэхээр энэ дээр бас анхаараасай гэж бодож байна.

Дараагийн юм нь болохоор тэр 10 аймгийн дулааны станцын хувьд тэр шалгаруулалтыг хийсэн субъект нь хэн бэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: 10 аймгийн дулааны станц төслийн сонгон шалгаруулалтыг манай Эрчим хүчний яам дээр 2021 онд хийсэн юм байна лээ. 2 удаа зарлаад оролцогч оролцохгүй байсан. 3 дахь удаа зарлаад “Бюксан инженеринг” гэдэг 1 л компани орж ирсэн нь ийм нөхцөлтэй зарлуулсан юм байна лээ. Тухайн үед нь би бол Эрчим хүчний сайдаар томилогдоогүй байсан ийм байдалтай байгаа гэдгийг бас хэлье. Таны яриад байгаа энэ төсөл дээр ч мөн ялгаагүй. Дэлхийн банк дээр бид нар энэ төслийг хэд хэдэн багц болгож, дотоодын компаниудын орлого, зарлага энэ шаардлагыг хангахуйц хэмжээнд багцлахын төлөө хичээж ажиллана. Гэхдээ эцсийн зөвшөөрлийг бол санхүүжүүлэгч байгууллага өгч байгаа учраас бас бүрэн шууд амлахад хэцүү байна. Оролдлого бол хийнэ. Энэ зураг төсвийн тухайд бол

2022 онд хийсэн зураг байна. Одоо энэ зургийг энэ Их Хурлаар соёрхон батлагдсаны дараа бид нар дахиж зураг төсвийг магадлаад, тэгээд тендер зарлах ажлыг эхлүүлнэ. 2024, 2025.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Энийг дэмжихгүй байгаа. Дандаа өр зээл авдаг, ажил олигтой хийсэн юм байдаггүй, бодлогоосоо зөрдөг. Би Чойжилсүрэн сайдаас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дээр 10 асуулт асуусан. Яам дээрээ очоод хариулт өгье гээд одоо 1 сар болох гэж байна. Жангабыл гишүүн ажлын хэсгээ ахалсан. Тан руу миний хажууд залгасан. Урьд нь бас яриад дандаа хойшлуулаад байна гэсэн. Ажлаа хийдэг үү та. Энэ зээлээ авах гэж байвал зөв юманд нь аваад зөв ашиглах хэрэгтэй. Бүсчилсэн хөгжил гээд энэ сэргээгдэх эрчим хүчийг бодлогоор дэмжье. Тархсан байдлаар эх үүсвэрүүдээ төвийн эрчим хүч рүүгээ нийлүүлье гээд явж байгаа. Ерөөсөө энийгээ дэмждэггүй. Үүний цаана юу явж байна гэхээр үндсэндээ бол Монгол Улсын айл өрх болон орлоготой байх бодлого явж байгаа. Иргэдээ дэмжээд хашааных нь 0.7 га газарт нь 20квт-ынх нь эх үүсвэр хийх боломжийг нь олгочихъё л доо. Тэгээд би танд хэлсэн шүү дээ Байнгын хороон дээр. 190 мянган утаа үйлдвэрлэж байгаа яндан байна. 40 хэдэн мянга орчим эрчим хүчээр шийдчихсэн байсан, одоо хүнд байдалд орчихсон. Үнэ өсчихсөн. Үлдсэн 140 мянга дээрээ бодлого хэрэгжүүлье. Энэ газар болгоноо үнэ цэнтэй болгоё. Мөнгө олдог болгоё гээд би танд симуляц хийсэн тооцоог нь хүртэл хэлж өгсөн шүү дээ тухайн үед. Айл өрх болгондоо боломж олгоод одоо энэ банкнууд дээр байгаа 1 их наяд орчим эко зээл чинь хаашаа гарахаа мэдэхгүй хүлээгдээд байж байна гээд ийм юм руу бодлогынхоо ажлыг хиймээр байна.

Ялангуяа одоо энэ явуулах гэж байгаа Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий эд нар бол нарны сэргээгдэх эрчим хүчний энергийн төв. Тэнд бодлогоор энэ ажил руугаа л энэ зээл байвал оруулъя. Жавхлан сайд аа, Монгол Улс 3,5 сая иргэнтэй. Яг өнөөдрийн байдлаар 1 иргэн улсын хэмжээнд 38 саяын зээлтэй гэж тооцоо гарч байгаа. Эдийн засагч нар яриад байна. Дахиад ингээд зээлээ нэмээд байх юм уу. Магадгүй 2028 онд бид нар Их Хурлаасаа тардаг юм уу, буудаг юм уу, бүрэн эрхийн хугацаа дуусаад явахад энэ улс эх орныхоо төрж байгаа хүүхэд болгоныг 40, 50 саяын өртэй болгоод үлдээх юм уу. Менежментээ сайжруул л даа Чойжилсүрэн сайд аа. Та ажлаа бодлогын түвшинд сайн хийчих л дээ. Асуусан асуултад бүрэн хариулчхаад энэ дээрээ парламентынхаа зарчмыг мэтгэлцье л дээ. Би танаас 10 асуулт асуусан шүү дээ. Одоо хүртэл хариугаа авч чадахгүй. Яам дээр чинь очоод уулзалт хийж чадахгүй байна шүү дээ. Тэгээд баахан зээл, мөнгө авах, үрэх, тараах юм болохоор ингээд оруулаад ирдэг. Олъё бүтээе, энийгээ өшөө арвижуулъя, өгөөжийг нь хүртье гэсэн юмнуудыг дэмждэггүй. Одоо Монгол Улсад эрчим хүчний салбараас л өрх бүр орлого олох боломжтой байгаа шүү. Хууль нь ч тийм байгаа юм. Хуучин хуулийг нь бол хөндөөд хэрэггүй. Тэгээд тэр боломжуудыг нь олгочихъё л доо. Тэгэх юм бол 365 хоногт тооцоо хийгээд үзээрэй. Та 20квт-ыг өөрөө хэрэглээд, эрчим хүчний төвийн сүлжээнд нийлүүлэх юм бол одоогийн тооцоогоор бол сардаа бараг 500 орчим мянган төгрөг айл өрх болгон олох боломж байгаа шүү. Тэгээд энэ дээрээ бодлогоо хэрэгжүүлье л дээ. Дутуу байгаа эрчим хүчээ дотооддоо өөрсдөө үйлдвэрлэе л дээ. Энийг нь дэмжье л дээ бодлогоор. Тэгэх үү. Та нэг хариулчих. Тэгээд би тодруулъя. Тэгэхгүй бол танаас чинь ерөөсөө асуулт асуух гэхээр алга болоод, Жангабыл гишүүн рүү би 3, 4 удаа залгасан, таараад асуусан. Яаж байна, уулзах гэж байна уу, хэзээ яам дээр нь очих юм гээд ирдэггүй. Таныг утсаа авдаггүй гээд. Авахаараа 5 сарын 21 гэсэн. Одоо жил

ихтэй байна гээд дахиад хойшлуулж байна гээд байна. Үгүй ээ, тэгээд ийм байх юм бол ажил яаж явах юм. Тэгээд энэ дээрээ би ядаж танаас урьд нь асуусан 10 асуулт дээр энэ микрофон ашигласан дээрээ хариултаа авчихъя. Тэгж байгаад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Очирбат гишүүн ээ, энэ 3 минутын асуулт хариултын горимоор таны 10 асуултад би 3 минутад амжиж хариулахгүй гэдгээ хэлсэн. Улс төржиж шоудаад яах вэ. Үнэнээ бодитоороо ярь. Олон нийтэд таалагдах гэж худлаа янз бүрийн юм ярихаа больё. Таны яриад байгаа айл болгон 20квт-ын нарны панел суулгаад, илүүдлээ төвийн сүлжээнд нийлүүлье гэдэг ийм гоё юм ярихад гоё юм. Энийг чинь яг үнэнийг хэлэхэд биелүүлэхэд энэ системийн тогтвортой байдлыг үүсгэхэд техникийн хувьд бололцоогүй болчихоод байна. Тийм учраас би таныг манай яам дээр яваад очооч ээ. Бид нар Диспетчерийн үндэсний төв, бусад горимын тооцооллыг танд үзүүлье гэсэн юм. Харамсалтай нь сүүлийн өдрүүдэд энэ улс төрийн нөхцөл байдал үүсээд, та яриагүй. Жангабыл гишүүнд бид нар ямар ч байсан энэ яам дээр очих зав гаргаад, 3, 4 цаг болно. Тэр үед очъё гэдгийг Жангабыл гишүүнд би учирлаж хэлсэн байгаа. Энийг техникийн хувьд бололцоогүй. Ард түмэнд техникийн хувьд хэрэгжүүлэх бололцоогүй юмыг хийх гэж байна гэж янз бүрийн тийм гоё, ганган үгээр энэ ард түмнийг молигодохоо болимоор байна шүү дээ. Бодит байдалтайгаа эвлэрье.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Монгол Улсын нийт өр гэдэг дотор Засгийн газрын өр хувийн, хэвшлийн өр аль аль нь орно. Тэр дотор Оюутолгойн өр ч ордог. Энэ бүгдийг Монголын хүн амын иргэнд хувааж тооцох тийм аргачлал бол энэ маш буруу. Ийм аргачлал дэлхийд хэрэглэгддэг, судалгаанд хэрэглэгддэг тийм зүйл байхгүй. ДНБ болон бусад өөр төсвийн үзүүлэлтүүдтэй энийгээ харьцуулж судалгаагаа юмнуудтайгаа эрсдэлээ тооцдог юм байгаа юм. Монгол Улсын ДНБ-д харьцуулсан Засгийн газрын өр жишээ нь 2015 онд 90 хувь хүрчихсэн байсан. 90 хувь шүү. Өнгөрсөн жилийн жилийн эцсээр 41,8 хувь болж 2 дахин буурсан байгаа. Тэгэхээр гадаад өрийн менежмент бол сүүлийн 6 жилийн хугацаанд 3, 3 жилээр Улсын Их Хурлаас батлагдсан стратегийн хүрээнд маш амжилттай үр дүнтэй явж байгаа гэж хэлмээр байгаа юм. Харин цаашдаа бид гадаад зээлийн ашиглалтыг маш үр өгөөжтэй энэ боломжит .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Жавхлан сайдын тайлбарыг 2024 оны намраас хойш өчнөөн сонсож байгаа. Таны энэ тайлбарыг чинь бол бүр бүгд мэдэж байгаа шүү дээ. Чойжилсүрэн сайдын хэлдэг арга технологийг ч бүгд мэдэж байгаа. Тэгэхээр ажлаа л хийчихмээр байна л даа. Энэ чинь хувийн эрх ашгийн юм юу ч яриагүй шүү дээ. Ийм хууль, эрх зүйн орчин байгаад, энэ боломж нөхцөл нь байхад иргэддээ таныг Чойжилсүрэн сайд аа боломжийг нь олгочихъё гэж байгаа юм. Шал дэмий зээл гээд дахиж өр зээл нэмэхээ боль л доо. Үгүй ээ, та асар том компанийн захирал хүн шүү дээ. Компанийнхаа өр зээлийг яаж төлдөг юм та. Татвар төлөгч нарын мөнгө болохоор ингээд хайр найргүй зээл авъя гээд байдаг юм уу. Танай компани зээл чинь төлөгдөхөө болих юм бол банк зээлээ хаагаад, таны компани чинь дампуурна биз дээ. Үгүй ээ, зарчим нь тэр шүү дээ. Үгүй ээ тэр лүүгээ л явъя л даа. Эрүүл юм руугаа л явъя л даа. Тэгэхгүй тэгээд худлаа попорлоо гээд байх юм. Попорсон юм

байхгүй шүү дээ. Яг бодит үнэнээ л ярьж байна шүү дээ. Эрчим хүчний салбар чинь өнөөдөр блокт ороод хаагдчихсан байна Чойжилсүрэн сайд аа.

Түрүүн бас Цэнгүүн гишүүн асууж байсан. Хариулт дээр нь та ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүн ээ, янз бүрийн байдлаар маргаад яах вэ 2-уулаа. Энэ шугамыг барих уу, үгүй юу гэдэг шийдвэр Улсын Их Хурлын гишүүд, та бид нар гаргана. Энэ шугамыг барьснаар бид нар жишээлбэл жилдээ 140 орчим сая долларын цахилгаан эрчим хүчийг Оюутолгой төсөл Хятад Улсаас импортолж байна. Оюутолгой төслийг Монголын талаас бид нар цахилгаан эрчим хүчээр хангах хэрэгтэй байна. Энийг хангахын тулд Оюутолгой төсөл өөрөө 1 дүгээр зэргийн хэрэглэгч учраас 24 цаг ямар нэг байдлаар 1 мөч ч цахилгаангүй байх ийм бололцоогүй учраас доор хаяж 2 эх үүсвэрээс энэ Оюутолгой төслийг цахилгаан эрчим хүчээр хангах шаардлага үүснэ. Тийм учраас энэ зүүн талаас нь очих энэ шугамын хамгийн том төсөл байгаа юм. Төсвийн бололцоо байхгүй байгаа учраас зөвхөн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг эрчим хүчний салбарын дамжуулах, түгээх, хуваарилах байгууламжууд дээр бид нар авч хэрэглэж байгаа. Засаг дээр ийм л байр суурьтай байгаа.

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн дахин тодруулж асууя.

Г.Очирбат: Харин би ойлгоод байгаа юм л даа Чойжилсүрэн сайд аа. Тэгэхээр таны бодлого, менежмент чинь буруу байна. Бодлого чинь буруу байна гээд байгаа шүү дээ. Тархмал эх үүсвэрүүдээр шийдээд өгчихье. Аймаг болгон утаатай болчихсон шүү дээ. Улаанбаатар хот утаандаа 9, 10 сараас ингээд л явчихна. Тэгээд тархмал эх үүсвэрээр тэрийг нь шийдээд, тэр боломжуудыг нь нэе л дээ гэдэг саналыг л би танд хэлээд байгаа юм. Тэгээд тэр боломж нь байна. Ялангуяа тэр Германчуудтай, Германы технологийн дэвшил дэлхийд номер 1 гэж явдаг. Өнөөдөр сэргээгдэх эрчим хүчээр нийт эрчим хүчнийхээ 50 хувийг хангачихсан. 2030 он гэхэд 80 хувь болгоно гээд зорилт тавиад, тэрийгээ хэрэгжүүлээд явж байна. БНХАУ бүх нүүрснээсээ энэ бол нөгөө байгаль орчинд ээлгүй байна гэдгээрээ буцаад, сэргээгдэх эрчим хүч рүүгээ ороод, дахиад 2050 он гэхэд энэ чинь 100 хувь шууд сэргээгдэх эрчим хүчээрээ эрчим хүчнийхээ салбарыг авч явна гээд бодлогоо тодорхойлоод байна шүү дээ. Тэгээд бид нар тэрийгээ л хийчихье л дээ. Тэгээд тэрийг нь дахиад хийхдээ их давуу талтайгаар хийчихье л гэж байгаа шүү дээ. Иргэн болгондоо, өрх болгондоо .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүн ээ, яг таны энэ яриад байгаа юмыг чинь техникийн хувьд бид нар биелүүлэх бололцоогүй. Яг үнэнийг хэлье. Одоо Улаанбаатар хотод жишээлбэл 2 эх үүсвэрээс 2 тэжээлтэй нийт хэрэглэгчийн 95 хувь нь 1 тэжээлтэй. Энэ ЦДАШ хуваарилах байгууламжууд маань бараг 100, зарим газраа 104, 105 хувийн ачаалалтай болчихсон байна. Нэмэлт эх үүсвэрийг хувьсах эх үүсвэрийг бид нар дахиад сүлжээнд шингээх ийм чадвар алга байна.

Хэрвээ энийг сүлжээнд шингээх ийм шаардлага гарах юм бол магадгүй дамжуулах түгээх зардал 1квт цаг тутмаа 6 центээр дахиж өртөг нь нэмэгдчих гээд байгаа юм. Тэгэхээр ийм юмыг байна шүү дээ хөгжингүй орнууд дээр хийсэн өндөр

өртөгтэй юмыг бид нар яг ойрын хугацаанд бол бид нар хийж чадахгүй. Урд хормойгоороо хойд хормойгоо нөхөөд, дөнгөн данган орлого, зарлагыг тэнцүүлэх гэж байгаа нөхцөлд бол энэ худлаа. Таныг би юу дахиад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Энэ хэлэлцээрт 2025 оны 2 сарын 5-ны өдөр Сангийн сайд гарын үсэг зурсан юм байна. Хэлэлцээртэй холбоотой 5 асуулт байна.

1 дүгээрт гэрээний ерөнхий нөхцөл хаана байгаа юм бэ. Зээлийн хэлэлцээрийн зүйл 1.1.0.1-д энэхүү хэлэлцээрийн хавсралтад тодорхойлсон ерөнхий нөхцөл нь энэ хэлэлцээрийн салшгүй 1 хэсэг байна гээд заасан. Гэхдээ ерөнхий нөхцөлийн өөрчлөлт нь байгаад байдаг. Ерөнхий нөхцөл нь хавсралтаараа байхгүй байна. Гишүүдэд тараагдсан материалд ч тэр, D-parliament-д ч тэр. Энийг нэг тодруулж өгөөч.

2 дугаарт зээлдэгч энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүрэг дуусгавар болох огноо гээд хэлэлцээрийн зүйл 4.4.3-д байгаа юм. Гарын үсэг зурсан өдрөөс хойш 20 жил. Гэтэл үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хугацаа 2030 оноос хойш 25 жил. Сангийн сайд таны танилцуулж байгаа танилцуулгаар 30 жил. Санхүүжилт хаагдах хугацаа 2029 оны 12 сарын 31. Энэ ямар утга учиртай, цаг хугацааны хувьд ийм зөрүүтэй асуудлууд яваад байна вэ. Энийг нэг тодруулаад өгөөч.

3 дахь асуулт. Төсөл хэрэгжүүлэх нэгж гэж байгуулах юм байна. Эрчим хүчний яамны дэргэд байгуулах гэж байгаа юм байна. Эрдэнэс Монголд саяхан “Эрчис Монгол” гээд нэг компани байгуулагдсан байх аа. Эрчим хүчний бүх төслүүдийг хариуцаж байгаа компани гэж ойлгосон. Тэгээд тусдаа дахиад ийм нэгж байгуулагдаад явах юм уу. “Эрчис Монгол”-тойгоо ер нь яаж уялдах гэж байгаа юм бол. Төрийн өмчит компаниуд энэ төслүүд ер нь хоорондоо яаж уялдах юм бэ. Энэ дээр тодорхой хариулт авъя.

Та тодорхойлолт хэсгийнхээ 4-ийг хараад өгөөрэй. Байнгын хорооны дарга бас энэ дээр тодруулаад өгнө биз. Чойрын дэд станц гэж зээлдэгчийн Дундговь аймгийн Чойрт орших мөн нэртэй дэд станц байна гэхихсэн байгаа. Чойр ямар үндэслэлээр Дундговийн харьяанд оччихов. Энэ асуултууд дээр тодорхой хариулт аваад, дараа нь саналаа хэлье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ, өнөөдөр бол соёрхон батлуулахаар өнөөдөр бид нар хэлэлцэж байгаа шүү. Өмнө нь бол Их Хурал дээр танилцуулагдаад, гэрээний ерөнхий нөхцөл дэлгэрэнгүй байдлаар Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор 2025 оны 1 сарын 13-ны өдөр хэлэлцэгдээд дэмжигдсэн гэсэн үг. Тийм учраас өнөөдөр дахиж энэ дээр соёрхон батлах үед бол гэрээний ерөнхий нөхцөлүүд бол хавсаргадаггүй байгаа. Шаардлагатай бол танд өгчихье. 1 дүгээрт.

2 дугаарт тэр нөхцөлүүд дотор ерөөсөө л ийм л байгаа. Одоо ингээд соёрхон батлагдмагц гэрээгээ ашиглах эрх нь нээгдэнэ. Ингээд нээгдмэгц 5 жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Өөрөөр хэлбэл энэ зээлээ ашиглаж

дуусах ёстой энэ хугацаанд. Тэр хугацаа нь бол 2029 онд. 2029 оноос цаашаагаа бол 25 жилийн хугацаанд үндсэн зээлийнхээ төлбөр лүү ороод, төлөлт эхлээд явна гэсэн үг. Ингээд 5 дээр нэмэх нь 25 буюу нийтдээ 30 жилийн хугацаатай гэсэн үг.

Төслийн нэгж болон бусад асуудлаар сайд хариулах уу. Тэндээс хариулчих юм уу. Ажлын хэсгээс хариулчих уу. Тэр ерөнхий нөхцөлүүдийг Үүрийнтуяа гишүүнд одоо өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад нэмээд хариулъя. Энэ “Эрчис Монгол”-тойгоо яаж уялдах вэ гэхээр Засгийн газрын тогтоол гаргаад, 2025 оны 3 дугаар сард гарсан. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын 66 хувийг “Эрчис Монгол” компани, 34 хувийг Эрчим хүчний яаманд хариуцуулсан. Одоогийн байдлаар “Эрчис Монгол” компани маань ерөнхийдөө бол хүний нөөц эд нар бол бэлэн биш байна. Бид менежментийн түр аргацаагаад явж байгаа. Энэ менежментийн эрхийг шилжүүлж аваач ээ гэдэг ийм хүсэлт хэлэлцээрийг бол “Эрчис Монгол” компанид өгч байгаа. Энэ зээлийн хэлэлцээр бол “Эрчис Монгол” компанитай хамаагүй, тусдаа Засгийн газар өөрийнхөө нэрээр зээл авч байгаа учраас энийг Засгийн газрыг төлөөлөөд, төрийн захиргааны төв байгууллага нь Эрчим хүчний яам учраас манай яам энэ төслийг хэрэгжүүлээд явна. Энэ гэрээний төсөл дээр манай Сангийн яамны ажлын хэсэг орчуулгын алдаа гарсан уу.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индэр.

Л.Гантогтох: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Зээлийн гэрээний хавсралт хэсэг дээр байгаа тодорхойлолт дээр байгаа хэсэг дээр Говьсүмбэр аймгийн нэрийг Дундговь гэж андуурч бичигдсэн ийм алдаа байгаа. Энэ бол механик алдаа. Тэгээд энэ алдааг бол Дэлхийн банктай манайх яриад, энэ алдаагаа засаад, гэрээ соёрхон батлагдаад, төрийн мэдээлэл рүү хэвлэгдэхийн өмнө механик алдааг засварлаад оруулахаар тохирчихсон байгаа.

Зээлийн хугацааны хувьд бол сая Сангийн сайд хэлсэн. 25 жилийн хугацаанд эргэн төлөгдөх, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ийм нөхцөлтэй гэрээ байгаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн. Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Тэр 9,4 сая долларын асуудал байгаад байгаа шүү дээ. Энэ хуваарь 2-ын хэсэг 3-ын Б-1 дээр байгаад байгаа. 2024 оны 3 сарын 31-ний өдөр буюу түүнээс хойш хугацаанд ангилал 1-д хамаарах зөвшөөрөгдөх зардалд зориулж татан авсан 9,4 сая ам доллар гээд. Энэ өмнө нь хийгдчихсэн хэлэлцээр зурахаас өмнө авчихсан зүйл яриад байна уу. Ямар асуудал яригдаад байна. Энийг 1 дүгээрт тодруулъя. Тэгээд ер нь би ойлгож байгаа соёрхон батлагдахаар орж ирж байгаа гэдгийг ойлгож байгаа. Тэгээд ядаад энэ чинь бүхэл бүтэн аймгийн нэр андуурч тавьчаад, соёрхон батлахаасаа өмнө энийгээ засаад оруулдаггүй юм уу. Энэ чинь хуулийн төсөл бэлтгэгдээд орж ирж байна шүү дээ. Тэгээд Байнгын хороо дээр яригдахдаа ийм алдаа гарчихсан юм гэдгээ хэлээд, Байнгын хорооны дүгнэлтээр ч гэсэн засах барих нөхцөлийг нь оруулж болдоггүй юм уу. Эсвэл үнэхээр боломжгүй байдаг юм уу.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индрээс нэмж хариулъя.

Л.Гантогтох: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Гэрээний хавсралт дээр заачихсан байгаа. 47 сая ам.долларын дүнг энэхүү гэрээнд заасан төсөлд зориулан зарцуулна гэж заасан. 9,4 сая ам.доллар гэдэг бол 1 удаадаа татан авах гидравл буюу дисперсментийн нөгөө ашиглалтын дээд хэмжээг зааж өгч байгаа ийм хэмжээ байгаа. Тэгэхээр энэ бол ерөөсөө өмнө нь авч байгаа зээл биш. Энэ 47 сая ам.долларын зээлийн гэрээний хүрээнд 1 удаадаа татан авалт хийхдээ дээд тал нь 9.4 сая ам.доллар зарцуулна шүү гэсэн ийм хязгаар гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Тэр андуурсан асуудал дээрээ тайлбараа аль шатдаа яагаад засаагүй одоо хүртэл явчхаад байгаа юм.

Л.Гантогтох: Говьсүмбэр аймгийг Дундговь гэж андуурч бичсэн зүйл дээр бол өргөн баригдах хугацаанд зээлийн гэрээг зурагдсан буюу Дэлхийн банктай цахим системээр зурсан энэ зүйлийг бол Их Хуралд өргөн барьчихсан байгаа. Тэгэхээр энэхүү алдааг бол яг төрийн мэдээлэлд хэвлэгдэхээс нь өмнө засах бүрэн боломжтой. Албан ёсны орчуулга дээр бас засагдах бүрэн боломжтой ийм зүйл байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ чинь асуугаад байна шүү дээ. Улсын Их Хурлаар ороод эцэслэн батлагдаж байгаа зүйл дээр засагдаагүй байна. Тэгээд Улсын Их Хурлын шийдвэр гарчихсаны дараа та нар засах гээд байгаа юм уу. Юу хариулаад байна.

Л.Гантогтох: Ерөнхийдөө засагдахад бол бүрэн боломжтой. Дэлхийн банктай бид нар энэхүү алдаагаа засна гээд хоорондоо албан бичиг солилцчихсон байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дондогмаа дарга энэ дээр хариул даа. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ч.Дондогмаа: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль дээр бол зөвшилцөөд гарын үсэг зурчихсан 2 тал хоёулаа албан ёсны гарын үсгээ зурчихсан төсөл дээр ийм алдаа гарч ирсэн. Техникийн гэж хэлэхээр алдаа. Говьсүмбэр аймаг гэдгийг Дундговь гэж бичсэн ийм алдаа гарч ирсэн. Их Хурал бол Соёрхон батлах тухай хуулийн төслийг нь хэлэлцэж байгаа. Энд хавсаргаж орж ирсэн гэрээ дээр гарсан алдааг бол Засгийн газар гарын үсэг зурсан талтайгаа засах шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Тэгээд өнөөдөр Их Хурлын шийдвэр эцэслээд гарчихаар яах юм.

Ч.Дондогмаа: Хэлэлцээр соёрхон батлахаас өмнө энэ алдааг бол амжуулж засах ёстой.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр чинь бид эцэслэж, соёрхон баталж болохгүй нь байна шүү дээ. Тийм үү. Энэ чинь янз янзын түвшинд бас Их Хурлаар ороод шийдэгдчихсэнийг араас нь үг, үсэг битгий хэл цэг, таслалыг нь ч хүртэл өөрчлөх ямар ч боломжгүй болдог шүү дээ. Тийм үү. Тэгээд яагаад энэ дутуу юм орж ирээд ингээд яваад байгаа юм. Үүрийнтуяа гишүүн зөв олж харсан л байна л даа. Ийм

алдаа байж болохгүй л дээ. Бүхэл бүтэн аймгийн нэрийг сольж тавьчихаад тэгээд ингээд явж байдаг. Тэгээд хэрвээ цаад талаас чинь хариу ирэхгүй бол хэдүүлээ яах юм. Өөрчлөхгүй бол яах юм. Улсын Их Хуралд ороод соёрхон баталчихсан байж байдаг ийм л асуудал үүснэ. Гэхдээ зүгээр батлахаас татгалзаж байгаадаа биш. Ийм алдаатай зүйл баталж болохгүй гэдэг дээр л асуудал яригдаж байгаа шүү.

Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Хэд хэдэн асуулт байгаа. Бас төстэй. Сая Үүрийнтуяа гишүүний асуулттай ер нь бол төстэй. Тэгээд яах вэ, зүгээр сая энэ ирүүлсэн хэлэлцээрийн Монгол орчуулга бол ерөөсөө хангалтгүй байна. Монгол Улсын Сангийн яам албан ёсны орчуулга гэсэн тамгатай мөртөө сая тэр 9,4 сая ам.доллараос хэтрэхгүй хэмжээний төлбөрийг гэдэг орчуулга бол яг Англитайгаа ерөөсөө тулахгүй байна лээ. Тийм учраас авчихсан мөнгийг буцааж өгөх гээд байгаа юм шиг ойлгогдоод байгаа учраас энийгээ хүртэл сайн засаж байх хэрэгтэй. Энэ дээр бол анхааруулах хэрэгтэй байна. Асуулт бол зээлийн эргэн төлөлтийн хувь дээр байгаа юм. Хүү дээр байгаа юм. Тэгээд хэлэлцээрт зааснаар бол тэр SOFR гээд secured overnight financing rate гэдгийг ашиглаад, хүүгийн түвшнийг тогтооно гэсэн байгаа юм. Тэгээд энэ дээр, мэдээлэл олон нийтэд өгөх үүднээс олон улсын түвшинд ер нь ямар түвшний хүү тооцогддог юм бэ. Нэг лайбер гээд нэг төрлийн хүү бас яригдаад байдаг. Тэгээд судлаад үзэхээр болохоор SOFR гээд энэ хэлэлцээр дээр баримтлах гэж байгаа энэ хүүг өдөр бүр зарладаг юм билээ. Тэгэхээр тийм тогтмол хүү бол байдаггүй юм байна. Тэгэхээр энэ хэлэлцээр дээрээ юу гэдэг юм сүүлийн 30 хоногийнх нь дунджаар авна гэх байсан уу, сүүлийн 90 хоногийн дунджаар гэх байсан уу, тиймэрхүү байдлаар та хэд маань ярилцаж үзсэн юм болов уу. Ер нь яаж яг хүүгээ тооцоолох вэ гэсэн эхний асуулт байна.

2 дугаарх нь болохоор үйлчилгээний шимтгэл, зээлийн дүнгийн 0.25 хувь байна гээд биччихсэн байгаа юм. Тэгээд энэ дээр сонирхож асууж байгаа зүйл нь 1 удаагийн шимтгэл байх юм уу. Эсвэл давтамжтай байдлаар шимтгэлийг бид нар жил болгон авах зээлийн хэмжээгээрээ төлөх үү. Мөн хэлэлцээрийн хуваарь 2-т зээлдэгч буюу манай талд бичигдсэн олон үүргүүд байгаа юм. Жилийн ажлын төлөвлөгөөгөө бид нар гаргах ёстой юм байна 12 сарын 10 болгонд. Тэгээд төслийнхөө хэрэгжилтийг сайн бичиж өгөх ёстой юм байна л даа. Тэгээд байгаль орчин, нийгмийн стандартууд гэсэн хэсэгт бас тайлан гаргах үүрэг хүлээжээ. Бас хэлэлцээр явагдаж дундаа орж явах үед нь дунд хугацааны үнэлгээ бас хийлгэх юм байна. Тэгэхдээ энэ бүх үүргүүдээ, хийх ёстой ажлаа зээлдэгч нь хийхгүй тохиолдолд яг ямар хариуцлага үүрэх вэ, хүлээх вэ гэдэг тийм хариуцлагын хэсэг байдаггүй. Яг ямар эрх зүйн орчинд хариуцлага тооцох вэ. Энийг бас нэмж тусгах ёстой байсан юм биш үү. Эдгээрт хариулт авъя.

Д.Амарбаясгалан: За байз ингэдэг юм уу. Энэ сая англи эхийг нь харл. Англи эх дээрээ бас энэ чинь Дундговь гэхихсэн аймгийн нэртэй ирчихсэн зүйл юм байна шүү дээ. Өчигдөр байнгын хороо дээр яригдаад, орчуулга дээр алдаа гарсан байна. Техникийн алдаа гэж хэлээд, өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхээс өмнө засна гэсэн хариултыг өгсөн мөртөө засагдаагүй орж ирсэн байна. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэхийг ингээд зогсоочихъё. Дэлхийн банктайгаа энэ гарсан зөрүүтэй байдлаа арилгаад, техникийнхээ алдаа дутагдлыг зассаных нь дараа Улсын Их Хурлын гишүүд одоо нэр ирчихсэн байж байгаа гишүүд үргэлжлүүлэн асуугаад, хариултаа аваад, үгээ хэлээд явах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгэх үү гишүүд ээ. Болдын Уянга гишүүний асуултад хариулчихаад, тэгээд бусад

гишүүдийн асуулт, үгийг засагдсаны дараа үргэлжлүүлэхдээ аваад явчихъя гэж бодож байна. Уянга гишүүний асуултад хариулъя. 3 дугаар индэр. Дондогмаа дарга 3 дугаар индрээс хариулт өгүүлье. Уянга гишүүний асуултад.

Л.Гантогтох: Уянга гишүүний асуултад хариулъя. Зээлийн гэрээн дээр 2 төрлийн шимтгэл байгаа. 1 нь бол front and fee буюу зээл авахад авдаг 1 удаагийн шимтгэл. Энэ бол 0,25 хувь буюу зээлийн нийт дүнгээс бодох юм бол 117 мянган ам.долларын 1 удаагийн шимтгэл төлнө.

Дараагийн шимтгэл нь commitment fee буюу 0,25 хувь. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан хураамжийн шимтгэл байгаа. Энэ шимтгэлийг бол 2029 он хүртэл буюу гресперодын үед бол нөхөн төлөхгүй. 2029 оноос хойш хэрвээ зээлийг ашиглагдаагүй үлдэгдэл байх юм бол тэрхүү шимтгэл дээр хүү төлөхөөр ийм нөхцөлтэй байгаа.

SOFR хүүгийн тухайд бол ерөнхийдөө Лайбер хүү бол 2022 оноос өмнө олон улсын энэ гэрээний тухай хуулийн дагуу олон улс дээр байгаа ам.долларын хүүг тогтоодог ийм жишиг хүү байсан. Лайбер хүү бол 2022 оноос эхлээд албан ёсоор халагдаад, түүний оронд SOFR буюу АНУ-ын холбооны нөөцийн банкнаас зарладаг энэ хүү дээр бол жишиг хүү тогтдог болсон. Тэгэхээр энэ хүү бол ингээд өдөр болгон тогтмол шинэчлэгддэг. Ерөнхийдөө энэ зээлийн гэрээ маань хувьсах хүүтэй гэсэн үг. Тэгэхээр энэ хувьсах хүүгийн дагуу SOFR хүү өөрчлөгдөх болгонд манай хагас жилд төлж байгаа хүүгийн хэмжээ SOFR хүүгийн хувьсах дүнгээр өөрчлөгдөх ийм нөхцөлтэй гэсэн үг. Тэгэхээр одоогийн байдлаар бол яг өнөөдрийн байдлаар бол SOFR хүү 4,3 хувь, зээлийн хүү маань 1,44 хувийн нэмэгдэлтэй гэхээр ойролцоогоор 5,7 хувийн хүүгээр дараагийн хагас жилд хүү төлнө. Тэрний дараагийн хагас жилд бол SOFR хүү хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч төлөгдөх хүүгийн төлбөр маань бас дагаж өөрчлөгдөх ийм нөхцөлтэй. SOFR хүү бол ерөнхийдөө 2023, 2024 онд бол ерөнхийдөө оргил үедээ хүрсэн. Одоо бол буурах ийм чиг хандлагатай байгаа. Ерөнхийдөө олон улсын байгууллагуудаас гаргасан төсөөллийн хувьд ч гэсэн SOFR хүү ерөнхийдөө буурах ийм төсөөлөлтэй байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө энэ зээл маань хувьсах хүүтэй. Хувьсах хүүгийнхээ дагуу зээлийн хүү төлөгдөөд явна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: SOFR хүүг илүү дээр гээд бас үздэг юм билээ. Тэр дээр дэлгэрэнгүй хариулт авлаа. Нөгөө хариуцлага дээр нь хариулаад өгөөч. Одоо бид нар үүрэг хүлээж байгаа зээлдэгчийн хүлээж байгаа энэ тайлангууд, энэ бүх стандарт, байгаль орчин, нийгмийн стандартуудыг хангаж ажиллах ёстой. Энийгээ бас тайлан гаргах ёстой. Энэ бүгдийгээ хэрвээ хийхгүй тохиолдолд ямар хариуцлага үүрэх талаар хэлэлцээрт байхгүй байгаа. Тэгэхээр энэ дээр та хэд маань тайлбар хэлэх хэрэгтэй байгаа юм.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индрээс нэмж тайлбарлая.

Л.Гантогтох: Уянга гишүүний асуултад хариулъя. Зээлдэгчийн хүлээх үүргийг бол зээлийн гэрээ дээр заасан байгаа. Хариуцлагын хувьд бол төслийн хэрэгжилтийн хувьд бол хүлээх хариуцлага, тухайн нөхцөл биелэгдээгүй бол яах вэ гэдэг энэ зүйлүүдийг бол төслийн баримт бичиг гэж бас Эрчим хүчний яам болон

Дэлхийн банк хоорондоо зурсан төслийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг ийм зохицуулалттай гарын авлага байгаа. Тэгээд тэрхүү гарын авлага дээр бол ерөнхийдөө зээлийн нөхцөлүүдийг зээлдэгчийн хүлээсэн үүргүүд ийм ийм байх ёстой. Тэрхүү хүлээсэн үүргүүдийг тухайн үед Дэлхийн банк болон Эрчим хүчний яам хоорондоо ингэж зохицуулна гэдэг нарийвчилсан заалтууд орсон байдаг. Мөн Дэлхийн банкны general condition гээд Үүрийнтуяа гишүүний асуусан энэ general conditions гэдэг энэ нөхцөл дээр бас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргүүдээ хангалттай биелүүлээгүй тохиолдолд ямар ямар нөхцөл байх вэ гэдгийг general condition дээр бол зааж өгсөн байдаг.

Д.Амарбаясгалан: Ингээд хэлэлцэж байгаа асуудал дээр техникийн алдаа гарсан, илэрхий алдаа гарсан учраас Улсын Их Хурал үүнийг эцэслэн шийдвэрлэж санал хураах боломж бол байхгүй. Тийм учраас энэ техникийнхээ алдааг засаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан ёсоор бичиг ирсний дараа Улсын Их Хурал уг асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

15.09 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 сарын 23, 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Тус байнгын хороо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж, хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хуулийн төсөл дэх нэр томъёог Эрүүгийн хуулийн бусад зүйл, хэсэг дэх нэр, томъёотой жигдлэх болон зарим найруулгын саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь дахин санал хураах нь зүйтэй гэж үзсэн тул төслийн 1 дүгээр зүйл буюу 20.18, 20.19 дүгээр зүйлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн

42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 нь дэмжсэн болно.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллын жигдлэх, хууль зүйн техникийн засваруудыг хийж, хуулийн төслүүдийн эцсийн хувилбар болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт, Золбоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт, Батболд Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга, Лувсан-Очир Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Тайван Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Гантулга дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, Тэрбиш Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна. Алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Ажлын хэсэгт энэ өдрийн мэнд хүргэе. Зөвшөөрлийн тухай хуулийг бол зарчмын хувьд дэмжиж байгаага илэрхийлмээр байна. Тэгээд өнгөрсөн хугацаанд хохирлын хэмжээг тогтоосон тоо баримт байдаг уу. Тэр тоо баримтыг жишээгээр энэ олон нийтэд ил тод болгосон тэр баримтууд байдаг уу гэдэг дээр асууя.

Дараагийнх нь зүйл техникийн шийдлийн хувьд VPN бусад шинэлэг, энэ хуулийн гадуур үйл ажиллагаагаа явуулах тийм техникийн боломж бололцоо байдаг уу гэдэг дээр нэмж тодруулж асуух гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх үү. Энхтайван 4 дүгээр индэр.

Г.Энхтайван: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Сүүлийн жилүүдэд крипто валюттай холбоотой Монгол Улсаас гарч байгаа гадаад гүйлгээний урсгал

бол нэмэгдээд байгаа. Нэгдсэн байдлаар тооцох юм бол гадаад гүйлгээний тайлангаас харах юм бол Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн крипто валютын нийт гүйлгээ 2021 онд 120 сая доллар, 2022 онд 198 сая доллар, 2023 онд 430 сая доллар, 2024 онд 578 сая доллар буюу өнгөрсөн 4 жилийн хугацаанд 1 тэрбум 325 сая америк долларыг бол гадагшаа шилжүүлсэн байгаа. Энэ бүгдээрээ бол энэ мөнгө гараад явчихсан гэсэн үг. Яагаад гэхээр тухайн цахим болон мөрийтэй тоглож байгаа этгээдүүд мөнгөө өөрийнхөө дансыг цэнэглээд хожсон бол тухайн дансанд нь гарахгүй байж байна гэсэн үг. Энэ бол яг бүрэн мөнгө нь бол манай улсын банкны системээс нутаг дэвсгэрээс бүрэн гарсан гэсэн үг. Тэр гарсан гадаад урсгалыг авч үзэх юм бол 55 хувийг нь бол Лихтенштейн, 26 хувийг нь АНУ, 16 хувийг нь бол Сингапур Улс руу гаргасан байгаад байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Энэ хохирол нь тогтоогдсон байна гээд. Тэгээд би тодруулаад байгаа нь хуулиа бид нар баталчихлаа. Чадах чинээгээрээ мэргэжлийн хүмүүс нь ажиллаад баталчихлаа гэхэд шинэ технологи нэвтрээд, жишээлбэл энэ төрлийн бизнес эрхэлж байсан хүмүүс дараагийн шатны тийм арга, аргачлал технологи ашиглаад дахиад энэ үйл ажиллагаа сэргэх эрсдэл байгаа юу. Тэгээд мөн адил энэ хохирсон асуудал дээр ямар нэгэн шийдэл гарц эргүүлэх, жишээгээр нөгөө хууль бус гүйлгээг эргүүлэн татах бололцоо байдаг уу. Тэр судалгаа байдаг уу л гэж асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. 4 дүгээр индэр.

Г.Энхтайван: Тухайн иргэн өөрөө өөрийн банкны картыг ашиглаад, тухайн өөрийн банкны карт болон цахим хэтэвч буюу valet-ийг ашиглаад энэ гүйлгээг бол өөрийн санамсаргүй байдлаас биш, өөрөө зорилготойгоор бол хийсэн гэж үздэг. Тэгэхээр энэ дээр тухайн хүн өөрөө юу гэдэг юм ямар нэгэн байдлаар өөрийн санамсаргүй болгоомжгүйгээс мөнгөө алдаагүй гэж үзэж байгаа тохиолдолд бол энийг бол буцаахад бол хүндрэлтэй. Хэрвээ үнэхээр цахим залилан болон бусад эрүүгийн гэмт хэрэгт холбоотойгоор эмзэг мэдээллээ алдаад, мөнгөө өөрийнхөө картаас алдсан тийм тохиолдлууд байх юм бол энэ дээр бол эргүүлэн авчрахад хууль, эрх зүйн хувьд боломжтой байгаа.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Нэмж хариулт өгөх үү. За 4 дүгээр индрээс.

Т.Батболд: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Харилцаа холбооны зохицуулах хороо Батболд. Технологийн хувьд бол үндсэн 3 арга байгаа.

1 дүгээрт бол IP хаяг болон домэйн нэрээр интернэтийн үйлчилгээ эрхлэгч үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд хязгаарлах,

2 дугаарт танин баталгаажуулах, данс цэнэглэлт хийхэд 1 удаагийн ATP SMS кодыг бол үүрэн телефон операторын сүлжээнд бол хязгаарлалтуудыг хийнэ. Мөн татаж авах боломжуудыг бол Монгол Улсаас хандах хандалтын домэйн нэрээр бол хязгаарлах арга хэмжээ авах бүрэн боломжтой.

VPN технологийн хувьд бол яг VPN технологийг ашиглаад хязгаарлалт хийх технологийн боломж бол одоогоор байхгүй байна.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Сая асуух гэж байсан юмтай нэлээн хариулт нь гарчихлаа. Ер нь 2 зүйл анхааруулж хэлмээр байгаа юм.

1 дүгээрт одоо бид нар хуулиа гаргахаар яаж хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал байгаа. Тэгээд та бүхэн бас хуулийн төсөл дээр ажиллаж байхдаа яаралтай арга хэмжээ авах ёстой гээд тодорхой сайтуудыг хаалаа гээд мэдээлж байсан. Би дөнгөж сая ороод үзэхэд бүгдээрээ нээлттэй л болчихсон байна л даа. Тэгээд тодорхой яг арга хэмжээ авлаа гээд тэр нь 2, 3 7 хоногийн дараа болохоор залуучууд томоохон сайтууд нь хаалттай хэвээрээ байгаа боловч яг нөгөө бүр залилангийн шинж чанартай, жинхэнээсээ спорт гэхээсээ илүү мөрийтэй покер юунууд нь бол нээлттэй, тэрүүгээр нь хүмүүс ороод байна шүү дээ гэдэг юм хэлсэн. Тэгэхээр энэ технологийн хувьд энийгээ та бүхэн маань яаж хориглож, хамгийн боломжит байдлаараа хориглоод, хэр үр дүн гаргана гэж үзэж байгаа вэ. Энэ дээрээ бас цаашдаа хуулийг хэрэгжүүлэхдээ ч гэсэн анхаараасай гэж хүсэж байна.

2 дугаарт бас хуулиа боловсруулж орж ирсэн ажлын хэсэгт хандаж, ер нь дараа дараагийн хууль дээр ажиллахдаа хууль зүйн техник талаас нь бас маш сайн харахгүй бол ер нь хуулиа яаралтайгаар оруулж ирсэн нь бол маш зөв алхам байсан. Энэ дээр бол талархалтай байгаа. Гэхдээ хууль зүйн техник чинь буруу байснаас болоод Хууль зүйн байнгын хороо дээр ажлын хэсэг гараад, асуудал байна, энийг яах вэ гэдэг юмнаас болоод энэ хууль маань гарахгүй нэлээн удсан. Тэгээд энэ хууль зүйн техник чинь ийм байна гээд ярихаар Улсын Их Хурал лоббинд автчихсан ч юм шиг, хэн нэг нь ингээд байгаа ч юм шиг, удааж байгаа ч юм шиг ийм нөхцөл байдал руу түлхэж болохгүй. Тэгэхээр анхнаасаа хуулиа яаралтайгаар оруулж ирэхдээ энэ талуудыгаа маш сайн бодож орж ирэхгүй бол хэн хэнийгээ эвгүй байдалд оруулах ийм нөхцөл байгаа шүү. Тэгээд энийг бас бодитойгоор бид нар хэлж байх ёстой. Тэгэхгүй бол ингээд нэг хэн нэгний лобби ч юм шиг, далд ч юм шиг дандаа хардлагууд дунд Улсын Их Хурал бол энэ чинь ажлаа хийгээд л явж байгаа хүмүүс шүү дээ. Хууль зүйн хувьд, бид нарын хувьд юу нь зөв байна гэдгээ хараад явж байгаа болохоор энэ дээр бас дараа дараагийн нөхцөл байдалд анхаараасай гэж хүсэж байна. Тэгээд асуулт гэхээсээ илүү хэрэгжилт дээр анхаараарай. Ялангуяа тэр жижиг жижиг нэлээн залилангийн шинж чанартай сайтууд дээр үнэхээр хаах арга хэмжээгээ илүү анхаарч, тогтмол ажиллагаанууд хийгээсэй гэж хүсэж байна.

2 дугаарт нь дараа дараагийн хуульдаа хууль зүйн техникийн анхаарч, энийгээ үнэхээр алдаатай оруулсан бол энийгээ бас хүлээн зөвшөөрөөд, хамтарч ажиллах тал дээр бас ажиллаж байгаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 4 гишүүний дараа санал хураалт явагдах нь байна. Үг байхгүй. Өмнөх “Эрчим хүч 3” төслийн санал хураалтыг хойшлуулсан байгаа. Засгийн газраас албан ёсоор техникийнхээ алдааг засаж залруулах бичиг ирсний дараа санал хураалт явуулна гэдгээр хойшлуулсан байгаа.

Одоо Зөвшөөрлийн тухай хуулийн асуудлаар зарчмын зөрүүтэй 2 санал хураалт явуулна. Санал хураалтын дараа Эдийн засгийн байнгын хороонд эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэх чиглэл өгөх учраас өнөөдөр санал хураалт явуулна. Гишүүдийг танхимд цуглахыг урьж байна. Ганбат гишүүн асуулт асууна. Алга байна. Чинбатын Ундрам гишүүн Алга байна. Батын Батбаатар гишүүн. Алга байна. Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн. Алга байна. Тэгээд гишүүд урьдчилаад өмнөх өдрийн 16 цагаас өмнө нэрээ ирүүлчихдэг. Тэгээд яг асуулт асуух цаг дээрээ бас байхгүй таараад байх шиг байна. Урьдчилаад сайн сануулж хэлж байхгүй бол.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Гишүүд танхим цуглая. Санал хураалтад бэлтгэе. Хурууныхаа хээг уншуулъя. Гишүүдийг дуудъя. Гишүүд хурууныхаа хээг уншуулж, санал хураалтдаа бэлэн байдалд оръё. Уншуулаагүй гишүүд нь уншуулъя.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулахаас өмнө ирц бүртгэлийн 1 санал хураалт явуулъя. Санал хураалт. 56 гишүүн, 57 гишүүн байна. Гишүүд орж ирж байгаа юм байна. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.18 дугаар зүйлийн гарчгийн “тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “тоглоом зохион байгуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 56 гишүүн буюу 51,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 20.19 дүгээр зүйлийн “зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд” гэснийг “зохион байгуулахад” гэж, “ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн” гэснийг “ашиглуулсан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 58 гишүүн буюу 53,7 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.30 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ